



ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН
15 ЖИЛИЙН ОЙД ЗОРИУЛАВ

ХӨГЖИЛ ДЭВШЛИЙН 15 ЖИЛ

УЛААНБААТАР ХОТ
2019 он

ХӨГЖИЛ ДЭВШЛИЙН 15 ЖИЛ

Эмхэтгэн бэлтгэсэн:

Ахлах дэслэгч Ш.Анхтуяа

Хянан тохиолдуулсан:

Бригадын генерал Г.Ариунбуян

Ажлын хэсэг:

Доктор Ph.d, хошууч генерал П.Даш
Бэлтгэл комиссар Д.Хишигбаатар
Доктор Ph.d, бэлтгэл хурандаа П.Дамдин
Бэлтгэл хурандаа П.Батаахүү
Хурандаа Д.Батсайхан
Хурандаа Г.Бат-Эрдэнэ
Дэд хурандаа Б.Дуламсүрэн
Дэд хурандаа Д.Сэржмядаг
Дэслэгч О.Цэнд-Аюуш

Хэвлэлийн эх бэлтгэсэн:

Ахлах дэслэгч Д.Отгонболд

Японы Засгийн газрын "Ядуурлыг бууруулах Япон сан",
Азийн хөгжлийн банкны "Зуд болон ой, хээрийн түймэртэй тэмцэх олон нийтийн
чадавхыг бэхжүүлэх GRANT9187-MON" төслөөс санхүүжүүлэв.

ISBN:

ГАРЧИГ

ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГА БАЙГУУЛАГДАХ УГТВАР НӨХЦӨЛ БҮРЭЛДСЭН НЬ	9
1 ДҮГЭЭР БҮЛЭГ Онцгой байдлын байгууллагын үүсэл, хөгжил	12
2 ДУГААР БҮЛЭГ Гамшгаас хамгаалах эрх зүйн орчин ба бодлого стратеги	32
3 ДУГААР БҮЛЭГ Онцгой байдлын байгууллагын чадавхын өсөлт	50
4 ДҮГЭЭР БҮЛЭГ Гамшгийн нөхцөл байдал, гамшгаас хамгаалах үйл ажиллагаа	78
5 ДУГААР БҮЛЭГ Хүмүүнлэгийн тусламж, сэргээн босгох ажиллагаа	98
6 ДУГААР БҮЛЭГ Олон талт хамтын ажиллагаа	110
7 ДУГААР БҮЛЭГ Сургалт, эрдэм шинжилгээ, инновацийн үйл ажиллагаа	134
8 ДУГААР БҮЛЭГ Бидний бахархал	168
9 ДҮГЭЭР БҮЛЭГ Гэрэл зураг түүх өгүүлнэ	184
ХАВСРАЛТ Он цагийн хэлхээс	306



Монгол Улсад дэлхийн жишигт нийцсэн орчин үеийн Онцгой байдлын алба үүсэн байгуулагдсаны 15 жилийн ойг тохиолдуулан эр зориг, авхаалж самбаа, эх оронч үзлийн шалгуур болсон нэр хүндтэй, өндөр хариуцлагатай, үлэмж эрсдэлтэй энэхүү албанд бие сэтгэлээ зориулж, амь насаа үл хайрлан зүтгэж ирсэн үе үеийн офицерууд, аврагч, гал сөнөөгчид, энэ байгууллагын тулгын чулууг тавилцсан ахмадууд, тэдний гэр бүл, үр хүүхдүүд, дэмжин тусалдаг иргэд, байгууллага, хамт олонд чин сэтгэлийн халуун дотно мэндчилгээ дэвшүүлж, эрүүл энх аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Түүхийн 15 жилийн энэ хугацаанд тус албаны удирдлагын тогтолцоо, хууль эрх зүйн орчин тогтвортой бүрэлдэж, бие бүрэлдэхүүний ур чадвар, техник, тоног төхөөрөмжийн хангалт, хүчин чадал нэмэгдэн албаны чадавх эрс дээшилж, Монгол Улсад орчин цагийн дэлхийн жишигт нийцсэн хүчирхэг алба болон хөгжиж ирлээ.

Онцгой байдлын байгууллага өнөөдөр ард түмний хайртай, итгэлт алба болсныг хараад тухайн албаны суурийг тавилцаж, гал голомтыг бадраалцаж Монгол Улсын сайд, Шадар сайдын хувиар гурвантаа удирдан ажилласны хувьд үргэлж бахархаж явдаг юм.

Миний бие 2004 онд анх Онцгой байдлын асуудал эрхэлсэн Монгол Улсын сайдаар томилогдон тухайн үед дөрвөн хуульд өөрчлөлт оруулж, 67 удаагийн Засгийн газрын тогтоол гаргуулан Онцгой байдлын албаны хууль, эрх зүйн орчинг бүрдүүлэх, алба хаагчдын цол хэргэм, хувцас хэрэгсэл, нийгмийн баталгааг хангасан тодорхой арга хэмжээг авахад анхааран ажиллаж байлаа.

Онцгой байдлын байгууллагыг өнөөдрийн түвшинд хүргэхэд тухайн үеийн төсвийн боломжоор тооцоолж үзэхэд 100 гаруй жилийн хугацаа шаардагдахаар дүр зураг харагдаж байсан үе саяхан мэт байна. Энэхүү нөр их ажлыг та бүхэн 15 жилийн дотор хийж гүйцэтгэжээ.

Онцгой байдлын байгууллагын хөгжил дэвшлийн энэ цаг үеүүдэд албыг бэхжүүлэх, чадавхыг сайжруулахад тус салбарыг хариуцан ажиллаж байсан үе, үеийн сайд, дарга нарын хүчин чармайлт их байсан гэдгийг дурдах хэрэгтэй.

“Хэнд хамгийн их итгэдэг вэ” гэдэг асуултад “Хамт үүрэг гүйцэтгэж яваа нөхөртөө хамгийн их итгэдэг дээ” гэсэн эгэл ахлагчийн үг өдийг хүртэл миний сэтгэл зүрхэнд хадгалагдаж байдаг юм.

Миний бие Монгол Улсын Ерөнхий сайдын хувьд, иргэн хүний хувьд ч ажилдаа халширч шантарсан нэг ч үгийг аврагчдын амнаас сонсч байсангүй ээ. Албаараа, ажил мэргэжлээрээ омогшин бахархсан, эрэлхэг зоригт эрхэм үйлсээрээ үлгэрлэн манлайлагч эх орны хөвгүүдтэй энэ цаг үед мөр зэрэгцэн ажиллаж байгаадаа туйлын бахдалтай байна.

Монгол Улсын тогтвортой хөгжил, хүн амын аюулгүй байдлыг хангах үйлсдээ өндөр амжилт гаргаж, эх орон, ард түмнийхээ өмнө хүлээсэн амаргүй бөгөөд хүндтэй үүргээ чин шударгаар биелүүлж байгаад Монгол Улсын Ерөнхий сайдын хувиар та бүхэндээ талархаж байгаагаа илэрхийлэхийн зэрэгцээ Монголын төр засаг, ард түмэн та бүхнээр бахархаж байдаг гэдгийг уламжлахад таатай байна.

Эх орон минь аюул, осолгүй амар тайван байж, Онцгой байдлын байгууллагын сүлд хийморь мандан бадарч байх болтугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

У.ХҮРЭЛСҮХ

Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлыг хангах, эх орон, байгаль дэлхийгээ болзошгүй аюул, ослоос аврах, иргэдийн эрүүл мэнд, амь нас, монгол хүний үнэт зүйлийг хадгалан хамгаалах чухал, хүндтэй, хариуцлагатай албыг гүйцэтгэдэг Онцгой байдлын байгууллагын эрхэм генерал, офицер, ахлагч, нийт бие бүрэлдэхүүнд Онцгой байдлын байгууллага үүсч байгуулагдсаны түүхт 15 жилийн ойн мэндийг дэвшүүлье.

Хүний амьдралтай харьцуулахад 15 жил богино хугацаа хэдий ч та бид хамтран Онцгой байдлын байгууллагыг бэхжүүлэх, чадавхжуулах талаар олон чухал арга хэмжээг хэрэгжүүлсний үрээр иргэдээ авран хамгаалах, аюулгүй, амар тайван амьдруулах төрийн эрхэм үүргээ нэр төртэйгээр биелүүлж ирснийг онцлон дурдахад таатай байна.

Онцгой байдлын байгууллага бол төр, ард түмнийхээ өмнө гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлагын хувьд Монгол Улсын төрийн байгууллагуудаас байгуулсан гавьяа, үзүүлсэн амжилт, хийж бүтээсэн ажил, үйлсээрээ ямагт тэргүүн шугаманд явдаг №1 агентлаг гэж Шадар сайдын хувьд дүгнэдэг.

Олон улсын түвшинд ч бидний хэрэгжүүлж, хийж байгаа арга хэмжээ, менежментийг өндрөөр үнэлж, туршлага судалж, хамтран ажиллах саналаа ирүүлсээр байна. Тийм ч учраас НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах газартай хамтран дэлхийн 60 гаруй орны 3000 шахам төлөөлөл оролцдог Гамшгийн эрсдэлийг бууруулах Азийн сайд нарын II хуралдааныг Улаанбаатар хотноо 2018 онд амжилттай зохион байгуулсан.

Онцгой байдлын байгууллага өдрөөс өдөрт өргөжин тэлж, үүрэг хариуцлага нэмэгдэж газрын гүнд, гадарга дээр, ууланд, агаарт, усны мандалд, усны гүнд ажиллаж, аврагч, гал сөнөөгчид та бүхний хүрч очиж үүрэг гүйцэтгэдэггүй орон зай, газар гэж үгүй болжээ.

Монгол Улсын Шадар сайдын хувьд Отгонтэнгэр ууланд болсон Уулчдын осол, Төв аймгийн Заамар суманд болсон Уурхайн осол, Дорноговь аймагт болсон галт тэрэгний осол гээд монгол улсын нутаг дэвсгэрт болсон томоохон осол, гамшгийн голомтод ажиллахдаа аврагчдынхаа мэргэжлийн ур чадвар, эр зоригоор үнэхээр бахархах сэтгэл төрж байсан.

Онцгой байдлын байгууллагаас энэ хугацаанд Ардын багш нэг, Үйлчилгээний гавьяат ажилтан зургаа төрөн гарсан. Түүний дотор жирийн аврагчдаас анхны залуу гавьяат төрөн гарсанд ард түмэн нүдээ олсон шагнал гэж бахдан хүндэтгэлтэйгээр хүлээж авсан нь Онцгой байдлын байгууллага, аврагчдын ажил, үйлсийг ард түмэн өндрөөр үнэлдэгийн том жишээ юм.

Цаашид гамшгийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийх болон мэдээллийн өгөгдлийн сан ашиглалтыг хөгжүүлэх, эрсдэлийн мэдрэмжтэй хөрөнгө оруулалтыг хөгжүүлэх, гамшгийг тэсвэрлэх, эрсдэл даах чадвартай төр хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих, гамшгийг даван туулах, сэргээн босгох чадвартай, тогтвортой иргэний нийгмийг бий болгоход онцгой анхаарч ажиллах болно.

Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагаа, чадавх жил ирэх тусам бэхжиж, ард иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлэх үйлчилгээний чанар хүртээмж дээшилнэ гэдэгт итгэлтэй байна.

Та бүхний хариуцлагатай бөгөөд бахархалтай, нэр хүндтэй их үйлсэд тань амжилт хүсэн ерөөе.



МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД

Ө.ЭНХТҮВШИН



Онцгой байдлын байгууллага хуулиар хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлэхэд дэмжлэг үзүүлж байнга хамтран ажилладаг Монгол Улсын Засгийн газар, гамшгаас хамгаалах улсын албад болон төсөл хөтөлбөр хэрэгжүүлэн тусалж дэмждэг улс орон, олон улсын байгууллага, энэ байгууллагад ажиллаж байсан үе, үеийн удирдлага, ахмад үеийнхэн, одоо ажиллаж байгаа генерал, офицер, ахлагч, нийт албан хаагчид, хамтран зүтгэгч Та бүхэнд Монгол Улсад Онцгой байдлын байгууллага үүссэн байгуулагдсаны 15 жилийн ойн мэндийг өргөн дэвшүүлье!

Онцгой байдлын байгууллагын үүсэл хөгжил, өнгөрсөн 15 жилийн дурсамж, алдаа оноо, амжилт бүтээлийг энэхүү номын хуудсаар дамжуулан хүргэхийг зорилоо.

Эдүгээ гамшгаас хамгаалах үндэсний чадавхыг бэхжүүлэх, гамшигтай тэмцэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэх, Онцгой байдлын байгууллага, түүний харьяа анги, салбарыг олон улсын байгууллагын жишигт ойртуулан орчин үеийн мэргэжлийн байгууллага болгон хөгжүүлэх, эрх зүйн орчин нэгэнт тогтсон.

Улс орны эдийн засгийн нөхцөл, төсөв хүндрэлтэй амаргүй үеийг туулж байгаа хэдий ч 2015 оноос хойш 42 анги, салбар, хэлтсийг шинээр байгуулж 900 гаруй алба хаагчаар эгнээгээ тэллээ. Гамшиг, аюулт үзэгдлийн үеийн удирдлага, зохион байгуулалт, оператив үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах, олон улсын жишигт хүргэх үүднээс Онцгой байдлын байгууллагын тогтолцоог 2016 оноос Бүсийн төвийн зохион байгуулалтад шилжүүллээ. Цаашид Онцгой байдлын байгууллага маань бүс нутгийн, дэлхийн хэмжээнд үйл ажиллагаагаа явуулдаг улам чадварлаг алба болон бэхжих нь дамжиггүй юм.

Өнөөдөр Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлыг хангах, эх орон, байгаль дэлхий, ард иргэдээ болзошгүй аюул, ослоос авран хамгаалах хүндтэй, хариуцлагатай албыг гүйцэтгэсээр ирсэн Онцгой байдлын байгууллагагүйгээр монголын ард түмэн өөрсдийн амьдралаа төсөөлөхөөргүй болжээ.

Энэ бүхэн бол та бүгдийн ажил үйлсийн үр дүн, энэ байгууллагын төлөө залуу халуун насаа зориулсан манай ахмад үеийнхний зүтгэл, эх орон, ард түмэн, албаныхаа төлөө алтан амиа зориулсан эрэлхэг зоригт хөвгүүдийн минь гавьяа юм.

Улс орны тэргүүлэх салбар нь болсон онцгой байдлын байгууллагын алба хаагч байна гэдэг та бидний бахархал, нэр төрийн хэрэг бөгөөд өндөр үүрэг хариуцлага юм.

Иймд бид мэдлэг, боловсрол, мэргэжлийн ур чадвараар нийгэмдээ тэргүүлэгч, манлайлагчид байж, өнөөдрийн түвшинд хүрсэн ололт, амжилтаа бататгаж, төр, ард түмнийхээ өмнө хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлж, Онцгой байдлын алба улам бүр бэхжин өнө мөнх оршин тогтноно гэдэгт итгэлтэй байна.

Эр зориг, тэсвэр хатуужил, золбоо хийморь төгөлдөр хүмүүнлэгийн албаны яруу алдар үеийн үед мандан бадрах болтугай.

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,

ХОШУУЧ ГЕНЕРАЛ

Т.БАДРАЛ

A handwritten signature in black ink, appearing to be 'T. Badral'.

Аливаа тэмдэглэлт ой гэдэг өмнөх үеэ дурссан, өнөө үедээ дурсамжтай, хойч үедээ сургамжтай, өчигдрийг амилуулж, өнөөдрийг бий болгож, маргаашаа тодорхойлох түүхийн онцлог агшин байдаг. Тийм ч учраас Онцгой байдлын байгууллага үүсэн байгуулагдсан түүхт 15 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний хүрээнд Онцгой байдлын байгууллагын түүхэн номыг бүтээн та бүхэндээ өргөн барьж байна.

Жил бүхэн өөр өөрийн араншинтай. Өөрийгөө тодотгох өнгө төрхтэй. Дэлхий ертөнц, бүс нутаг, улс үндэстэн, байгууллага, хамт олон, хувь бодгаль бүхэнд үлдээсэн мөр, бүтээсэн замнал, дурсамжтай байдаг. Энэ ч утгаараа Онцгой байдлын байгууллагын 15 жилийн түүхийг энэхүү номдоо гэрэл зургаар түлхүү харуулахыг зорилоо.

Түүхэн хөгжил дэвшлийн тодорхой үе шатуудыг даван туулсаар өнөөгийн энэ тогтолцоонд хүрч ирэхэд энэхүү байгууллага нь алдаа оноо, амжилт бүтээл, арвин их туршлагыг хуримтлуулсан тийм л он жилүүдийг үдсэн.

Онцгой байдлын байгууллага хууль эрхзүйн орчноо шинэчилж, шинэ бүтээн байгуулалт өрнүүлж, салбар нэгж бүртээ хийж бүтээсэн ололт амжилттайгаар өөрийн хөгжлийн түүхнээ шинэ хуудсыг нэмсээр буй юм.

Цаашдаа ч Онцгой байдлын байгууллага хэмээх энэ их айлыг нуруундаа үүрч яваа чадварлаг алба хаагчид та бүхний хичээл зүтгэл, дэмжлэгээр бидний зорьсон үйл хэрэг амжилт бүтээлийг дагуулж, ард иргэдээ аливаа гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах, авран хамгаалах энхийн үйлс минь мөнхөд дуурсах алдартай байна гэдэгт итгэлтэй байна.

“Онцгой байдлын байгууллагын алба хаагчид бусдын амийг аврахын төлөө өөрсдийнхөө амийг эрсдэлд оруулж, гамшиг тохиолдсон газарт та бүхнийг очиход иргэд тайвширч “Монголын төр ирлээ” гэж хардаг” хэмээн Монгол Улсын Ерөнхийлөгч нэгэнтээ та бидний ажил, үйлсийг үнэлэн хэлсэн нь бий.


Үнэхээр төрийн өмнөөс үүрэг хүлээдэг, эрхэм бөгөөд хүндтэй, хариуцлагатай, нэр төртэй та бүхний ариун үйлс, баатарлаг гавьяа үеийн үед тасралтгүй үргэлжилж, суу алдраа мөнхөд дуурсгаж явахыг хүсье.

Түүнчлэн энэхүү номыг бүтээсэн ажлын хэсгийн хамт олон, номд орох материал, гэрэл зургийг бэлтгэн өгсөн бүх хүнд талархлаа илэрхийлье.

Та бүхний хүсэл тань тод, зорилго тань алс байх болтугай.

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ТЭРГҮҮН ДЭД ДАРГА,

БРИГАДЫН ГЕНЕРАЛ



Г.АРИУНБУЯН



ОНЦГОЙ БАЙДЛЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН САЙД НАР



У.ХҮРЭЛСҮХ

Онцгой байдлын асуудал эрхэлсэн
Монгол Улсын сайд /2004-2006/
Монгол Улсын Шадар сайд
/2014-2015, 2016-2017/



С.ОТГОНБАЯР

Онцгой байдлын асуудал эрхэлсэн
Монгол Улсын сайд /2006-2007/



М.ЭНХБОЛД

Монгол Улсын Шадар сайд
/2007-2012/



Д.ТЭРБИШДАГВА

Монгол Улсын Шадар сайд
/2012-2014/



Ц.ОЮУНБААТАР

Монгол Улсын Шадар сайд
/2015-2016/



Ө.ЭНХТҮВШИН

Монгол Улсын Шадар сайд
/2017 оноос/

ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН ДАРГА НАР



П.ДАШ

/2004-2007/



Ц.АМГАЛАНБАЯР

/2007-2012/



Т.ДУЛАМДОРЖ

/2012-2015/



Т.БАДРАЛ

/2015 оноос/

ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГА БАЙГУУЛАГДАХ УГТВАР НӨХЦӨЛ БҮРЭЛДСЭН НЬ

Түүхэн баримтаас үзэхэд эрс тэс уур амьсгалтай Монгол орны хувьд бүхэлдээ болон хэсэгчилсэн байдлаар байгалийн гамшигт нэрвэгдсээр ирсэн байдаг. Тийм ч учраас манай улсын хувьд байгалийн гамшигтай тэмцэх асуудлыг өнгөрсөн зууны тавь, жараад оны үеэс эхлэн төрийн бодлогын хэмжээнд авч үзэх болсон байна.

Энэ нь Монгол Улсын Иргэний хамгаалалтын албаны эхлэлийг тавьсан байгууллагуудын гүйцэтгэх үүрэгт байгалийн гэнэтийн аюултай тэмцэх талаар удаа дараа тусгаж өгч байснаас харагдана. Харин Иргэний хамгаалалтыг дайсны үй олноор хөнөөх зэвсэг, довтолгооны бусад хэрэгслээс хамгаалах зорилгоор зохион байгуулж байсан дал, наяд онд байгалийн гэнэтийн аюулт үзэгдэл, үйлдвэрлэлийн осолтой тэмцэх арга хэмжээг Иргэний хамгаалалтын “тайван цагийн үүрэг” гэж үздэг байжээ.

Энэхүү тайван цагийн үүрэг зорилтыг улам тодорхой болгох, үйл ажиллагаагаа байгалийн гамшиг, ослын аюулаас авран хамгаалахад чиглүүлэх шаардлага тулгарах болж, зайлшгүй өөрчлөлт, шинэчлэлийн суурь тавигдсан нь 1990-ээд он.

Хүний нийгмийн хязгааргүй хэрэглээ, хөгжил, тэлэлт байгаль дэлхийг хайр найргүй сүйтгэсний хариуг байгаль өөрөө барьж эхлэв. Гамшиг осол, дэлхий дахинаа аюулын харанга дэлдэх үзэгдэл олширч буйд олон улс цочирдож, энэ талбарт шинэ хандлага нэгэнт бий болов. Тэрчлэн дэлхийн хэмжээнд улстөрийн уур амьсгалын дулаарал эхэлж, социалист орнуудын батлан хамгаалах бодлогод өөрчлөлт гарч эхэлсэн байна. Монгол Улсын хувьд ч улс орноороо шинэ тогтолцоонд шилжих өөрчлөл байгуулалтын замд буцалтгүй орсон байлаа. Энэхүү нийгмийн нэг тогтолцооноос нөгөөд шилжих түүхийн хариуцлагатай цаг үед бүх салбарт өөрчлөлт шинэчлэлийн уур амьсгал орсон нь Иргэний хамгаалалтын байгууллагыг тойроогүй юм.

Төрөөс батлан хамгаалах талаар баримтлах бодлого, чиглэл өөрчлөгдөхийн зэрэгцээ манай орны хэмжээнд тохиолдох байгалийн аюулт үзэгдэл, гамшиг осол, хүн малын гоц халдварт өвчний гаралтын тоо, хамрах хүрээ, хохирлын хэмжээ жилээс жилд өссөн зэргээс Иргэний хамгаалалтын байгууллага үйл ажиллагаагаа дэлхий нийтийн жишигт ойртуулан нийцүүлэх, Иргэний хамгаалалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага зүй ёсоор тавигдсан байна.

Ингээд Улсын иргэний хамгаалалтын газрын даргын 2001 оны 15 дугаар тушаалаар Засгийн газрын тохируулагч агентлаг Иргэний хамгаалалтын газрын өнөөгийн байдлын оношлогоо, шинжилгээ, дүгнэлт, ирээдүйн дүр төрхийг тодорхойлох төслийн багийг томилон ажиллуулжээ. Тус төслийн багийн ахлагчаар Иргэний хамгаалалтын газрын хэлтсийн дарга, хурандаа О.Намхай ажиллаж, гишүүдэд Ж.Энхбаяр, Г.Дашдаваа, Л.Пүрэвдорж, Б.Дорждагва, М.Сүхбаатар, Ш.Даваажав, Я.Жаргалсайхан, С.Содгэрэл, одоогийн ОБЕГ-ын дэд дарга, хурандаа Б.Ууганбаяр, үндэсний зөвлөхөөр Засгийн газрын ахлах референт Э.Сумьяа нар ажиллажээ.

Улмаар төслийн багаас гаргасан судалгааны тайланд үндэслэн Гамшгийн удирдлагын тухай хуулийн төсөл боловсруулагдаж, 2001 оны 12 дугаар сард Төрийн ордонд “Монгол Улсад гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх менежментийн тогтолцоог боловсронгуй болгох нь” үндэсний бага хурал анх удаа зохион байгуулагдаж, гамшгийн удирдлагын шинэчлэлийг хийх талаарх цогц асуудлыг хэлэлцэж, гамшигтай тэмцэх бие даасан байгууллага бий болох суурь тавигдаж эхэлжээ.

Гэхдээ энэхүү шинэчлэлт өөрчлөлтийн зам шулуухан, дардан байсангүй. Энэ тухай хошууч генерал О.Үржин нэгэнтээ “Шинэ хуулийн төсөл хэлэлцүүлэгдэх явцад Ж.Гүррагчаа сайд Иргэний хамгаалалтын газартай Галын байгууллагыг нэгтгэх хэрэгтэй гэсэн санал хэлж байсан бол Ерөнхий сайд Н.Энхбаяр Улсын нөөцийн газрыг оруулах нь зүйтэй гэж энэ гурван байгууллагын зангилаа гарсан. Байнгын хорооны хурал дээр М.Далайхүү гишүүн цэргийн цолыг яах юм бэ гэсэн асуулт тавьж, хурал даргалж байсан Байнгын хорооны орлогч дарга Д.Базарсад цолтой байхаар асуудлыг авч гарч байсан” хэмээн дурссан байдаг.

Харин Улсын Их Хурал “Гамшгаас хамгаалах тухай” хуулийг 2003 оны 6 дугаар сарын 20-нд батлан гаргав. Тус хуулийг хэрэгжүүлснээр гамшгаас хамгаалах эрхзүйн орчин, байгууллагын бүтэц, чиг үүрэг, зохион байгуулалт, Засгийн газрын бүтцийн хүрээнд эзлэх байр суурь, үйл ажиллагааны хэрэгжилт, эдийн засаг, гадаад харилцаа зэрэгт олон эерэг өөрчлөлт гарчээ.

Ийнхүү өнөөдрийн Онцгой байдлын алба бий болж, даян дэлхийн ижил төрлийн байгууллагатайгаа хөл нийлүүлэн алхах эрх зүйн үндэс нь тавигдсан байна.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН
ҮҮСЭЛ, ХӨГЖИЛ

1

Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 1 дүгээр тогтоолоор Гал түймэртэй тэмцэх газар, Улсын иргэний хамгаалалтын газар, Улсын нөөцийн газруудыг нэгтгэж гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, авран хамгаалах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааг удирдан зохион байгуулах чиг зорилго бүхий Онцгой байдлын албыг байгуулсан юм.


Монгол Улсын Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээс

Улсын Их Хурлаар 2003 оны 6 дугаар сарын 20-ны өдөр батлагдсан “Гамшгаас хамгаалах тухай” хуулийг хэрэгжүүлэх асуудлыг авч хэлэлцсэн Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 1 дүгээр сарын 7-ны өдрийн хуралдааны 1 дүгээр тэмдэглэлд:

“ҮШ. ХЭЛЭЛЦСЭН нь: Гамшгаас хамгаалах ерөнхий газар байгуулах тухай.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Гамшгаас хамгаалах ерөнхий газар байгуулах асуудлыг хэлэлцээд Засгийн газрын тогтоол гаргахаар тогтов.

2. Гамшгаас хамгаалах ерөнхий газар байгуулагдсантай холбогдуулан Улсын нөөцийн газар, Гал түймэртэй тэмцэх газар, Улсын иргэний хамгаалалтын газрын эдийн засаг, санхүүгийн хаалтын балансыг гаргаж, шинээр байгуулагдсан Гамшгаас хамгаалах ерөнхий газрын нээлтийн баланстай болгохыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгав” гэжээ.





Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 1 дүгээр сарын 7-ны өдрийн "Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" 1 дүгээр тогтоолоор "Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бодуулыг шинэчлэн батлах тухай" Улсын Их Хурлын 2002 оны 58 дугаар тогтоолыг үндэслэн Засгийн газраас "Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг байгуулах тухай" 2002 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 162 дугаар тогтоолын хавсралтын Ерөнхий сайдын эрхлэх ажлын хүрээнд "Засгийн газрын тохируулагч агентлаг" гэсэн хэсэгт "З. Гамшгаас хамгаалах ерөнхий газар" гэж нэмсүгэй гэснээр Монгол Улсад Гамшгаас хамгаалах ерөнхий газрыг байгуулах анхны шийдвэр гарчээ.



Пүрэвийн ДАШ

■ Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 1 дүгээр сарын 7-ны өдрийн 2 дугаар тогтоолоор хошууч генерал П.Дашийг Гамшгаас хамгаалах ерөнхий газрын даргаар зургаан сарын хугацаатай түр томилсон байна. Түүнийг Энэтхэг улсад суралцаж байхад тухайн үеийн Ерөнхий сайд Н.Энхбаяр дуудаж авчран энэхүү албанд томилсон байдаг.



► Батлан хамгаалах сайдын эрхлэх асуудлын хүрээнд байсан Улсын иргэний хамгаалалтын газар, Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд байсан Гал түймэртэй тэмцэх газар, Хүнс, хөдөө аж ахуйн сайдын эрхлэх асуудлын хүрээнд байсан Улсын нөөцийн газрыг нэгтгэж Засгийн газрын тохируулагч агентлаг-Гамшгаас хамгаалах ерөнхий газар байгуулах шийдвэр гарч, Засгийн газрын тогтоолоор дээрх гурван байгууллагын дарга нарыг ажлаас нь чөлөөлжээ.

Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар тэргүүн дэд даргаар хошууч генерал О.Үржин, дэд даргаар хурандаа Д.Хишигбаатар, Д.Ганболд нарыг томилж, бүтэц, орон тооны хувьд 108 хүний бүрэлдэхүүнтэй байхаар тогтжээ.

Монгол Улсын Их Хурлын хуралдаанаас

2005 оны нэгдүгээр сарын 18-нд Гамшгаас хамгаалах тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулж Гамшгаас хамгаалах ерөнхий газар гэдэг нэрийг Онцгой байдлын ерөнхий газар болгон өөрчилж албан хаагчдын нийгмийн баталгааг хангасан тодорхой заалтуудыг оруулж өгсөн.

Эрхэлсэн сайдын эрх үүрэг, Онцгой комиссын эрх үүрэг, Онцгой байдал гэсэн ойлголт, томъёоллыг нэлээн тодорхой болгон өөрчилсөн юм.


Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 48 дугаар тогтоолд Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулан Засгийн газрын 2002 оны 162 дугаар тогтоолын хавсралтад Онцгой байдлын асуудал эрхэлсэн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Онцгой байдлын газрыг хамруулсны зэрэгцээ аймаг, нийслэл, дүүргийн Гамшгаас хамгаалах штабыг Онцгой байдлын хэлтэс гэж нэрлэхээр шийдвэрлэсэн байна.

2004 оны Улсын Их Хурлын сонгуулийн дараа Монгол Улсын Засгийн газар бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийж, Онцгой байдлын асуудал эрхэлсэн сайдтай байхаар тогтсон байна. Онцгой байдлын асуудал эрхэлсэн анхны сайдаар У.Хүрэлсүх томилогджээ.



Улмаар эдүгээгийн Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх нь 2005-2006 онд Засгийн газрын гишүүн, Онцгой байдлын асуудал эрхэлсэн сайд, 2014-2015 онд Монгол Улсын Шадар сайд, 2016-2017 онд Монгол Улсын Шадар сайдаар тус тус томилогдон ажилласан юм.






Монгол Улсын Ерөнхий сайдын 2004 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн “Хөтөлбөр, бүтэц, удирдлагын орон тооны тухай” 8 тоот захирамжаар Гамшгаас хамгаалах ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын хөтөлбөр, бүтэц, удирдлагын орон тоог баталжээ.

Гамшгаас хамгаалах ерөнхий газрын бүтцийг

1. Бодлого зохицуулалтын газар дотроо А.Стратегийн удирдлага, төлөвлөлтийн, Б.Шинжилгээ судалгааны гэсэн 2 хэлтэстэй.
 2. Мэргэжлийн удирдлагын газар дотроо А.Шуурхай удирдлага зохицуулалтын, Б.Мэдээлэл холбооны, В.Урьдчилан сэргийлэх, хяналтын гэсэн 3 хэлтэстэй.
 3. Гамшгаас хамгаалах төв дотроо 2 сектортэй.
 4. Тамгын газар дотроо А. Төрийн захиргаа, хүний нөөцийн, Б.Хяналт шинжилгээ, үнэлгээний, В.Гадаад харилцаа, хамтын ажиллагааны гэсэн 3 хэлтэстэй. Олон нийтийн харилцах албатай.
 5. Улсын нөөцийн газар дотроо хэлтэсгүй.
 6. Санхүү, бүртгэлийн хэлтэс
- Гамшгаас хамгаалах ерөнхий газрын удирдлагын орон тоог дарга, тэргүүн дэд дарга нэг, дэд дарга хоёр байхаар тогтоожээ.

Гамшгаас хамгаалах ерөнхий газар нь Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд гамшгаас хамгаалахтай холбогдсон хууль тогтоомж, шийдвэр, үйл ажиллагааны стратегийг хэрэгжүүлнэ. Засгийн газрын гамшгаас хамгаалах зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэг бүхий тохируулагч агентлаг-Гамшгаас хамгаалах ерөнхий газрын дарга нь Ерөнхий сайдын өмнө үүрэг, хариуцлага хүлээнэ гэдгийг уг захирамжаар тогтоож өгсөн байна.



Бүтэц, орон тоо батлагдсанаар хуучин Иргэний хамгаалалтын газар, Гал түймэртэй тэмцэх газрын чиг үүрэг Мэргэжлийн удирдлагын газарт шилжин үйл ажиллагаа явуулах болжээ.



Онцгой байдлын асуудал эрхэлсэн сайдын тушаалаар ОБЕГын дэргэд Шуурхай бүлэг-105-ыг шинээр байгуулж, тусгай тоноглол бүхий автомашинаар ханган ээлжийн дөрвөн эмчтэйгээр үүрэг гүйцэтгэж эхлэв.



2006 онд Мэргэжлийн удирдлагын газрын нэрийг өөрчлөн Онцгой үеийн шуурхай удирдлагын газар гэж нэрийдсэн бол Монгол Улсын сайдын 2007 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 33 дугаар тушаалаар Онцгой байдлын ерөнхий газрын бүтцэд Онцгой үеийн удирдлагын газар нэртэйгээр Шуурхай удирдлага, зохицуулалтын төв, Холбоо мэдээллийн хэлтэс, Шуурхай бүлэг-105, Оператив жижүүртэй, Олон нийттэй харилцах, Хүн амын Эрүүл мэндийг хамгаалах, Дэд бүтэц, техник, технологиос үүдсэн гамшигтай тэмцэх, Байгаль экологи, хөдөө аж ахуйн гаралтай гамшигтай тэмцэх, Гал түймэртэй тэмцэх хэлтэстэйгээр байгуулагдсан байна.

2008 оноос Монгол Улсын Шадар сайдын 01 дүгээр сарын 10-ны өдрийн 03 дугаар тушаал, 05 дугаар сарын 16-ны өдрийн 56 дугаар тушаалаар Онцгой байдлын ерөнхий газрын бүтцийг шинэчлэн баталсанаар Онцгой үеийн удирдлагын газар нь Гамшигтай тэмцэх газар, Гал түймэртэй тэмцэх газар гэж хуваагдан зохион байгуулагджээ.

Түүнчлэн Гамшигтай тэмцэх газар нь Онцгой байдлын ерөнхий газрын 2012 оны бүтцийн өөрчлөлтөөр Гамшгаас хамгаалах газар, 2015 оноос Гамшгийн шуурхай удирдлагын газар нэртэйгээр Мэргэжлийн удирдлага, зохицуулалтын хэлтэс, Холбоо зарлан мэдээллийн хэлтэс, Гамшгийн шуурхай удирдлага, зарлан мэдээллэх төвтэйгөөр үүргээ гүйцэтгэж байна.



Улсын иргэний хамгаалалтын газрын даргын 2003 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн 82 дугаар тушаалаар Холбоо, мэдээллийн хэлтсийн даргаар дэд хурандаа Д.Ариундалай томилогдож, тус хэлтэс нийт 16 албан хаагч (5 офицер, 11 ахлагч) бүрэлдэхүүнтэй байхаас нийт 9 албан хаагч (2 офицер, 7 ахлагч) бүрэлдэхүүнтэй ажил үүргээ гүйцэтгэж байв.


Тус хэлтэс 2005-2006 онд Улсын нөөц, хангалтын газрын бүтцэд үйл ажиллагаа явуулж байгаад 2007 оноос Онцгой үеийн шуурхай удирдлагын газрын бүтцэд багтжээ.



Гал түймэртэй тэмцэх газрын хувьд 2012 оноос тус газрын Урьдчилан сэргийлэх хэлтэст Барилгын зураг, төсөл хянах тасгийг шинээр байгуулсан бол 2015 оноос Гал түймэртэй тэмцэх газрын галын аюулаас урьдчилан сэргийлэх ажлыг Гамшгаас урьдчилан сэргийлэх газарт, гал түймрийн судалгаа, эрдэм шинжилгээ, туршилт, галын шалтгаан нөхцөлийг тогтоох ажлыг Гамшиг судлалын хүрээлэнд тус тус харьяалуулж, Гал түймэр унтраах, Гал түймрийн хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй хоёр хэлтэс, Барилгын зураг төсөл хянах тасагтайгаар шинэчлэн зохион байгуулсан юм.



► Мөн 2015 онд Онцгой байдлын ерөнхий газрын бүтцэд гамшгаас урьдчилан сэргийлэх, сургалт, сурталчилгаа, олон нийттэй харилцах чиг үүрэг бүхий Гамшгаас урьдчилан сэргийлэх газар, 2017 онд Гамшигийн эрсдэлийн удирдлагын газар, 2018 онд Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийг өргөтгөн Дотоод хяналт, шалгалт, аюулгүй байдлын газрыг бүтцийн нэгжид шинээр байгуулсан юм. Одоо Онцгой байдлын ерөнхий газар нь дээрх бүтэцтэй үйл ажиллагаагаа явуулж байна.



Монгол Улсын Ерөнхий сайдын 2004 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн “Улсын албад байгуулах тухай” 13 дугаар захирамжаар гамшгаас хамгаалах есөн улсын албыг байгуулж, удирдлагыг томилжээ. Үүнд:


1. Байгалийн болон химийн аюулыг үнэлж мэдээлэх алба,
2. Эрүүл мэндийн алба,
3. Хүнс, хөдөө аж ахуйн алба,
4. Дэд бүтцийн алба,
5. Хэв журмын алба,
6. Сурталчилгаа, мэдээллийн алба,
7. Цацрагийн аюулаас хамгаалах алба,
8. Мэргэжлийн хяналтын алба,
9. Газрын алба

Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн “Гамшгаас хамгаалах улсын албад байгуулах тухай” 158 дугаар тогтоолоор улсын албад 9 байсныг 11 алба болгон өргөжүүлсэн байна.

Гамшгаас хамгаалах улсын албадын бүтэц нийтдээ Засгийн газрын тогтоолоор гурван удаа шинэчлэгдэн батлагдсан бөгөөд Засгийн газрын 2018 оны 347-р тогтоолоор өдгөө 12 улсын алба гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2004 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн “Дүрэм батлах тухай” 17 дугаар захирамжаар Гамшгаас хамгаалах ерөнхий газрын дүрмийг баталжээ.

Гамшгаас хамгаалах чиг үүрэгтэй байгууллагуудыг шинэ бүтэц, зохион байгуулалтад шилжүүлсэнтэй холбогдуулан үйл ажиллагаандаа үнэлэлт дүгнэлт өгөх, цаашдын зорилтыг тодорхойлох, нэгдсэн ойлголтод хүрэх зорилгоор Гамшгаас хамгаалах ерөнхий газар, харъяа анги, аймаг, нийслэлийн Гамшгаас хамгаалах штаб, Улсын нөөцийн салбаруудын удирдах ажилтны цугларалтыг 2004 оны 05 дугаар сарын 18-20-ны өдрүүдэд анх удаа зохион байгуулсан байна.



■ Гамшгаас хамгаалах
удирдах ажилтны сургалт
2004.05.18-20



Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 1 дүгээр тогтоолоор Гамшгаас хамгаалах ерөнхий газар байгуулсантай уялдуулан Гамшгаас хамгаалах ерөнхий газрын даргын 2004 оны 17 дугаар тушаалаар Ахмадын хороог байгуулж, тус хорооны дүрмийг боловсруулж батлуулах, хорооны тэргүүлэгчдийг сонгож ажиллуулах ажлыг зохион байгуулахыг Тамгын газрын дарга /хурандаа П.Баттогтох/-д үүрэг болгожээ.



■ ОБЕГ-ын Ахмадын хорооны бүх гишүүдийн 2009 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн хурлаар Ахмадын хорооны удирдах зөвлөлийн гишүүнээр Д.Хишигбаатар, Ч.Нямаа, Н.Нансал, Т.Бадрал, О.Ганхуяг, Ж.Цогтоо, Ц.Батбаяр, П.Дамдин, Б.Жанчив нарыг сонгож 2012 онд бүх гишүүдийн хурлаар дээрх ахмадууд Удирдах зөвлөлийн гишүүнээр улиран сонгогдсон байна.

Түүнчлэн 2013 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хурлаар Ж.Цогтоог Ахмадын хорооны удирдах зөвлөлийн даргаар сонгон ажиллуулсан бол 2015 оны бүх гишүүдийн хурлаар мөн улираан сонгосон байна. Харин Ахмадын хороог шинэчлэн зохион байгуулж удирдах зөвлөлийн гишүүдэд Б.Булган, Ч.Батчулуун, О.Ганхуяг, Р.Даваажав, Я.Ишжамц, С.Цогтбаатар, Ж.Цогтоо нар ажиллахаар болжээ.

Энэхүү шийдвэрийг хэрэгжүүлэн Гамшгаас хамгаалах ерөнхий газрын Ахмадын хороог зохион байгуулах хурлыг 2005 оны 03 дугаар сарын 11-ний өдөр хийж, Ахмадын хорооны дүрмийг батлан Ахмадын хорооны тэргүүлэгчдэд Г.Махбариад, С.Энэбиш, Д.Далантай, П.Батаахүү, П.Дамдин, Г.Цэнд, Г.Чулуун, Ч.Нямаа, Д.Жадамбаа нарыг сонгосон байна.

Ахмадын хорооны тэргүүлэгчдийн анхдугаар хурлаас Ахмадын хорооны даргаар Г.Махбариад, орлогч даргаар Д.Далантай нарыг сонгож ажиллуулав.

Мөн Онцгой байдлын ерөнхий газрын даргын шийдвэрээр Ахмадын хорооны даргаар Б.Жанчив 2005-2008 онд, Г.Дамдинсүрэн 2008-2009 онд томилогдон ажиллаж байжээ.

► *Онцгой байдлын албаны Ахмадын байгууллага нь өөрийн гишүүддээ үйлчилдэг, тэдний хууль ёсны эрх ашгийг хамгаалах үндсэн үүрэг зорилготой Төрийн бус байгууллага юм.*



Онцгой байдлын байгууллагын "Гурван үеийн чуулга уулзалт"-ыг 2013 онд анх удаа зохион байгуулж, цаашид гурван жил тутамд зохион байгуулахаар тогтсон байна. Түүнчлэн энэ уулзалтын үеэр ахмад настнуудын үүсгэл санаачлагыг харгалзан Онцгой байдлын байгууллагын "Ахмадын холбоо"-г байгуулж, тэргүүнээр бэлтгэл комиссар Д.Хишигбаатарыг сонгосон бол 2019 оны 05 дугаар сарын 25-нд болсон "Ахмадын холбоо"-ны гуравдугаар бага хурлаар түүнийг дахин сонгосон байна. Эдүгээ Онцгой байдлын байгууллагын Ахмадын холбооны харьяа Ахмадын хороо 3, зөвлөл, салбар 24 ажиллаж байгаа бөгөөд тэтгэврийн ахмад настан 2000 гаруй хүн хамрагдаж байна.

Ахмад настны тухай хууль, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2017 оны А/339 дүгээр тушаалаар "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-ыг батлан мөрдүүлж ахмад настны нийгмийн асуудлыг шийдвэрлэх, тэдэнд үзүүлэх хүндэтгэл, хөнгөлөлт, тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх, амралт чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх чиглэлээр үйл ажиллагаагаа жилээр төлөвлөн хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг Ахмадын санд жил бүр тусган хэрэгжүүлж байна.



Ахмад настны тухай хуулийн 9.3 дугаар заалтыг үндэслэн Гамшгаас хамгаалах эрх зүйн орчинг боловсронгуй болгох, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх үүрэгтэй Зөвлөх мэргэжилтний багийн ажиллах журам, багийн гишүүдийг ОБЕГ-ын даргын 2018 оны А/195, А/224 дүгээр тушаалаар батлуулан ажиллаж байна.


Зөвлөх мэргэжилтний багийн хамт олон 2019 онд зохиох ажлын төлөвлөгөөний дагуу Хууль сахиулах Их сургууль, Онцгой байдлын сургуулийн үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөртэй танилцаж, 2019 оны 04 дүгээр сарын 24-26-ны өдрүүдэд зохион байгуулсан Нийслэлийн Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуульд Иж бүрэн сургуулийн бодлого, төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх зүйл, иж бүрэн сургуулийн үед удирдах бүрэлдэхүүний гүйцэтгэх чиг, үүрэг, практик ажлын талаар Онцгой байдлын ерөнхий газрын удирдлага, бие бүрэлдэхүүнд цаашид анхаарах асуудлаар санал зөвлөмж өгч ажиллав.

Гурван байгууллага нэгдэж, нэгдсэн тогтолцоонд шилжсэн эхний үед байгууллага бүр өөрийн давуу байр суурьтай үлдэх гэсэн санаархал байсан нь нууц биш юм. Тиймээс тухайн үеийн удирдлагаас аймгуудын Гамшгаас хамгаалах штабын даргыг тухайн аймгийн Засаг даргын саналаар томилох шийдвэрийг гаргаж байжээ.



Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн “Комиссын ажиллах журам, бүрэлдэхүүн батлах тухай” 34 дүгээр тогтоолоор Гамшгаас хамгаалах тухай хуулийн 17, 23.2-т заасныг үндэслэн “Бий болсон цагийн байдалтай уялдуулан гамшгийн хор уршгийг арилгах, голомт тэлэхээс урьдчилан сэргийлэх, аврах, хойшлуулшгүй сэргээн

босгох арга хэмжээг зохицуулах, шуурхай зохион байгуулах үүрэг бүхий Гамшигтай тэмцэх комиссын ажиллах журмыг батлуулан мөрдөж эхэлжээ. Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн “Комиссын бүрэлдэхүүн, журам батлах тухай” 183 дугаар тогтоолоор Гамшигтай тэмцэх комиссыг “Улсын онцгой комисс” болгон өөрчилжээ.



Монгол Улсын Онцгой байдлын асуудал эрхэлсэн сайдын 2005 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 36 дугаар тушаалаар Онцгой байдлын байгууллагын Бэлгэ тэмдгийн тодорхойлолт, загвар, хэрэглэх журмыг баталжээ.

■ Онцгой байдлын ерөнхий газрын даргын зөвлөлийн хурлаар Онцгой байдлын байгууллагын бэлгэ тэмдгийн загварыг шинээр хийхээр болж, Олон Улсын Иргэний хамгаалалтын байгууллагын бэлгэ тэмдэг, логоны загварын үндсэн суурийг ашиглах нь зүйтэй гэж тогтсон байна.

Албаны бэлгэ тэмдэг логоны эх загварыг Төрийн захиргааны удирдлагын газар хариуцан хийхээр болж, тухайн үед тус газрын ахлах мэргэжилтэн, дээд ахмад эдүгээгийн Гамшгийн шуурхай удирдлагын газрын дарга, хурандаа Б.Мандахгэрэл анхны хар зургийг зурж байжээ.



■ Онцгой байдлын албаны бэлгэ тэмдэг, логоны анхны батлагдсан загвар



■ Бэлгэ тэмдэг, логоны анхны гар зураг

БЭЛГЭ ТЭМДГИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Дэлхийн бөмбөрцөг:
 -Хүн төрөлхтөн нэг гараг ертөнцийн нэгдмэл гэр бүл бөгөөд гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох арга хэмжээ нь зөвхөн нэг улс үндэстний бус нийт улс орон, хүн ардын үйл ажиллагаанаас харилцан хамааралтай нийгэм, эдийн засаг, тогтвортой хөгжил байгаль экологийн асуудал гэсэн утга санааг илэрхийлнэ.



Бөмбөрцгийг эмжсэн чидун жимсний мөчир:
 - Ялалт, амжилтыг бэлгэдэх ба мөнхөд оршихуйн утга санааг илэрхийлнэ.

Гурвалжин дүрсний төв хэсэг дэх "Соёмбо" тэмдэг:
 -Тусгаар тогтносон, бүрэн эрхт, эртний түүх соёл, төр ёсны арвин баялаг уламжлал бүхий Монгол Улсын үндэсний онцлогийг илэрхийлнэ.


Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2005 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн "Цол олгох журам батлах тухай" 51 дүгээр зарлигаар баталжээ.

Улсын Иргэний хамгаалалтын газар, Гал түймэртэй тэмцэх газар, Улсын нөөцийн газруудыг нэгтгэн Гамшгаас хамгаалах ерөнхий газрыг байгуулах болсноор 2003 оны 11 дүгээр сард Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын "Улсын иргэний хамгаалалтын газрын офицеруудыг цэргийн жинхэнэ албанаас бэлтгэлээр халсугай" гэсэн тушаал гарсан байна.




■ Ингэснээр Онцгой байдлын байгууллагын алба хаагчид хуучин Гал түймэртэй тэмцэх газрын хэрэглэж байсан дотоодын цэргийн цолыг түр хугацаанд хэрэглэж байгаад тусдаа цол, дүрэмт хувцастай болох асуудлыг Ерөнхийлөгчийн Тамгын газарт тавьжээ. Харин тухайн үеийн Ерөнхийлөгчийн Тамгын газраас "Та бүхний гүйцэтгэж байгаа үүрэг үнэхээр онцлогтой, тусдаа дүрэмт хувцас, цолтой байх нь зүйтэй юм" гэж хүлээн зөвшөөрсөн хэдий ч "засаг", "залан", "зайсан", "занги", "захирагч" гэх XVI-XVII зууны үед манжийн засаг захиргаа Монголд ноёрхлоо тогтоосонтой холбоотойгоор үүссэн нэр томъёо, засаг захиргааны нэгжтэй холбогдож гарсан албан тушаалын цол хэргэмийг санал болгосон байна.

"Эдгээр нь манж үгнүүд юм байна. 21-р зууны тусгаар тогтносон Монгол Улс аль тэртээх 16, 17-р зууны үеийн манжийн засаг захиргааны үед хэрэглэж байсан нэр томъёог хэрэглэх нь оновчгүй юм. Тэгээд ч цол биш албан тушаал юм байна" гэсэн тайлбар хүргүүлсэний дараа "шадар түшээ", "ахлах түшээ", "дэс түшээ", "туслах түшээ" гэдэг цол санал болгосон нь төрийн захиргааны албан тушаалыг зэрэг дэвтэй хольж хутгасан зүйл байв.



■ Ийнхүү цол, дүрэмт хувцастай болох асуудал хэдэнтээ эргэж буцсаар "шадар дэслэгч", "тэргүүн дэслэгч", "дээд дэслэгч", "шадар ахмад", "тэргүүн ахмад", "дээд ахмад", "комиссар", "тэргүүн комиссар" гэсэн цолыг Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын алба хаагчид хэрэглэхээр болжээ.



Монгол Улсын Их Хурлаас 2011 оны 12 дугаар сарын 09-ний өдөр Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, 32.2-т Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын тусгай алба хаагч нь, ахлагч нь онцгой байдлын дэд ахлагч, ахлагч, ахлах ахлагч, офицер нь онцгой байдлын дэслэгч, ахлах дэслэгч, ахмад, хошууч, дэд хурандаа, хурандаа гэсэн цолтой байна. Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын удирдах албан тушаалтанд цэргийн дээд цол олгож болно гэж заасан байна.

Тус хуулийн заалтыг үндэслэн Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2012 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 06 дугаар тушаалаар дээд ахмад цол эдэлж байсан алба хаагчдад онцгой байдлын хурандаа, тэргүүн ахмад цол эдэлж байсан алба хаагчдад онцгой байдлын дэд хурандаа, шадар ахмад цол эдэлж байсан алба хаагчдад онцгой байдлын хошууч, дээд дэслэгч цол эдэлж байсан алба хаагчдад онцгой байдлын ахмад, тэргүүн дэслэгч цол эдэлж байсан алба хаагчдад онцгой байдлын ахлах дэслэгч, шадар дэслэгч цол эдэлж байсан алба хаагчдад онцгой байдлын дэслэгч, дээд түрүүч цол эдэлж байсан алба хаагчдад онцгой байдлын ахлах ахлагч, тэргүүн түрүүч цол эдэлж байсан алба хаагчдад онцгой байдлын ахлагч, шадар түрүүч цол эдэлж байсан алба хаагчдад онцгой байдлын дэд ахлагч цол тус тус олгосон байна.



Монгол Улсын Их Хурлын 2015 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 85 дугаар тогтоолоор "Монгол Улсын Батлан хамгаалахын бодлогын үндэс"-ийг баталж, 7.1-т "Монгол Улсын төрийн цэргийн байгуулал нь тайван цагт зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллагаас бүрдэнэ, 7.4-т Зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллага нь цэргийн нийтлэг дүрмүүдийг даган мөрдөж, цэргийн алба хаагчийн эрх зүйн хэм хэмжээгээр олгогдсон эрх, үүргийг хэрэгжүүлнэ" хэмээн зааснаар Онцгой байдлын байгууллага нь төрийн цэргийн бүрэлдэхүүнд албан ёсоор багтаж, 2016 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр "Цэргийн албаны тухай хууль" шинэчлэгдэн батлагдсанаар цэргийн цол хэрэглэж эхэлсэн бөгөөд алба хаагчид хос тангарагтай болсон юм.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2005 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн "Тангараг өргөх ёслолын журам батлах тухай" 50 дугаар зарлигаар Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын төрийн тусгай албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам"-ыг баталжээ.



Засгийн газрын Агентлагийн эрх зүйн байдлын болон Гамшгаас хамгаалах тухай хуулийг үндэслэн Монгол Улсын Онцгой байдлын асуудал эрхэлсэн сайдын 2005 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 66 дугаар тушаалаар Тугны загварыг баталжээ.



Энэхүү тушаалд Онцгой байдлын ерөнхий газрын тугны урт, өргөн нь 2:1 метр, Нийслэл, аймаг, дүүргийн Онцгой байдлын газар, хэлтэс, Аврах тусгай анги, Хангалт үйлчилгээний анги, түүнтэй адилтгах нэгжийн тугны урт өргөн 1,8:09 метр, Улсын нөөцийн салбар, Гал унтраах анги, Аврах отряд, салбарын тугны урт, өргөн нь 1,5:0,75 метр байхаар тогтоосон байна.

Монгол Улсын сайдын 2005 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 92 дугаар тушаалаар Онцгой байдлын ерөнхий газар, Нийслэлийн Онцгой байдлын газар, Аврах тусгай анги, Хангалт үйлчилгээний ангид Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын бэлгэ тэмдэг бүхий тугийг, үнэмлэхийн хамт гардуулжээ.



■ Монгол Улсын сайдын мөн өдрийн 93 дугаар тушаалаар Онцгой байдлын ерөнхий газар, Нийслэлийн Онцгой байдлын газар, Аврах тусгай анги, Хангалт үйлчилгээний ангийн захирагч нарын тангараг өргөх ёслолын ажиллагааг 2005 оны 06 дугаар сарын 20-ны өдөр Д.Сүхбаатарын талбайд анхлан зохион байгуулсан байна.





Анх гурван байгууллага нэгдсэн тогтолцоонд орсноос хойшхи жил орчмын хугацаанд албан хаагчид энгийн хувцастай ажиллаж байсан. Хэдийгээр ихэнх алба хаагчид цэргийн цол, дүрэмт хувцастай байсан ч Гамшгаас хамгаалах ерөнхий газар хэмээх шинэ байгууллагад харьяалагдах болсноор өмнөх цол, дүрэмт хувцсаа хэрэглэх аргагүй болсон юм. Гамшгаас хамгаалах тухай хуульд зааснаар Гамшгаас хамгаалах байгууллагын тусгай албан тушаал эрхэлдэг албан хаагчийн дүрэмт хувцасны загварыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар батлуулах ажил удаашралтай байв. Байгууллагын нэг жилийн ойн арга хэмжээнд жигдрэхийн тулд эхний ээлжинд аврах ажиллагаанд оролцдог албан хаагчдыг Онцгой байдлын асуудал эрхэлсэн сайд У.Хүрэлсүхийн 2005 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 60 дугаар тушаалаар батлагдсан ажлын тусгай хувцас буюу одоогийнхоор хээрийн хувцсаар 2005 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор маш богино хугацаанд хангах ажлыг зохион байгуулж Сүхбаатарын тайлбайд жагсаж байжээ.

Дүрэмт хувцасны өнгийг сонгохдоо бусад байгууллагуудын хувцаснаас ялгарахын тулд олон улсын Иргэний хамгаалалтын байгууллагын бэлгэдэлийн хөх өнгөнөөс санаа авч цэнхэр өнгийг үндсэн өнгөөр сонгож, хосолгоог нь улбар шар өнгөөр нь байхаар сонгожээ.



Тухайн үед олон зохион бүтээгчид дүрэмт хувцасны загварыг ирүүлснээс загвар зохион бүтээгч М.Батзоригийн загварыг сонгон авч, хурандаа П.Баттогтохын ахалсан ажлын хэсэг 2005 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 130 дугаар зарлигаар хувцасны загварыг батлуулсан байна. Ийнхүү шинэхэн байгуулагдсан байгууллага ард иргэдийн дунд “онцгой” гэсэн өөрийн дүр төрхтэй болсон юм.



2007 онд дүрэмт хувцасны эдэлгээний хугацааг Засгийн газрын 123 дугаар тогтоолоор, хангалтанд өгөх шаардлагатай зарим ажлын хувцас, хэрэглэлийн загвар, эдэлгээний хугацаа, техникийн шаардлага, өнгө, материалын ялгаа болон хувцас өмсөх дүрэм зэргийг Онцгой байдлын асуудал эрхэлсэн сайдын 40, 41 дүгээр тушаалаар тус тус батлуулж байсан.

Гамшгийн төрөл, давтамж нэмэгдэж Онцгой байдлын байгууллагын алба хаагчид олон төрлийн аврах ажиллагаанд үүрэг гүйцэтгэх болсноор ажлын онцлог тус бүрт тохирсон хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлийг шинээр нэмэх шаардлага тулгаран урд батлагдсан ажлын хувцасны нэр төрөл дээр нэмэн шинэчилж, нийт 61 төрлийн тусгай зориулалтын хувцас хэрэглэлийн нэр

төрөл, эдэлгээний хугацааг Шадар сайдын 2011 оны 62 дугаар тушаалаар баталгаажуулав. Улмаар 2012 онд ШУТИС-ийн эрдэмтэн судлаачидтай хамтран аврах ажиллагааны хувцас хэрэглэл тус бүрээр үндэсний стандартыг батлуулснаар онцгой байдлын байгууллагын албан хаагчид тухайн аврах ажиллагаанд тохирсон хувцас хэрэглэлтэй үүрэг гүйцэтгэх болсон юм.



Улсын Их Хурлаас Гамшигаас хамгаалах тухай хуульд 2011 оны 12 дугаар сарын 09-ний өдөр нэмэлт өөрчлөлт оруулснаар Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын албан хаагчийн цолны нэршил өөрчлөгдөж зарим цолны, тухайлбал "Комиссар" гэсэн цол байхгүй болсонтой холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2005 оны 130 дугаар зарлигийн хавсралтаар баталсан "Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын тусгай албан хаагчийн дүрэмт хувцасны загвар"-т өөрчлөлт оруулах шаардлага тулгарсан. Иймд 2014 онд албаны хувцсыг ёслолын хувцаснаас салган шинэ загвар гарган, мөрдэс болон зарим хувцас хэрэглэлийн өнгө загварыг өөрчлөн шинэчилж, комиссарын болон хэрэглээ багатай хувцас хэрэглэлийг хасаж, нийт 25 нэр төрлийн хувцас, 14 нэр төрлийн чимэг хэрэглэлийн загварыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн 111 дүгээр зарлигийг батлуулсан.



Тухайн цаг үеийн шаардлагаар 15 жилийн хугацаанд Онцгой байдлын байгууллага дүрэмт хувцас хэрэглэлийн загварыг батлах тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийг 3 удаа, дүрэмт хувцасны эдэлгээний хугацааг баталсан Засгийн газрын тогтоолыг 2 удаа, Онцгой байдлын асуудал эрхэлсэн сайдын болон Шадар сайдын тушаалыг 3 удаа, хувцас өмсөх дүрэм, журмыг нийт 3 удаа тус тус батлуулж байжээ.

Батлан хамгаалах хууль шинэчлэн батлагдаж, Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн зүгээс цэргийн алба хаагчдын цол, ялгах тэмдгийг дэлхий нийтийн жишигт нийцүүлэхээр өгсөн чиглэлийн дагуу 2016 онд төрийн цэргийн байгууллагуудын дүрэмт хувцас, мөрдэсний загварыг шинэчлэн батлуулах ажил хийгдэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 81 дүгээр зарлигаар дүрэмт хувцасны загварыг шинэчлэн батлуулсан билээ. Энэхүү зарлигаар Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын хээрийн хувцас өнгөлөн далдлалтын өнгөтэй болж, мөрдэсний загвар бусад цэргийн байгууллагуудтай ижил боловч өөрийн өнгөөр ялгарахаар батлагдсан.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ГАМШГААС ХАМГААЛАХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН БА БОДЛОГО СТРАТЕГИ



Монгол Улсын гамшгаас хамгаалах үйл ажиллагааг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Улсын нөөцийн тухай хууль, Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулж байна.

Дэлхий нийтээр хүйтэн дайны үеийн Иргэний хамгаалалтаас татгалзаж, байгалийн гамшигтай тэмцэх үзэл баримтлалыг чухалчлан 1994 онд Байгалийн гамшгийн аюулыг бууруулах дэлхийн анхдугаар бага хурлаар Йокохамагийн стратегийг баталжээ. Аюул багатай дэлхийн төлөө Йокохамагийн стратеги гэгдэх

энэхүү баримт бичиг нь байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдал, гамшгийн аюулыг бууруулах заавар зөвлөмж, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө нь гамшгийн эрсдэлийг бууруулах болон байгалийн гамшгийн нөлөөллийн талаарх гол чиглүүлэгч болсон юм.




Йокохамагийн стратеги батлагдсанаас хойш бараг 10 жилийн дараа Иргэний хамгаалалтын хуулийн үзэл санааг өөрчлөхөөр Гамшгийн удирдлагын тухай хуулийн төслийг УИХ-д өргөн барьсан бөгөөд энэхүү төсөл явцын дунд өөрчлөгдөж 2003 онд Гамшгаас хамгаалах тухай хууль батлагдсан түүхтэй.

Тус хууль батлагдсанаар дэлхий нийтийн чиг хандлагад нийцсэн орчин цагийн гамшгаас хамгаалах, гамшгийн аюулыг бууруулах тухай ойлголт, бүх нийтийн оролцоо, хамтын ажиллагааны талаар тусгасан гамшгаас хамгаалах шинэ тогтолцооны эхлэл тавигдаж, эрхзүйн зохицуулалт бий болсон.

Өөрөөр хэлбэл, Монгол Улс анх удаа гамшгийн менежментийг хуульчилж, Иргэний хамгаалалтаас гамшгаас хамгаалах менежментийн үзэл баримтлалд шилжсэн бөгөөд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг олон улсын түвшинд хүргэх, гамшгаас хамгаалах чадавхыг сайжруулах нөхцөл бүрдсэн юм.



2005 онд Япон улсын Кобэ хотод хуралдсан Гамшигийн аюулыг бууруулах дэлхийн II бага хурлаас улс үндэстэн орон нутгийн гамшигтай тэмцэх чадавхыг бий болгох "Хёогогийн үйл ажиллагааны хүрээ" баримт бичгийг батлав. Дан ганц байгалийн аюулт үзэгдэлд анхаарахаас гадна хүний үйл ажиллагаатай холбоотой олон янзын гамшиг бий болж байгаа учраас дараагийн 10 жилд үйлдвэрлэлийн осол, хүний буруутай үйл ажиллагаа, уур амьсгалын өөрчлөлт зэрэг бүх төрлийн гамшигтай тэмцэх нь зүйтэй. Ингэхийн тулд улс орнуудын гамшигтай тэмцэх чадавхыг бэхжүүлэх нь зүйтэй гэсэн шийдэлд хүрсэн юм.



Монгол Улсын хувьд энэхүү баримт бичгийн үзэл баримтлалд нийцүүлэн Улсын Их Хурлын 2011 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 22 дугаар тогтоолоор "Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого", "Гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг тус тус баталсан.

Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр нь гамшгаас хамгаалах менежментийн тогтолцоог бэхжүүлэх, хүн амыг аюулгүй амьдрах ухаанд сургах, гамшигийн эмзэг байдлыг бууруулах, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд төв, орон нутгийн төрийн байгууллага, мэргэжлийн байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоог хангах, хүч хэрэгслийн чадавхи, бэлэн байдлыг дээшлүүлэхэд чиглэгдсэн юм.



Дэлхий нийт аливаа гамшигтай тэмцэхээс илүүтэй түүнээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах нь улс орны хөгжил дэвшилд эерэгээр нөлөөлнө гэсэн үзэл санааг, өөрөөр хэлбэл, гамшгаас хамгаалах менежментээс гамшигийн эрсдэлийг бууруулах менежментийн чиг хандлагыг баримтлах болсоноор Япон Улсын Сендай хотод 2015 онд зохион байгуулагдсан Гамшигийн эрсдэлийг бууруулах дэлхийн III бага хурлаар 187 улс хуран чуулж, "Хёогогийн үйл ажиллагааны хүрээ" баримт бичгийн үргэлжлэл болгож "Гамшигийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ 2015-2030" баримт бичгийг санал нэгтэй батлав.

“Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ” баримт бичигт дэвшүүлсэн дэлхий нийтээр хэрэгжүүлэх 7 зорилго, үйл ажиллагааны 4 тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 355 дугаар тогтоолоор “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги (2017-2030)”-ийг батлуулсан нь Ази номхон далайн бүс нутагт уг баримт бичгийг хэрэгжүүлэх үндэсний стратегитай болсон анхдагч орнуудын нэг болсон юм.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2017 оны 12 дугаар сарын 27-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 355

СТРАТЕГИ БАТЛАХ ТУХАЙ

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги”-ийг хавсралт ёсоор баталсугай.

Мөн онд НҮБ-аас “Дэлхийн тогтвортой хөгжлийн хөтөлбөр 2030”, “Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг Парисын хэлэлцээр” гэсэн бодлогын баримт бичгүүдийг баталсан бөгөөд дэлхийн улс орнууд эдгээр баримт бичгийн зорилго, зорилтуудыг үндэсний хууль тогтоомж, бодлого, хөтөлбөртөө нийцүүлэн өөрсдийн чадавх, нөөц бололцоонд тулгуурлан хэрэгжүүлэхээр үүрэг амлалт авсан билээ.



Дээрх бодлогын баримт бичгүүд болон Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, Монгол Улсын батлан хамгаалахын бодлогын үндэс, Батлан хамгаалахын багц хуулиудтай нийцүүлэн Онцгой байдлын ерөнхий газраас “Гамшгаас хамгаалах тухай хууль”-ийг шинэчлэн

боловсруулж, УИХ-ын 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлууллаа. Ингэснээр Монгол Улс дэлхийн тогтвортой хөгжлийг хангах, гамшгийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтийг багасгах дэлхий нийтийн бодлого, хөтөлбөртэй нийцүүлэн гамшгаас хамгаалах эрх зүйн орчноо шинэчилсэн анхны орнуудын нэг болсон юм.


■ Хууль батлагдснаар гамшгаас хамгаалах менежментээс гамшгийн эрсдэлийн менежмент рүү шилжиж, гамшгийн эрсдэлийг бууруулах, удирдлага зохион байгуулалт, холбогдох талуудын үүрэг хариуцлага, гадаад, дотоодын хүмүүнлэгийн тусламжийн зохицуулалт илүү тодорхой болж, онцгой байдлын байгууллагын алба хаагчийн эрхзүйн байдал, нийгмийн баталгаа дээшлэх нөхцөл бүрдсэн юм.

Шинэчлэн баталсан Гамшгаас хамгаалах тухай хуульд дараах зарчмын шинжтэй зохицуулалтыг нарийвчлан тодорхойлсон. Үүнд:

- Хуулийн нэр томъёоны тайлбарыг гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд ашигладаг олон улсын нэр томъёоны тайлбартай нийцүүлж, өөрийн орны онцлогт тохируулан шинээр томъёолсон.
- Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд баримтлах зарчмыг тодорхойлсон.
- Гамшгаас хамгаалах менежментийн үе шатууд болох гамшгийн өмнөх, гамшгийн үеийн, гамшгийн дараах үйл ажиллагааны зохицуулалтыг тусгаж, зааг ялгааг тодорхойлсон.
- Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлага зохион байгуулалт, гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний болон орон нутгийн тогтолцоо, оролцогч талуудын эрх, үүргийг шинэчлэн тусгасан.
- Дотоодын болон гадаадын хүмүүнлэгийн тусламжийн талаарх зохицуулалтыг шинээр тусгасан.
- Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны санхүүжилтийг тодорхой болгосон.
- Алба хаагчийн өргөсөн тангараг, хүлэсэн үүргээ нэр төртэй биелүүлэх эрх зүйн баталгааг бий болгосон.



УЛСЫН ХЭМЖЭЭНД



Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, галын аюулгүй байдлын хяналт тавих, гал түймэртэй тэмцэх байгууллага, алба хаагчийн эрх зүйн байдлыг зохицуулах чиглэлээр 1999 онд батлагдсан Галын аюулгүй байдлын тухай хуулийг шинэчлэн боловсруулж, 2015 оны 7 дугаар сарын 2-ны өдөр УИХ-аар батлуулав.



Тус хууль батлагдсанаар галын аюулгүй байдлыг хангахад Онцгой байдлын байгууллагаас гадна энэ чиглэлийн төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх, галын аюулаас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа зохион байгуулах, галын аюулгүй байдлын үнэлгээ хийх зэрэг төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагуудаар хийлгэх, гал түймэртэй тэмцэх салбар, нэгжийг аж ахуйн нэгж байгууллага, болон сайн дурын үндсэн дээр байгуулах, иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх боломж бүрдсэн.



Галын аюулгүй байдлын тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 48 дугаар тогтоолоор "Гал түймрийн хяналтын дүрэм"-ийг, 2016 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 339 дүгээр тогтоолоор "Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм"-ийг, 2018 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 357 дугаар тогтоолоор "Галын аюултай бүтээгдэхүүн, гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмжийг улсын хилээр нэвтрүүлэх болон үйлдвэрлэх, борлуулах, тээвэрлэх, хадгалах, устгах журам"-ыг тус тус батлуулсан юм.

Галын аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн Монгол Улсын стандарт MNS 4928-2017 "Галын техник, гал түймрийн ангилал", MNS 6412 "Гал унтраах анги, хэсэг аврах нэгжид тавигдах шаардлага" зэрэг 16 стандартыг боловсруулж батлуулан мөрдөн ажиллаж байна.



УИХ-ын 2005 оны 26 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын хууль тогтоомжийг 2008 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-д улсын нөөц бүрдүүлэх, хадгалах, шинэчлэх, захиран зарцуулахтай холбогдсон харилцааг зохицуулах, улсын нөөцийн бэлэн байдлыг дээшлүүлэх, үндэсний аюулгүй байдалд дэмжлэг үзүүлэх, эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад улсын нөөцийн эрх, үүргийг тодорхойлох зорилго бүхий Улсын нөөцийн тухай хуулийг боловсруулж батлуулахаар тусгасан.

Энэ хүрээнд Улсын нөөцийн тухай хуулийг боловсруулан 2007 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн УИХ-аар хэлэлцэн баталсан . Уг хууль батлагдсанаар улсын нөөц бүрдүүлэх, хадгалах, шинэчлэх, захиран зарцуулахтай холбогдсон харилцаа бүрэн зохицуулагдаж, улсын нөөцийн бэлэн байдлыг дээшлүүлэх, гамшгийн хор уршгийг шуурхай арилгах, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, үндэсний аюулгүй байдалд дэмжлэг үзүүлэхэд чухал ач холбогдолтой болсон юм.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2007 оны 7 дугаар сарын 5-ны өдөр Улаанбаатар хот

УЛСЫН НӨӨЦИЙН ТУХАЙ

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДСЭЛЭЛ**

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь улсын нөөцийн бараа, материалыг бүрдүүлэх, хадгалах, тээвэрлэх хүргэх, шинэчлэх, захиран зарцуулах, санхүүжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Улсын нөөцийн тухай хууль тогтоомж

2.1. Улсын нөөцийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.



Мөн орон нутгийн нөөцийг бүрдүүлэх, хадгалах, захиран зарцуулахтай холбогдсон харилцаа хуулийн зохицуулалттай болжээ. Улсын нөөцийн тухай хуулиар Дайчилгааны болон валют, мөнгөн хөрөнгийн нөөцөөс бусад улсын нөөцийг бүрдүүлэх, хадгалах, шинэчлэх, нөхөн бүрдүүлэх, захиран зарцуулах, санхүүжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулж байна.





Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2011 оны 21 дүгээр зарлиг, ҮАБЗ-ийн 2011 оны 5/04 дүгээр тэмдэглэлээр газар хөдлөлтийн төлөв байдлыг нарийвчлан судлах, газар хөдлөлийн гамшгийн аюулыг амжиж анхааруулах системтэй болох, орон сууц, олон нийтийн зориулалтын барилгын чанарыг шалгаж тогтоох, ашиглалтын шаардлага хангахгүй байгааг нь шинэчлэх, хүчитгэх, дахин төлөвлөлтийн арга хэмжээг авах чиглэлийг Засгийн газарт өгөв.



Дээрх үүрэг чиглэлийн дагуу Засгийн газрын 2011 оны 95 дугаар тогтоолоор “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах үйл ажиллагааг улсын хэмжээнд уялдуулан зохицуулж нэгдсэн удирдлагаар хангах” үүрэг бүхий Байнгын ажиллагаатай орон тооны бус зөвлөлийг байгуулж, ажлын алба нь Онцгой байдлын ерөнхий газарт ажиллахаар тусгасан. Тус зөвлөлийн 2016 оны 04 дүгээр хурлын шийдвэрээр аймгуудад газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх Байнгын ажиллагаатай салбар зөвлөл байгуулан ажиллаж байна.

Улсын Их Хурлын 2011 оны 22 дугаар тогтоолоор баталсан “Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого”-ын 1, 2 дахь үндсэн чиглэлд заасныг хэрэгжүүлэх зорилгоор “Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр”-ийг Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 303 тоот тогтоолоор батлуулав.



НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах газраас санаачлан дэлхийн 4000 гаруй хотыг эгнээндээ нэгтгэсэн “Аюулгүй, гамшигт тэсвэртэй хот” хөтөлбөрт 2016 онд Монгол Улсын

нийслэл Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотууд анх нэгдэн орсон бол 2017 онд бүх аймгийн төвүүд нэгдсэнээр уг хөтөлбөрт бүх хотууд нь нэгдсэн Азийн анхны улс болсон.



■ “Аюулгүй, гамшигт тэсвэртэй хот” хөтөлбөрт 21 аймаг нэгдэж, Засаг дарга нар батламжаа гардаж авлаа.



▶ Энэхүү хөтөлбөрт нэгдсэнээр орон нутгийн түвшинд гамшгийн эрсдэлийн талаарх ойлголт нэмэгдэх, гамшигтай тэмцэх чадавх сайжрах, дэлхийн бусад орнуудтай гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлд харилцан туршлага солилцох, аюулгүй хотыг бий болгох чиглэлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх боломж бүрдсэн билээ.

■ ОБЕГ, нийслэлийн ЗДТГ, НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах газар, БНСУ-ын Дотоод хэрэг, аюулгүй байдлын яамтай хамтран “Аюулгүй, гамшигт тэсвэртэй хотыг бий болгох нь” сургалт зохион байгууллаа.

Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах бодлого зохицуулалтыг үндэсний хэмжээнд зохион байгуулах, төр, хувийн хэвшил болон салбар дундын хамтын ажиллагааг хангах, чиг үүрэг бүхий Монгол Улсын Ерөнхий сайдаар тэргүүлсэн Гамшгийн эрсдэлийг бууруулах Үндэсний зөвлөлийг Засгийн газрын 2018 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 63 дугаар тогтоолоор байгуулав. Мөн онд 21 аймаг, нийслэлд Засаг даргаар ахлуулсан гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөл байгуулагдан ажиллаж байна.



Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 31-ний 327 дугаар тогтоолоор "Гамшгийг тодорхойлох шалгуур үзүүлэлт, гамшгийн зэрэглэл тогтоох журам"-ыг батлууллаа.



Энэ журмаар тухайн нутаг дэвсгэрт гарсан аюулт үзэгдэл, ослын нөхцөл байдал, эрчимжилт, үргэлжлэх хугацаа, хүн ам, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчны өртсөн байдал, хамарсан цар хүрээ, учирсан хохирлын хэмжээг илэрхийлэх шалгуур үзүүлэлтийг гарган, орон нутгийн болон бүсийн, улсын хэмжээний гамшиг гэсэн зэрэглэлийг тогтоох боломж бүрдэж байна.

Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 271 дүгээр тогтоолоор "Гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах" журам батлагдаж, гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд зориулж

Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд, хувь хүнээс үзүүлэх хандив, тусламжаар ирүүлсэн бараа материал, мөнгөн хөрөнгийг хүлээн авч байршуулах, хадгалах, хуваарилах, тээвэрлэн хүргэх, зарцуулах, тайлагнах харилцааг зохицуулах боломж бүрдлээ.



Гамшиг ослын улмаас учирсан хохирол үндэсний эдийн засаг, нийгмийн дотоод нөөц боломжоос давсан тохиолдолд гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор дотоодын хүмүүнлэгийн тусламж хүсэх, уриалга гаргах шийдвэрийг улсын хэмжээнд Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, орон нутагт тухайн шатны Засаг дарга гаргана хэмээн заасан байна.



Гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний төлөвлөгөөг Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 416 дугаар тогтоолоор батлуулсанаар Монгол Улс Гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй болов.

Энэхүү төлөвлөгөө нь Монгол Улсын хэмжээнд гамшиг, байгалийн аюулт үзэгдэл тохиолдсон үед Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газрыг гамшигийн үед хийж гүйцэтгэх ажлын үүрэг, чиглэлийг тодорхойлох, зохицуулалт хийх стратегийн түвшний удирдлагын баримт бичиг юм.

Шинэчлэгдэн батлагдсан Гамшгаас хамгаалах тухай хууль, Засгийн газрын 2018 оны 67 дугаар тогтоолоор батлагдсан “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам”-д Онцгой байдлын байгууллага нь хуулийн этгээдэд гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл олгохоор заасан.

Эдгээр баримт бичгүүдийн хэрэгжилтийг хангах хүрээнд Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх хуулийн этгээдэд гамшгийн эрсдэлийн мэргэжлийн сургалтыг зохион байгуулах эрх бүхий байгууллага боллоо.




Орон нутаг дахь гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр зөвлөмж гаргалаа.



“Гамшгийн эрсдэлийн үнэлгээний мэргэшүүлэх сургалт”-ыг зохион байгууллаа.

Гамшгаас хамгаалах тухай хуульд гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх, хуулийн этгээдэд тусгай зөвшөөрлийг олгох, Онцгой байдлын байгууллага эрсдэлийн үнэлгээний гүйцэтгэл, тайланд хяналт тавьж ажиллах заалтыг тусгасан байдаг. Хуулийн заалтыг хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газрын 2018 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 67 дугаар тогтоолоор “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам”-ыг батлууллаа.

Уг журам батлагдсанаар засаг захиргаа, нутаг дэвсгэр, аж ахуйн нэгж байгууллага, салбарын хэмжээнд гамшгийн эрсдэлийн үнэлгээг гүйцэтгэх эрх зүйн боломж бүрдэж, гамшгийн эрсдэлийг нарийвчлан тодорхойлсноор гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн байдлыг сайжруулах нөхцөл бүрдэж байна.



Онцгой байдлын байгууллага Гамшгийн эрсдэлийн удирдлагын тогтолцоонд шилжих зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор 2019 онд төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтсүүдэд “Гамшгийн эрсдэлийн үнэлгээний асуудал эрхэлсэн мэргэжилтэн”-ий орон тоог бүтцийн шинэчлэлээр батлав.

“Гамшгаас хамгаалах тухай хууль”-ийн 50 дугаар зүйлийн 50.9-д “Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээ албан тушаалын үндсэн цалингийн 20 хувиас доошгүй байна” гэж заасан.



Энэхүү заалтыг хэрэгжүүлэх, Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд 2018 оны 12 дугаар сарын 19-ний Засгийн газрын хуралдаанаар 2006 оны 104 дүгээр тогтоолоор батлагдсан журмыг шинэчлэн онцгой байдлын байгууллагын алба хаагчдын албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг албан тушаалын сарын үндсэн цалингийн 20 хувиар тооцож олгохоор шийдвэрлэлээ.



Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 118 дугаар тушаалаар “Онцгой байдлын байгууллагын алба хаагчид онцгой гавьяа байгуулсан тохиолдолд мөнгөн урамшуулал олгох журам”-ыг батлууллаа.

Энэхүү журам батлагдснаар гамшиг, осол, аюулт үзэгдлийн бүс болон хүн, малын гоцхалдварт өвчний голомтод аврах, эмчлэх, сувилах, хор уршгийг арилгах, сэргээн босгох ажиллагаанд эр зориг, мэргэжлийн ур чадвар гарган оролцож, онцгой гавьяа байгуулсан алба хаагчийг тодруулах, мөнгөн урамшуулал олгох үйл ажиллагааг зохицуулах боломж бүрдэж байна.



Журам батлагдсанаас хойшхи анхны мөнгөн урамшууллыг 2018 оны үр дүнгийн хурлын үеэр алба хаагчдад олгосон бөгөөд НОБ-ын нийслэлийн Аврах анги-105-ын аврагч, ахлах ахлагч Х.Цогбадрах, Дорнод аймгийн Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах, аврах 52 дугаар ангийн аврагч, ахлах ахлагч Б.Эрхэмбаяр, Хөвсгөл аймгийн Онцгой байдлын газрын Эрэн хайх, аврах салбарын бүлгийн дарга, ахлах дэслэгч Х.Мөнхбат нар тус бүр 16 сая төгрөгийн мөнгөн шагнал хүртсэн юм.



Гамшгаас хамгаалах тухай хуульд заасны дагуу “Онцгой байдлын байгууллагын алба хаагчдад мэргэшлийн зэрэг, зэргийн нэмэгдэл олгох журам”-ыг Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 374 дүгээр тогтоолоор батлууллаа.

Журамд алба хаагчдаас жил бүр ерөнхий мэдлэг, бие бялдрын бэлтгэлжилтийн түвшин, сэтгэл зүй, тусгай бэлтгэлийн шалгалт авч, зэрэг олгож байхаар тусгасан.

Мэргэшлийн I, II, III гэсэн ангилалтай байх бөгөөд зэргийн нэмэгдлийг тухайн албан тушаалын сарын үндсэн цалингийн 5-15 хувиар тооцож олгох юм.



Аливаа гамшгийн үед мэргэжлийн аврах байгууллагын тусламж иртэл дийлэнх тохиолдолд иргэд өөрсдийгөө болон бусдыг авран хамгаалж, учирч болох эрсдэлийг бууруулж байгаа нь гадны улс орнуудад тохиолдсон гамшгийн байдал, түүнийг даван туулж байгаа туршлага, сургамж харуулж байна. Гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгийн үед аврах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд сайн дурын ажилтнуудын оролцох оролцоо, гүйцэтгэх үүрэг дэлхий нийтэд улам бүр өсөн нэмэгдсээр байна.

Шинэчлэн батлагдсан Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлд сайн дурын хэсгийн нэр томъёог шинээр оруулж, 24 дүгээр зүйлд сайн дурын хэсгийг гамшгаас хамгаалах хүч хэрэгсэлд хамааруулж, 32 дугаар зүйлд сайн дурын хэсгийг байгуулах асуудлыг, 36 дугаар зүйлд гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн эрх, үүрэг, нийгмийн баталгааг тусгасан. Мөн Галын аюулгүй байдлын тухай хуулийн 14 дүгээр зүйлд гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг байгуулах, санхүүжүүлэх, сайн дурын хэсгийн ажилтны нийгмийн хамгааллын асуудлыг тусгаснаар гамшгаас хамгаалах сайн дурын үйл ажиллагаа, сайн дурын хэсгийн эрх зүйн зохицуулалт, эрх, үүрэг тодорхой болсон байна.

Улмаар Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 24 дүгээр тушаалаар “Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны нийтлэг журам”-ыг шинэчлэн, 2019 оны 38 дугаар тушаалаар “Гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн үйл ажиллагааг санхүүжүүлэх, урамшуулал олгох журам”-ыг тус тус батлав.



Дээрх журмууд батлагдсанаар гамшгаас хамгаалах сайн дурын үйл ажиллагааг зохион байгуулах, гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэсэн хугацааны томилолт урамшуулал олгоход орон нутгаас тодорхой хэмжээний зардал гаргах, гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн ажилтны нийгмийн баталгаа хангагдах, гамшгийн эрсдэлийг бууруулахад олон нийтийн оролцоо нэмэгдэх нөхцөл бүрдэж байгаа юм.

Нийслэлийн 9 дүүрэг, 21 аймаг, сумдад гал унтраах болон гамшгаас хамгаалах сайн дурын хэсэг байгуулагдан гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.



Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 120 дугаар тушаалаар “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар”-ыг шинэчлэн батлав.

Энэхүү заавар нь “Аймаг, нийслэл, сум, дүүргийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар”, “Гамшгаас хамгаалах албаны төлөвлөгөө боловсруулах заавар”, “Байгууллага, аж ахуйн нэгжийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар” гэсэн гурван хэсгээс бүрдэж байгаа юм.




Заавар батлагдсанаар аймаг, нийслэл, сум, дүүрэг, улсын албад, аж ахуй нэгж, байгууллагууд болзошгүй аюулт үзэгдэл, ослын үед хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, удирдлага зохицуулалтыг оновчтой бодит нөхцөл байдалд нийцүүлэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагааны санхүүжилтыг шийдвэрлэх, гамшгаас хамгаалах чадавх сайжрах юм.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН
ЧАДАВХЫН ӨСӨЛТ




Онцгой байдлын байгууллага нь нэгдсэн тогтолцоонд шилжихдээ Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд Гамшгаас хамгаалах ерөнхий газар, Аврах тусгай анги, Хангалт үйлчилгээний анги, нийслэлийн, аймаг, дүүргийн Гамшгаас хамгаалах штаб, Гал унтраах ангиуд, Улсын нөөцийн салбарууд гэсэн ерөнхий бүтэцтэй байгуулагдаж байв.



Тэгвэл одоо Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд Онцгой байдлын ерөнхий газар, Аврах тусгай анги, Хангалт үйлчилгээний анги, Уул уурхайн аврах ангийг нэгтгэсэн Үндэсний аврах бригад, Гамшиг судлалын хүрээлэн, Давтан сургалт, сэргээн заслын төв, “Аврагч” биеийн тамир, техник

спортын хороо, нийслэлийн Онцгой байдлын газар, Бүсийн төвүүд, аймгуудын Онцгой байдлын газар, сум, дүүргүүдэд Онцгой байдлын хэлтэс, Гал түймэр унтраах, аврах ангиуд, Улсын нөөцийн салбаруудтайгаар өргөжин үйл ажиллагаагаа явуулж байна.





■ Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2013 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн А/304 тушаалаар Гамшгийн шуурхай удирдлагын газрын бүтцэд улсын хэмжээний гамшиг, аюулт үзэгдлийн мэдээ, мэдээллийг хүлээн авч үнэлгээ хийх, удирдлагыг мэдээллээр хангах, шуурхай удирдлагаар хангах, гамшгийн аюулыг зарлан мэдээлэх Гамшгийн шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төвийг байгуулж, нийт 20 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна.

2017 онд тус төвд сүүлийн үеийн дэвшилтэт технологи бүхий холбоо, зарлан мэдээллийн тоног төхөөрөмжийн шинэчлэлийг бүрэн хийж, үндэсний хэмжээнд гамшгийн үеийн удирдлага, зохицуулалтын системийг нэвтрүүллээ. Мөн Бүсийн төв Орхон, Ховд, Өмнөговь, Дорнод аймгуудад, 21 аймгийн Онцгой байдлын газруудад Шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төвийг байгуулж Онцгой байдлын ерөнхий газартай өндөр хурдны шилэн кабелийн нэгдсэн сүлжээнд холбогдож мэдээ, мэдээллийг шуурхай солилцох боломжийг бүрдүүлэв.



▶ Түүнчлэн Зэвсэгт хүчний жанжин штаб, Эрүүл мэндийн яам, Хил хамгаалах ерөнхий газрын шуурхай удирдлагын төвүүдтэй шууд холбогдож, мэдээ, мэдээллийг шуурхай солилцож байна. Цаашид тусгай чиг үүргийн байгууллагууд, зарим төрийн болон төрийн бус байгууллагууд нэгдсэн холболтод орж, харилцан мэдээлэл солилцоход техникийн бүрэн боломжтой болсон юм.



Газар хөдлөлтийн идэвхтэй бүсүүдэд суурилуулсан газар хөдлөлтийг мэдрэх 12 станцаас хүлээн авсан мэдээг Одон орон, геофизикийн хүрээлэнд боловсруулан Гамшгийн шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төвд дамжуулах ба хүчтэй газар хөдлөлт болох үед зарлан мэдээлэх систем автоматаар ажиллаж зарлан мэдээллийг богино хугацаанд (27-30 сек) хүргэх боломжтой.

■ Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх энэхүү нэгдсэн систем сансрын холбоо, богино болон хэт богино долгионы радио холбооны сүлжээг ашиглаж байна.



Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 325 дугаар тогтоолоор нийслэлийн Налайх дүүрэгт байрлах Уул уурхайн яамны харъяа Уул уурхайн аврах албыг Онцгой байдлын ерөнхий газрын харъяа Аврах тусгай ангитай нэгтгэсэн бол Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн 80 дугаар тогтоолоор Онцгой байдлын ерөнхий газрын харъяа Уул уурхайн аврах анги болгон өргөтгөсөн юм.

Тус анги нь анх 1951 онд Аврах команд нэртэйгээр байгуулагдаж, 1961 онд БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 633 дугаар тогтоолоор Уулын цэрэгжүүлсэн аврах анги болон өргөжин, 1995 оноос Газрын хэвлийн тухай хуулиар Уул уурхайн аврах алба нэртэйгээр үйл ажиллагаа явуулж байсан юм.



Уул уурхайн аврах ангийг ийнхүү нэгтгэснээр Онцгой байдлын байгууллагад Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн бүтээгдэхүүн болон газрын тос байгалийн хий олборлох, боловсруулах үйлдвэрүүд, ажлын байр нь хортой, хий, тоосны тэсрэх аюултай аж ахуйн нэгж байгууллагуудад гарч болох аливаа аваар ослоос урьдчилан сэргийлэхэд мэргэжлийн туслалцаа үзүүлэх, аюулгүй ажиллагааны байдалд мэргэжлийн хяналт тавьж холбогдох хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, осол аваргийн үр дагаврыг шуурхай арилгах чиг үүрэг нэмэгдсэн гэж хэлж болно.





■ 2018 оны 06 дугаар сарын 20 буюу Онцгой байдлын албаны өдрөөр Үндэсний аврах бригадын тугийг гардуулан өгсөн юм.

▼ Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 114 дүгээр тогтоолоор ОБЕГ-ын харъяа Аврах тусгай анги, Хангалт үйлчилгээний анги, Уул уурхайн аврах ангийг нэгтгэн гамшигаас хамгаалах үндэсний чадавхыг бэхжүүлэх, гамшигтай тэмцэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэх, орчин үеийн мэргэжлийн байгууллага болгон хөгжүүлэх зорилтын хүрээнд Үндэсний аврах бригад болгон шинэчлэн зохион байгууллаа.

Үндэсний аврах бригад нь ОХУ-ын Онц байдал, Иргэний хамгаалалтын яамны бүтцэд ажилладаг төв аврах бригад, БНСУ-ын Үндэсний аврах бригад-119 зэрэг бүс нутгийн ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын жишгээр улсдаа төдийгүй бүс нутаг, олон улсад эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд үүрэг гүйцэтгэх чадавхтай болох зорилт тавин ажиллаж байна.



Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, олон нийтийн оролцоотой гамшгийн эрсдэлийг бууруулах нөхцөлийг бүрдүүлэх, гамшгийн үеийн удирдлагын системийг нэвтрүүлэх зорилгоор Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн Б/442 дугаар тушаалаар Гамшгийн шуурхай удирдлага зарлан мэдээллийн төвийн бүтцэд “Орон зайн мэдээлэл, технологийн тасаг”-ийг байгуулав.



Тус тасаг нь орон зайн мэдээлэлд суурилсан гамшгийн сэдэвчилсэн зураг, орон зайн мэдээллийг өгөгдлийн сангийн нэгдсэн стандартын дагуу нэгтгэж гамшгийн орон зайн өгөгдлийн дэд бүтцийг байгуулах, гамшгийн орон зайн мэдээллийн системийг бусад салбартай холбон хэрэглээнд гаргах, мэдээллийг хадгалах, хамгаалах, уялдаа холбоог сайжруулах, олон нийтэд хүргэх, мэдээллийн ил тод байдлыг хангах чиг үүрэгтэй ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 282 дугаар тогтоолд ОБЕГ-ын харьяа Нохойн алба байгуулах заалт орсон бөгөөд 2017 оны улсын төсөвт зардал нь тусгагдсанаар Онцгой байдлын байгууллага Эрэлч нохойн албатай болов.

Нийслэлийн Онцгой байдлын газрын Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гал түймэр унтраах, аврах 65 дугаар ангийг түшиглэн анх байгуулагдаж 2017 оны 09 дүгээр сарын 20-нд нээлтээ хийсэн тус алба нь эдүгээ Үндэсний аврах бригадын харьяанд үйл ажиллагаагаа явуулж байна.



Эрэлч нохойн албатай болсноор 2018 онд Нохойн хөтөч, эрэлч нохой бэлтгэх “АНС-18” сургалтыг зохион байгуулж, Үндэсний аврах бригад, НОБГ-ын Аврах анги-105, бүсийн төвүүд, Булган, Сэлэнгэ, Хэнтий аймгаас нийт 10 алба хаагчийг нохойн хөтөчөөр, 10 албаны нохойг эрэн хайх, аврах чиглэлээр сургаж, дадлагажуулаад байна.

Онцгой байдлын байгууллага нь дунд түвшний олон улсын аврах багтай болох зорилтыг тавин ажиллаж байгаа бөгөөд Олон улсын аврах багтай болох гол шалгуурт эрэлч нохойн албатай байх ёстойг тусгасан байдаг юм.

Засгийн газрын 2016 оны 66 дугаар тогтоолоор Онцгой байдлын байгууллагын салбар нэгжийг баруун, зүүн, өмнөд, хойд, Улаанбаатар гэсэн таван бүсэд хувааж гамшгаас хамгаалах удирдлага, зохицуулалтыг бүсчилсэн хэлбэрт шилжүүлээ.



➤ Хойд бүсэд Архангай, Булган, Хөвсгөл, Дархан-Уул, Сэлэнгэ, Орхон, Төв аймгууд, Баруун бүсэд Баян-Өлгий, Говь-Алтай, Увс, Завхан, Ховд аймгууд, Зүүн бүсэд Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгууд, Өмнөд бүсэд Өмнөговь, Өвөрхангай, Баянхонгор, Өмнөговь, Дорноговь, Дундговь, Говьсүмбэр аймгууд багтан гамшигийн үеийн шуурхай удирдлага, зохицуулалтыг бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулж байна.



Хүний нөөцийн чадавх

Онцгой байдлын байгууллага байгуулагдсан цагаас алба хаагчдад мэргэжил олгох, мэргэшүүлэх, боловсролын зэрэг ахиулахад байнга анхаарч, сургалтад хамрагдах боломжийг нэмэгдүүлсээр ирсэн. Тухайлбал, дотооддоо ХСИС-ийн Онцгой байдлын сургууль, БХИС, Удирдлагын академи болон ОХУ-ын Гал эсэргүүцэх академи, Иргэний хамгаалалтын академи, Торжокийн политехникийн коллеж болон БНСУ, БНПУ, БНУУ, Япон улсуудад алба хаагчдыг сургаж, дадлагажуулж байна.

2018 оны байдлаар нийт алба хаагчдын 6 хувь нь ажиллахын зэрэгцээ суралцаж байна.



➤ Онцгой байдлын байгууллагад 2019 оны I улирлын байдлаар нийт алба хаагчдын 23.6 хувийг офицер, 63.8 хувийг ахлагч, 12.4 хувийг төрийн үйлчилгээний алба хаагч эзэлж байна.


“Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр”-ийг 2010 оноос хэрэгжүүлэн ажиллаж байна.



Хөтөлбөрийн хүрээнд алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ажиллаж, амьдрах ая тухтай орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгын хүрээнд төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын хэмжээнд нийслэлийн Хан-Уул дүүрэг болон Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Булган, Дорноговь, Дархан-Уул, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Завхан, Хэнтий зэрэг 11 аймагт 331 айлын орон сууцыг барьж, ашиглалтад орууллаа. Мөн нийслэлийн Баянзүрх дүүргийн 8 дугаар хороонд 300 айлын орон сууц, НОБГ-ын 72 айлын орон сууц, Өвөрхангай аймгийн Онцгой байдлын газрын Хархорин сум дахь Онцгой байдлын хэлтсийн алба хаагчдын 42 айлын орон сууцыг 2019 оны III улиралд ашиглалтад оруулахаар ажиллаж байна.



■ Нийт алба хаагчдаас түрээсийн байранд 6.5 хувь, түрээсний хашаа байшинд 1.1 хувь, байгууллагын орон сууцанд 5.6 хувь, хашаа байшинд 49.5, нийтийн орон сууцанд 34.6 хувь, айлд 1.7, айлын хажуу өрөөнд 0.4, хувийн хаусанд 0.6 хувь нь амьдарч байна.



➤ "Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын эрүүл мэндийг хамгаалах дэд хөтөлбөр"-ийг 2013 оноос хэрэгжүүлэн ажиллаж байна.

■ Хөтөлбөрийн хүрээнд алба хаагчдын эрүүл мэндийг дэмжих, бие бялдрыг хөгжүүлэх, албаны бэлтгэл, бэлэн байдлыг дээшлүүлэх аливаа өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношлогоонд тогтмол хамруулан, сэтгэлзүйн болон бие бялдрын танхимуудыг тохижуулж, байнгын бэлтгэл, сургуулилт хийх боломжийг бүрдүүлээд байна.



Мөн Онцгой байдлын байгууллагын хэмжээнд алба хаагчдад сэтгэлзүйн болон сэргээн заслын эмчилгээ, сувилгаа үзүүлэх амралт, сувиллын төв болох ОБЕГ-ын харьяа Давтан сургалт, сэргээн заслын төвийн "Онцгой Жаргалант" сувилал, Хөвсгөл аймаг дахь "Гүний усны сургалтын төв"-үүдийг байгуулсан нь алба хаагчдын эрүүл мэндийг хамгаалах нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр хийсэн томоохон ажил юм.

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 479 дүгээр тогтоолоор Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа Сэргээн засах, сувиллын цогцолборын Сувиллын хэсгийг Онцгой байдлын ерөнхий газарт балансаас балансад шилжүүлж, Засгийн газрын 2016 оны 66 дугаар тогтоолоор Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Давтан сургалт, сэргээн заслын төв байгуулав.



■ Давтан сургалт, сэргээн заслын төв нь анх 2015 онд Захиргаа, санхүү, үйлчилгээний алба, Сургалтын алба, Сэргээн заслын алба гэсэн гурван албатайгаар байгуулагдав.

Давтан сургалт, сэргээн заслын төв нь Эрүүл мэндийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн тушаалаар Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний технологи, чанарын шаардлагыг хангасан тухай 45/2018 дугаар гэрчилгээгээр Магадлан итгэмжлэгдсэн бөгөөд Эрүүл мэндийн сайдын 2017 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн А/234 дугаар тушаалаар батлагдсан сувиллын 60 орны зөвшөөрөлтэйгээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тасралтгүй үзүүлэн ажиллаж байна.




2017 оны 05 дугаар сарын 01-нээс эхлэн Хөдөлмөр халамжийн ерөнхий газрын Ахмад настанд хөнгөлөлттэй үнээр үйлчлэх эрх бүхий байгууллагын сонгон шалгаруулалтад орж тэнцэн ахмадуудад хөнгөлөлттэй эрхийн бичгээр үйлчилж эхэлсэн.



2017 оны 08 дугаар сарын 01-нээс эхлэн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын эрүүл мэндийн даатгалын бодлогын хэрэгжилтийн газартай гэрээ байгуулснаар Эрүүл мэндийн даатгал төлөгч иргэн бүрт даатгалын сангийн хөнгөлөлтийг эдлэх эрх нээгдсэн.

2018 онд Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн үндэсний төвөөс олгодог Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах шалгуур үзүүлэлтүүдийг ханган ХАБЭА-н сургалт зохион байгуулах эрх бүхий байгууллага болсон бөгөөд 2019 онд ISO 9001 олон улсын стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхээр ажиллаж байна.





■ Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын мэргэшлийн ур чадварыг дээшлүүлэх, сургаж дадлагажуулах, иргэд олон нийтэд гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа зохион байгуулах ажлуудыг эрчимжүүлэх зорилтын хүрээнд “Гүний усны сургалтын төв”-ийг 2018 онд байгуулав.



■ Хөвсгөл нуурын ай сав бүхий цогцолбор газрыг түшиглэн байгуулсан энэхүү сургалтын төвд жилдээ 200 гаруй мэргэжлийн усчин аврагчийг сургаж, бэлтгэх, 500-1000 иргэнд гамшгаас хамгаалах мэдлэг, дадлага олгох анхан шатны сургалт зохион байгуулах боломжтой юм.



Монгол Улсын Шадар сайд, Хууль зүй Дотоод хэргийн сайдын 2012 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 19/А/39 дүгээр тушаалаар Хууль сахиулахын их сургуулийн дэргэд Онцгой байдлын сургуулийг байгуулав.

➤ Онцгой байдлын сургуулийн анхны суурь 1990 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн НАХЯ-ны сайдын б/49 дүгээр тушаалаар НАХЯ-ны Цагдаагийн дээд сургуулийн бүтцэд нэг жилийн хугацаатай мэргэжлийн гал сөнөөгч бэлтгэх дамжааны сургалтыг явуулж эхэлсэнээр тавигдсан байдаг.

- 1991-2003 онд Дунд боловсролтой “Галын техникч”
- 2004-2007 онд Бакалаврын боловсролтой “ Эрх зүйч-галын ажилтан”
- 2008-2009 онд Дипломын дээд боловсролтой “Галын техникч”
- 2011 оноос Бакалавр боловсролтой “Онцгой байдлын байгууллагын ажил-эрх зүй” мэргэжлээр боловсон хүчин бэлтгэж байгаад 2013 оноос “Онцгой байдал-гамшгаас хамгаалах алба” мэргэжлээр
- 2016 оноос нөөцийн чиглэлээр “Эдийн засаг” мэргэжлээр,
- 2016 оноос “Онцгой байдал -гамшгаас хамгаалах алба” эчнээ 3, 5 жилийн сургалт;
- 2018 оноос Галын техникч мэргэжлийн дунд боловсролтой алба хаагчдад “Онцгой байдал-гамшгаас хамгаалах алба” D/103205/, 1,5 жилийн бакалаврын хөтөлбөрийн эчнээ ангийн сургалт,
- 2019 оноос ОБЕГ-ын захиалгаар богино хугацааны мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулж байна.



2013-2014 оны хичээлийн жилээс "Гамшиг судлал"-ын магистрын сургалтыг явуулж нийт 100 гаруй магистрын зэрэгтэй боловсон хүчин бэлтгэн, практик байгууллагад шилжүүлж, 2014 оноос Гамшиг судлалын докторын сургалтыг зохион байгуулан явуулж байна.

■ 2016-2017 оны хичээлийн жилд Хууль сахиулахын их сургуулийн Онцгой байдлын сургууль нь "Эдийн засаг, нөөцийн удирдлага"-ын тэнхим шинээр байгуулж, түүхэндээ анх удаа "Онцгой байдал-Гамшгаас хамгаалах алба" мэргэжлээр гурван жилийн эчнээгийн элсэлт авч эхэллээ.



2018-2019 оны хичээлийн жилээс ОБЕГ-ын захиалгат Гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын байцаагчийн мэргэжил дээшлүүлэх 30 хоногийн, Гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын байцаагчийн давтан 7 хоногийн, Гамшгийн эрсдэлийн удирдлагын мэргэжилтэн бэлтгэх 45 хоногийн сургалтын хөтөлбөрийг боловсруулж батлуулан "Гамшгийн эрсдэлийн удирдлагын мэргэжилтэн" бэлтгэх 45 хоногийн сургалтыг зохион байгууллаа.



■ 2018 онд Онцгой байдлын сургуулийн сургалтын үйл ажиллагааг дэмжих, багш нарын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, гадаад харилцааг өргөжүүлэх тал дээр хамтран ажиллахаар Онцгой байдлын ерөнхий газар Хууль сахиулахын их сургуулийн хамтын ажиллагааны "Санамж бичиг"-ийг шинэчлэн байгуулав.



Гадаад орны ижил төстэй их сургуулиудтай хамтын ажиллагааг хөгжүүлж ОХУ, БНСУ, Польш, Унгарулстай хамтран ажиллаж сонсогчдыг суралцуулан, сонсогчдын танилцах болон үйлдвэрлэлийн дадлагыг төв, орон нутгийн Онцгой байдлын анги байгууллагуудад ХСИС-ийн захирал, ОБЕГ-ын дарга нарын хамтарсан тушаал, удирдамжийн дагуу зохион байгуулж байна.

Үндэсний аюулгүй байдлыг хангах, болзошгүй гамшгийн аюулаас ард иргэдийн амь нас, эрүүл мэнд, өмч хөрөнгийг авран хамгаалах үүрэг хүлээдэг албан хаагчдын бие бялдрыг чийрэгжүүлэх, бэлтгэл, бэлэн байдал, мэргэжлийн ур чадвар, ажлын чадавхыг нэмэгдүүлэх, их спортын тамирчдын амжилтыг ахиулахад хүрэх нэг алхам нь албаны хэмжээнд биеийн тамир, спортын салбар нэгж байгуулсан явдал юм.

"Аврагч" биеийн тамир техник-спорт хороо нь Монгол Улсын Шадар сайдын 2009 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 08 тоот тушаалаар анх байгуулагдсан бол 2011 оны 10 дугаар сарын 21-нд Спортын ордонтой болсноор үйл ажиллагаагаа эхлүүлж, улмаар Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор "Аврагч" биеийн тамир техник-спорт хороо болж өргөжөөд байна.



■ Онцгой байдлын албаны "Аврагч" биеийн тамир спортын хорооны спорт заалны барилгын шав тавих ёслол. 2009 он



► Тус хороо нь Галын техникийн олон төрөлт спорт, аврагчдыг бэлтгэх, Онцгой байдлын албаны аварга шалгаруулах спортын тэмцээнийг Онцгой байдлын албаны ажил, мэргэжил, цэргийн биеийн тамирын стандартад тусгагдсан дасгал, нормативийг үндэслэн цэрэг, спортын төрөлд жил бүр уламжлал болгон зохион байгуулж, төрийн болон хувийн хэвшилд ажилладаг 1000 гаруй иргэдэд биеийн тамир, спортыг сурталчилах, хүн амын дунд нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байгаа билээ.



Спорт хороо нь 1843,8 м2 ам дөрвөлжин талбайтай оффис, чийрэгжилтийн танхим, болон олон улс, улсын хэмжээний тэмцээнийг зохион байгуулах боломжтой 256 хүний суудалтай спортын заалтай. Спорт заалаар жилд давхардсан тоогоор 30,000 мянга хүн үйлчлүүлж, спортын 10 орчим төрөлд 9,500 тамирчид тогтмол хамрагдан оролцож, Онцгой байдлын албаны алба хаагчдын дунд жилд 20 гаруй тэмцээнийг зохион байгуулж ажилладаг.

► "Аврагч" Биеийн тамир техник-спортын хороо нь Онцгой байдлын албаны алба хаагчдын ажил, үүрэг гүйцэтгэх бие бялдрын байнгын бэлэн байдлыг хангах, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, жудо бөх, чөлөөт бөх, буудлага, хүндийн өргөлт, бокс, волейбол, хөнгөн атлетик, үндэсний спортын төрлүүдийг хөгжүүлэн баг тамирчдаа дотоод, гадаад, олон улс, тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд амжилттай бэлтгэн оролцуулж өндөр амжилт гарган Монгол Улсын болон Онцгой байдлын албаны нэр хүндийг өндөрт өргөх зорилтыг тавин ажиллаж байна.



"Аврагч" Биеийн тамир техник-спортын хорооны баг тамирчид дотоодын болон олон улс, тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд өндөр амжилт гарган одоогийн байдлаар Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс жудо, самбо бөхийн төрөлд 10 алт, 8 мөнгө, 15 хүрэл медаль, Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнээс 12 алт, 4 мөнгө, 12 хүрэл медаль, Олон улсын тэмцээнээс 16 алт, 19 мөнгө, 11 хүрэл медаль, Галын техникийн олон төрөлт спортын Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд довтолгооны шатны төрөлд хүрэл медалийг хүртээд байна. Монголын бүх ард түмний спартакиад, улсын аварга шалгаруулах тэмцээнээс манай баг тамирчид 113 алтан медаль, 97 мөнгөн медаль, 81 хүрэл медалийг хүртээд байна.



Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсаны дагуу “Аюулгүй, амгалан Улаанбаатар” зорилтын хүрээнд 2014-2015 оны нийслэлийн хөрөнгө оруулалтаар “Нийслэлийн иргэдийг гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төв”-ийг 2016 онд шинээр байгууллаа.





Сургалт арга зүйн төв нь эмнэлгийн анхны тусламж үзүүлэх, утаат орчны дадлага хийх, өндрөөс аврах үйл ажиллагааны танхим, номын сан, газар хөдлөлтийн тусгай тоноглол бүхий танхим, үзвэрийн 3D бичил кино театр, хуралдааны танхим, бага хурлын танхим зэрэг нийт 52 өрөөтэй. Гамшгаас хамгаалах сургалт, дадлага зохион байгуулах, аврах дуудлагаар ажиллах аврах ангитай иж бүрэн цогцолбор байгууламж юм.

Тус төв нь нийслэлийн иргэдийн гамшгаас хамгаалах мэдлэгийг үе шаттайгаар дээшлүүлж, аливаа гамшгийг хохирол багатай даван туулах, олон нийтийн оролцоотой гамшгийн эрсдэл, эмзэг байдлыг бууруулах нөхцлийг бүрдүүлэн, нэг ээлжиндээ 150-200 хүний сургалт, дадлагыг зохион байгуулан ажиллаж байна.




Хүч, хэрэгсэл тоног төхөөрөмж

■ Өнгөрсөн 15 жилийн хугацаанд аврах, гал түймэртэй тэмцэх материаллаг бааз, хүч хэрэгслийн хувьд өсөн бэхжсээр байна. 2004-2019 онд Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор 25 Гал унтраах, аврах анги шинээр байгуулагдаж хүч хэрэгсэл 1000 гаруйгаар боловсон хүчнээр нэмэгджээ.

Гурван байгууллага нэгдэж нэгдсэн тогтолцоонд шилжсэн эхний жилүүдэд хүн нэг бүрийн хувцас хэрэгсэл, багаж зэвсэглэмж, техник, тоног төхөөрөмжөөр Онцгой байдлын албыг бүрэн хангахад тухайн үеийн хөрөнгө оруулалтаар явбал 113 жил шаардлагатай гэсэн тооцоо гарч байжээ.

Өнөөдрийн байдлаар тус байгууллагын гал унтраах, аврах тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмжийн хангалт 50.0 хувь, алба хаагчдын тусгай зориулалтын хувцас, багаж хэрэгслийн хангалт 30 хувь, холбоо, зарлан мэдээллийн техник хэрэгслийн хангалт 21.7 хувьтай байна.



▶ Онцгой байдлын байгууллага нэгдсэн тогтолцоонд шилжих үед буюу 2004 онд тусгай албаны 125 автомашинтай байсан бол сүүлийн 15 жилийн хугацаанд 100 гаруй автомашингаар нэмэгдэж гал унтраах бэлэн байдлын түвшин 30 гаруй, техникийн нөхөн хангалт 21.1 хувиар өсчээ. Түүнчлэн төв, орон нутгийн Онцгой байдлын газрын Гал унтраах, аврах 16 ангийг зориулалтын депотой болгож албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулсан байна.



■ Тухайн үед ашиглагдаж байсан тусгай албаны автомашины 60.8 хувь нь ОХУ-ын, 13.6 хувь нь Япон, 25.6 хувь нь Солонгос улсад үйлдвэрлэгдсэн автомашинууд байв.



2008 онд батлагдсан нийт 2.731 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар өмнө нь онцгой байдлын албанд ашиглагдаж байгаагүй гал унтраах үндсэн албаны 5 нэгж, ус тээвэрлэгч 3 нэгж техникийг худалдан авсан.

Мөн 508.8 сая төгрөгөөр БНСУ-ын Sancheong амьсгалын бие даасан төхөөрөмж, 48.4 сая төгрөгөөр ой, хээрийн түймэртэй тэмцэх гурван нэр төрлийн багаж хэрэгсэл, 61.6 сая төгрөгөөр аврах ажлын багаж хэрэгслийг тус тус худалдан авч байжээ.



2009-2010 онд батлагдсан нийт 3.922 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар албанд нэн шаардлагатай Галын үндсэн албаны автомашин АЦ-40 маркын 6 нэгж, Камаз АЦ 5-40 маркын галын үндсэн албан автомашин гурван нэгж, ус тээвэрлэгч автомашин гурван нэгж, шуурхай ажлын УАЗ маркын автомашин 14 нэгж, албанд өмнө нь ашиглагдаж байгаагүй дулаан мэдрэгч галын камер 3 ширхэг, усны өндөр даралтын буу 3 ширхэг, автомат шүхэр задлагч 30 ширхэг, Sancheong SCA-680 шахсан агаарын баг 240 ширхэг, бортого цэнэглэгч 4 ширхэгийг тус тус худалдан авсан байна.



2011 онд батлагдсан 4,520 сая төгрөгөөр гал унтраах үндсэн автомашин КАМАЗ АЦ-40 1 нэгж, аврах ажиллагааны автомашин 5 нэгж, хөдөлгөөнт удирдлагын автомашин 2 нэгж, хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл 15 нэр төрлийн 3000 гаруй, аврах ажиллагааны чиглэлийн 21 нэр төрлийн 10000 гаруй багаж, хэрэгслийг тус тус худалдан авснаар аврах ажиллагааны багаж хэрэгслийн хангалт 10 гаруй хувиар нэмэгдсэн байна.

Мөн 2012 оноос эхлэн холбооны хэрэгсэл түүний чадавхид илүү анхаарч богино долгионы станц 2, дахин дамжуулагч 2, хэт богино долгионы станц 4, хэт богино долгионы автомашины станц 6, хэт богино долгионы гар станц 20, байршил тодорхойлогч 6 ширхэгийг тус тус худалдан авсан.

Түүнчлэн гал сөнөөгчийн 300 ш иж бүрдэл хувцаснуудыг худалдан авсан бөгөөд энэ нь хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслийн хангалтыг 10 хувиар нэмэгдүүлсэн юм.



Тус аврах ажиллагааны багаж хэрэгсэл бетон бутлагч, зүсэгч иж бүрдэл нь дэлхийн тэргүүлэх Голланд улсын "HOLMATRO" брендийн багаж юм.



■ 2013 онд ОХУ, БНХАУ, Япон улсад үйлдвэрлэсэн галын үндсэн албаны автомашин, аврах ажлын бүрэн тоноглолтой автомашин, ковшоос гадна анх удаа газар уснаа явагч, аврах ажиллагааны бүрэн тоноглолтой катер завиар хангагдлаа. Жилийн аль ч улиралд байгаль, цаг агаарын ямар ч нөхцөлд явж үүрэг гүйцэтгэх онцлогтой газар уснаа явагчийг Увс, Хөвсгөл, Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газар хэлтэс, Нийслэлийн Аврах ангид хүлээлгэн өгөв.



■ Монгол Улсын Засгийн газар, Австри Улсын Засгийн газар хоорондын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд 2016 онд Монгол Улсад анх удаа евро стандартын техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, тусгай зориулалтын Розенбауер автомашиныг "Розенбауер интернэйшнл аг" компани нийлүүлсэн юм.

► Өнөөгийн байдлаар Гал түймэр унтраах аврах ангиудад MNS 6412:2013 стандартын дагуу гал унтраах тусгай зориулалтын 9 нэр төрлийн 498 автомашин байхаас 6 нэр төрлийн автомашин ашиглагдаж байна. Мөн гал унтраах, аврах тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмжийн хангалт 50.0 хувь, алба хаагчдын тусгай зориулалтын хувцас, багаж хэрэгслийн хангалт 30 хувь, холбоо, зарлан мэдээллийн техник хэрэгслийн хангалт 21.7 хувьтай байгаа боловч ойрын 5 жилийн төлөвлөгөөг боловсруулан хангалтын хувийг нэмэгдүүлэх боломжийг тухай бүр эрэлхийлэн ажиллаж байна.



Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар хоорондын нөхцөлт зээлийн хүрээнд санхүүжих "Онцгой байдлын байгууллагын гал түймэртэй тэмцэх техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх" төслийн хүрээнд БНПУ-ын Столарчик Мирослав Технологиа Пожарничка компаниас гал унтраах зориулалтын 3 төрлийн 15 ширхэг автомашин 2019 оны 2 дугаар улиралд нийлүүлэгдэнэ.

Өнөөдрийн байдлаар Онцгой байдлын албанд ашиглагдаж байгаа нийт тээврийн хэрэгслийн 36.8 хувь нь гал унтраах үндсэн болон туслах, тусгай албаны, 28.8 хувь нь шуурхай ажлын, 15.6 хувь нь хүн болон ачаа тээврийн, 11.4 хувь нь тусгай зориулалтын автомашин механизм, 0.7 хувь нь усан тээврийн зориулалтаар ашиглагдаж байна.



■ Холбоо, хангалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн, хошууч Ц.Отгондорж, мэргэжилтэн, хошууч А.Ганжаргал нар Онцгой байдлын албанд ашиглагдаж байгаа болон цаашид шаардлагатай бүх төрлийн аврах ажиллагааны зориулалттай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, автомашин, хувцас, багаж хэрэгслийн дэлгэрэнгүй тооцоо, судалгаа гаргаж, алба хаагчдын дүрэмт хувцас, техник, тоног төхөөрөмжийн норм, норматив, эдэлгээний хугацааг тогтоож, хүч хэрэгслийн чадавхыг анх удаа бодитоор тооцож гаргасан нь байгууллагын стратеги төлөвлөлтийг хийхэд суурь мэдээллээр хангах гол судалгааны материал болсон юм.

► Улсын иргэний хамгаалалтын газрын хэмжээнд 46 компьютер байсан бөгөөд үзүүлэлт нь интел-586-аас пентум-3 байв. Мөн газрын хэмжээнд 11 хэвлэгч, 1 скайнер, 1 проектортай байв.

Иргэний хамгаалалтын газрын төв байранд 24 хэрэглэгч компьютерийн дотоод сүлжээнд холбогдож байсан бөгөөд хэрэглэгчид интернэтэд холбогдохдоо сервер компьютерт share хийгдсэн Dial-Up 56 Kbps хурдтай модемоор дамжуулан холбогдож байлаа.

Интернэтийн сүлжээг Dial-Up холболтоос ADSL холболт руу 2006 онд шилжүүлж, 2009 оноос өнөөгийн шилэн кабелийн сүлжээг ашиглаж эхэлсэн байна.

Дотоод сүлжээнд 10 Mbps хурдтай сүлжээний салаалагч ашиглаж эхэлж байсан бол 2006 онд үзүүлэлтийг 100 Mbps хүртэл, 2010 оноос 1000 Mbps болгож хүчин чадлыг сайжруулж иржээ.

Байгууллагын электрон оффисын систем, вэб хуудсыг анх 2005 онд Холбоо мэдээллийн хэлтсийн мэргэжилтэн, ахмад Б.Баярбат, ахмад Б.Пүрэвням нар боловсруулан ашиглалтад оруулж байсан ба энэ нь өнөөгийн "Цахим бүртгэл, мэдээллийн систем"-ийн эхлэл болж байв.



■ 2019 оны 3 дугаар сарын байдлаар "Цахим бүртгэл, мэдээллийн систем"-д хүний нөөц, хувцас хангалт, сургалт, гамшгийн нөхцөл байдлын хоногийн мэдээ, гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын байцаагч нарын үйл ажиллагааны мэдээг боловсруулах дэд системүүдийн программ хангамжийг ашиглаж байна.

Радио холбоог сайжруулах талаар 2004 оноос ихээхэн анхаарч Австрали улсад үйлдвэрлэсэн овор хэмжээ багатай Barrett, Codan, Q-мас зэрэг орчин үеийн хүчин чадал сайтай MIL-STD-810F олон улсын стандарт хангасан радио холбооны хэрэгслээр үе шаттайгаар хангалт хийж байсан ч богино долгионы радио станцын хангалт, хүрэлцээ муу байсан учир Онцгой байдлын ерөнхий газрын дарга, "Мэдээлэл, холбооны сүлжээ" ТӨХК-ийн даргын 2013 оны хамтарсан тушаалаар багийн холбооны зориулалтаар ашиглагдаж байсан 314 иж бүрдэл бүхий IC-78 радио станцыг Онцгой байдлын албанд үнэ төлбөргүй шилжүүлэн авснаар богино долгионы радио станцын тоо 2013 онд 465 болж өссөн байдаг.



■ Сансрын холбооны NERA Worldphone болон BGAN сансрын холбооны станцыг 2002-2004 он хүртэл ашиглаж байгаад сансрын хиймэл дагуул нь ажиллахгүй болсон учраас хэрэглээнээс гарч, 2004 оноос 2 ширхэг Inmarsat станц ашиглаж байгаад 2006 оноос сансрын холбооны иридиум гар утсыг ашиглаж эхэлжээ.



■ "Шинэ болон сэргэн тархаж буй халдварт өвчинтэй тэмцэх, чадавхыг бэхжүүлэх" төслийн хүрээнд Тоёота Ландкрузер-200 загварын автомашинд бүх төрлийн холбоо, мэдээллийн тоног төхөөрөмжийг суурилуулан, гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэх боломжтой холбооны хөдөлгөөнт зангилгааг байгуулав.



■ Тухайн үед богино долгионы Ангара-1, Полоса, Ромашка, SBX-11A, IC-78 загварын нийт 27 ширхэг радио станц ашиглаж байв.

Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутаг дэвсгэрт 2007 оны 6 дугаар сард гарсан ой, хээрийн түймрийн голомтод үүрэг гүйцэтгэхээр явсан алба хаагчид нисдэг тэрэгний ослоор амь эрсэдсэн харамсалтай үйл явдал тохиолдсон.

Энэхүү үйл явдлын дараагаас сансрын холбооны гар утсаар хангахад ихээхэн анхаарч, "Мобиком" ХХК-аас 7, "Цайрт минерал" ХХК-аас 5 ширхэг иридиум гар утсыг бэлэглэж, орон нутгийн Онцгой байдлын байгууллагууд өөрсдийн нөөц хөрөнгөөр 22 ширхэг иридиум гар утсыг худалдан авч, 34 иридиум гар утастай болж байжээ. Одоо гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэж байгаа бие бүрэлдэхүүн иридиум гар утсаар байнгын мэдээлэл солилцож байна.

► Тухайн үеийн удирдлагын гэнэтийн шийдвэрээр үүрэг гүйцэтгэхээр томилогдсон бүлгийг холбоочин, холбооны хэрэгслээр хангаагүй ба Онцгой байдлын ерөнхий газрын хэмжээнд сансрын холбооны 1 иридиум гар утас байсныг Онцгой байдлын асуудал эрхэлсэн сайдын ажлын албанд ашиглаж байжээ.



Ойрзайндхолбоозохион байгуулах боломжтой Kenwood TK-278, TK-768, TK-2107, IC-RV 8050 зэрэг хэт богино долгионы гар болон суурин радио станц ашиглаж байсан ба нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд Соёлын төв өргөөний 12 дугаар давхарт КТ-820 загварын хэт богино долгионы дахин дамжуулах станцыг суурилуулж нийслэл хот орчмын гамшгийн голомтод ажиллаж байгаа бие бүрэлдэхүүнтэй холбоо зохион байгуулж, уг станцыг автомат телефон станцын шугамд холбон удирдлагын холбоог хангаж байв.



Хэт богино долгионы холбоо барих холын зайг нэмэгдүүлэх зорилгоор 2007-2014 онд дахин дамжуулах станцыг 21 аймагт, зарим томоохон суурин газарт суурилуулснаар холбоо барих холын зай аймгийн төвөөс 50 км-ийн алслалттай болж нэмэгдсэн.



■ Төвлөрсөн зарлан мэдээллийн төхөөрөмж 5Ф88-ыг ЗХУ-ын тусламжтайгаар 1975 онд суурилуулан ашиглаж байсан бөгөөд 1990-ээд оноос техник технологийн хувьд хуучирсан тул цаашид ашиглах боломжгүй болсон байв.

▼ Төвлөрсөн зарлан мэдээллийн системээс зөвхөн төгсгөлийн хэрэгсэл болох сирень дохионы төхөөрөмжийг гар удирдлагаар ажиллуулж зарлан мэдээллийг хүргэж байсан ба уг төхөөрөмж нь 2004 онд нийслэл Улаанбаатар хотод 17, аймгийн төвүүдэд тус бүр 1-2, нийт 40 орчим ашиглагдаж байв.



■ Монгол Улсын Засгийн газрын санхүүжилтээр 2012-2014 онд 2 үе шаттайгаар хэрэгжүүлсэн "Газар хөдлөлтийн гамшгийн аюулыг амжиж анхааруулах систем байгуулах" төслийн хүрээнд гамшгийн аюулыг зарлан мэдээлэх нэгдсэн системийг байгуулж, 2014 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр ашиглалтад орууллаа.

Онцгой байдлын албыг бэхжүүлэхэд үе, үеийн Засгийн газраас онцгой анхаарч хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлсээр ирсэн. Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын төсөв жил бүр нэмэгдэж, 2005 онд 13,4 тэрбум төгрөг, 2014 онд 83,1 тэрбум төгрөгийн төсөвтэй байсан бол 2019 онд 100 тэрбум 772 сая гаруй төгрөгийн төсөвтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

2005-2018 онд Улсын төсвийн 33.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 12 аймаг, нийслэлийн 4 дүүрэгт 1-р зэргийн хоёр, 2 дугаар зэргийн арав, 3 дугаар зэргийн найм, нийт 20 Гал түймэр унтраах, аврах ангийн барилга, улсын төсвийн 1.28 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Аврагч" спорт хорооны спорт заалны барилга, улсын төсвийн 4 тэрбум төгрөгөөр Улсын нөөцийн "Объект-03" салбарт өвс, тэжээлийн агуулах, 2000 тн-ын агуулахыг тус тус бариулж ашиглалтад оруулаад байна.



■ Анхны 28 алба хаагч 2012 оны 8 дугаар сарын 27-нд энхийг сахиулахаар эх орноосоо мордож байв. Алба хаагчдын 27 нь Өмнөд Судан улсад, 1 албан хаагч Хойд Судан улсад үүрэг гүйцэтгэсэн байна. Энхийг сахиулахын нэгдүгээр ээлжийг тухайн үеийн Аврах тусгай ангийн захирагчийн орлогч, штабын дарга Онцгой байдлын дэд хурандаа Б.Үнэнбаатар ахалж явсан юм.

Монгол Улсын хүчний байгууллагуудын хамтарсан анхны бие даасан батальон 2012 онд БНӨСУ-д НҮБ-ын Unmiss ажиллагаанд оролцсон юм. Тус энхийг сахиулах ажиллагаанд Монгол Улс 850 албан хаагчаа илгээсэн.

Онцгой байдлын байгууллагын алба хаагчид НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд 2012 оноос эхлэн тасралтгүй оролцож эхэлсэн билээ.



Эдүгээ нийт 230 гаруй алба хаагч дэлхийн энх тайвныг батлан хамгаалах ариун үйлсэд хүчин зүтгэж Онцгой байдлын алба төдийгүй Монгол Улсын нэр хүндийг олон улсад өндөрт өргөн үүргээ нэр төртэйгээр биелүүлж ирсэн.



■ Өнөөдрийн байдлаар Бүгд Найрамдах Өмнөд Судан улсад явагдаж буй НҮБ-ын мандаттай Энхийг сахиулах ажиллагааны VIII ээлжинд Онцгой байдлын албаны 26 алба хаагч үүрэг гүйцэтгэж байна.




■ Энхийг сахиулах ажиллагааны IV ээлжинд Өмнөд Судан улс дахь Мотобуудлагын 5 батальоны 3 дугаар ротын 2 дугаар салааны пулеметын тасагт үүрэг гүйцэж байсан ОБЕГ-ын харьяа Аврах тусгай ангийн Эрэн хайх, аврах салбарын усчин аврагч, ахлах ахлагч С.Эрдэнэбилэг 2016 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр НҮБ-ын ажилтнууд болон дотоодын дүрвэгсдийн хуаранд харуулын үүрэг гүйцэтгэж байхдаа сонор сэрэмжтэй ажиллаж, хошууч Ш.Мөнгөнсүхийн хамт хуарангийн ойрхон зэвсэг нуусныг илрүүлж, газар орноо болзошгүй аюулаас аварсан байна. Түүнд НҮБ-ын UNMISS ажиллагааны Хойд секторын командлал болон батальоны удирдлагууд баярласнаа илэрхийлж, шагнаж урамшуулсан юм.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ГАМШГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ,
ГАМШГААС ХАМГААЛАХ
ҮЙЛ АЖИЛЛАГАА



Онцгой байдлын байгууллага байгуулагдсан цагаас аливаа гамшиг осол, аюулт үзэгдлээс ард иргэдээ урьдчилан сэргийлэх, авран хамгаалах, хойшлуулшигүй сэргээн босгох үйл ажиллагаанд ямагт бэлэн байж, хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлж ирсэн билээ. Энэ хугацаанд Монгол Улсын хэмжээнд 2004-2018 онуудад аюулт үзэгдэл, осол нийт 55633 удаа гарч үүний улмаас 3146 хүн амь насаа алдаж, 8474 хүн хүнд, хөнгөн гэмтэж бэртэн 17.2 сая толгой мал хорогдож, 58.7 сая га талбай өртөж, ойролцоогоор 1 их наяд 264.4 тэрбум төгрөгийн шууд хохирол учирсан.



Үүнээс олон хүний амь эрсдэж, их хэмжээний хохирол учруулсан аюулт үзэгдэл, осол цөөнгүй тохиолдож байв. Тухайлбал, 2004-2018 онуудад цаг агаарын гаралтай аюулт үзэгдэл 1300 удаа тохиолдож үүний улмаас 320 хүн амь насаа алдан, 76 хүн бэртэж гэмтэн, 14.4 сая толгой мал хорогдож 61.4 тэрбум төгрөгийн хохирол учирч, хор уршгийг арилгах, сэргээн босгох ажилд 25215 хүн, 4207 техник хэрэгсэл ажиллаж, 17.6 тэрбум төгрөг зарцуулсан байна.



2008 оны 5 дугаар сарын 26, 27-ны өдөр сүүлийн 20 жилд ажиглагдаагүй онц хүчтэй цасан болон шороон шуурга болж Дорнод, Дорноговь, Говьсүмбэр, Сүхбаатар, Төв, Хэнтий аймгийн нутгаар 28-34 м/с, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан суманд 40 м/с хүртэл салхилсан. Цаг агаарын гамшигт үзэгдлийн улмаас 254 хүн төөрч сураггүй болсноос 202 хүнийг эсэн мэнд олж, 52 хүн (үүнээс 14 хүүхэд) нас барж, 362195 толгой мал хорогдож, 110 барилга байгууламжид гэмтэл учирч, 221 гэр нурж, цахилгаан дамжуулах агаарын шугамын 62 тулгуур багана, холбооны 668 тулгуур багана унаж, 758.7 сая төгрөгийн хохирол учирсан.

Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дундговь, Өвөрхангай, Өмнөговь аймгийн нутгаар 2009 оны 4 дүгээр сарын 22, 23-ны өдөр 18-36 м/с хүчтэй шороон болон цасан шуурга шуурсны улмаас Дундговь, Өвөрхангай, Өмнөговь аймгуудад 188 хүн сураггүй болсноос 180 хүнийг эсэн мэнд олж, 8 хүн осгож нас барсан.

Говь-Алтай аймгийн Цээл сумын Хүрэнгол багийн "Зүүнсалаа", Баянгол багийн "Өндөр" гэдэг газруудад 2009 оны 7 дугаар сарын 16-ны өдөр хүчтэй аадар бороо орсны улмаас 18 хүн нас барж, 12 гэр, 2 автомашин үерийн усанд урссан.



2009-2010 оны өвөл тохиолдсон зудад 18 аймгийн 175 сум (нийт нутаг дэвсгэрийн 80.9 хувь)-ын, 97.5 мянган малчин өрх нэрвэгдэж, 9.7 сая мал хорогдож, 526.0 тэрбум төгрөгийн хохирол учирсан ба гамшгийн хор уршгийг арилгахад 30.2 тэрбум төгрөгийг зарцуулсан. Түүнчлэн НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс 1.8 сая ам.доллар, Азийн хөгжлийн банкны Ази номхон далайн гамшигтай тэмцэх сангаас 3.4 тэрбум төгрөгийн тусламж үзүүлсэн.

■ 2009-2010 оны өвлийн зуд нь хамарсан хүрээ, орсон хур тунадас, цасны хэмжээ, хүйтний эрч, малын хорогдлын хэмжээгээрээ манай улсын түүхэнд 1944-1945 онд тохиолдож байсан зудаас илүү их хэмжээний хохирол учруулсан байдаг.

➤ Архангай аймгийн Хашаат сумын Номгон багийн нутаг "Хөөвөр" гэдэг газар 2014 оны 07 дугаар сарын 26-ны өдөр 10 км орчим зурвас газарт 8 см-ийн голчтой мөндөр орж, хүчтэй хар салхи үүссэний улмаас 1 хүн нас барж, 9 хүн гэмтэж бэртэн, 3 байшин, 5 гэр, 200 толгой мал, 3 автомашин тус тус өртөж сүйдсэн.

Байгалийн гамшигт үзэгдэл болсон голомтод аймгийн Онцгой комиссын шийдвэрээр Онцгой байдлын хэлтэс, Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Шүүхийн шинжилгээний алба, Ус, Цаг уур, орчны шинжилгээний алба, Мал эмнэлэг, үржлийн алба болон сумын Засаг даргын Тамгын газар зэрэг байгууллагын хамтарсан нийт 58 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг, 15 техник хэрэгсэлтэйгээр сэргээн босгох, хорогдсон малын сэг зэмийг устгах, хохирлыг эцэслэн тогтоох чиг үүрэгтэйгээр ажилласан байна.



■ Тухайн үед Хашаат сумын төвд 28 минутын турш мөндөр орж, салхины хурд 12 м/с хүрч байсныг бүс нутаг дахь ажиглагч мэдээлжээ. Хар салхины өргөн нь 300-400 м, урт нь 10 км орчим зурвас газар хамарснаас гадна хүмүүсийн харсанаар мөндөрийн хэмжээ теннисний бөмбөгний хэмжээтэй байсан аж.



2018 оны зун 13 аймгийн 35 сум, нийслэлийн 1 дүүрэгт тохиолдсон үерийн улмаас 8 хүн амь насаа алдаж, 72 хүн гэмтэж бэртэн, 5360 толгой мал хорогдож, 1831 га тариалангийн талбай мөндөрт цохигдон, 1824 айл өрхийн 535 гэр, 120 барилгын зоорийн давхар усанд автаж, 1678 хашаа нурж эвдрэн, цахилгаан дамжуулах агаарын шугамын 89 тулгуур багана унаж, 27 суудлын автомашин эвдэрч, үерт өртсөн 456 айл өрхийг аюулгүй газарт нүүлгэн шилжүүлж байв.



■ Тухайлбал, Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэрт 2018 оны 07 дугаар сар гарсаар 4 удаа орсон усархаг аадар борооны улмаас Өлгий сумын нийт 7 багийн 530 айл өрхийн 2500 гаруй хүн (хүүхэд 1636, өндөр настан 159, хөгжлийн бэрхшээлтэй иргэн 123) гамшигт нэрвэгдэж, 3 иргэн бэртэж гэмтэн, 287 байшин бүрэн нурж, 154 гэр, 819 хашаа усанд автсан бөгөөд хор уршгийг арилгах зардалд нийт 525.8 сая төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргасан байна.

Тус суманд тохиолдсон гамшгийн хохирлын нэгдсэн үнэлгээг гаргах ажлын хэсгийн гаргасан тооцоогоор 15.6 тэрбум төгрөгийн хохирол учирсан.

Баруун аймгуудын нутгаар 2018 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр салхины хурд 20-30 м/с, Говь-Алтай аймгийн Бугат сумын нутгаар 40 м/с хүртэл ширүүсч цасан болон шороон шуурга шуурсан. Цаг агаарын гамшигт үзэгдлийн улмаас 3 иргэн бэртэж гэмтэн, 235 гэр нурж, 1600 гаруй толгой бог мал шуурганд уруудаж, цахилгаан эрчим хүч дамжуулах агаарын шугамын 13 тулгуур багана унаж 4 аймгийн 52 суманд цахилгаан эрчим хүч тасарч, 27 барилгын дээвэр хийсч, 205 айлын хашаа, малын саравч нурсан бөгөөд эрэн хайх, аврах, хор уршгийг арилгахад төв, орон нутгийн Онцгой байдлын анги, байгууллага, нутгийн захиргааны байгууллага, "Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" ХК, түүний салбар нэгжийн нийт 828 хүн, 107 техник хэрэгсэлтэй ажиллаж Засгийн газрын нөөц хөрөнгөөс 1.4 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.



2004-2018 онуудад биологийн гаралтай аюулт үзэгдэл 1621 удаа тохиолдож үүний улмаас 48 хүн амь насаа алдан, 97961 мянган толгой мал хорогдож 12.3 тэрбум төгрөгийн хохирол учирч, хор уршгийг арилгах ажилд 25700 хүн, 5136 техник хэрэгсэл ажилласан байна.

Дорноговь аймгийн Алтанширээ, Айраг, Дэлгэрэх, Өргөн, Сайхандулаан сум, Дундговь аймгийн Баянжаргалан сум, Сүхбаатар аймгийн Асгат, Баяндэлгэр, Наран сумын нутагт 2004 оны 2 дугаар сард малын гоц халдварт шүлхий өвчин гарч 2468 толгой малыг зориудаар устгасан ба нийт 455.7 сая төгрөгийн хохирол учирсан.



Дорнод аймгийн Баянтүмэн суманд 2005 оны 8 дугаар сард малын гоц халдварт шүлхий өвчин гарч 235 малыг зориудаар устгаж, 1.2 тэрбум төгрөгийн хохирол учирсан.

Нийслэлийн Хан-Уул дүүргийн 11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 2006 оны 4 дүгээр сард Хөдөө аж ахуйн их сургуулийн Мал эмнэлэг, биотехнологийн сургуулийн сургалт, эрдэм шинжилгээний зориулалтын үхэр малын гоц халдварт шүлхий өвчнөөр өвчилж, нийт 24 малыг зориудаар устгаж, 150 сая төгрөгийн хохирол учирсан.



Манай оронд хонь, ямааны цэцэг өвчин анх 1930 онд оношлогдож, 1967, 1977 онуудад бүртгэгдэж, 2006-2007 онд дахин сэргэж 7 сумын 14 голомтод 978 хонь өвчилсэн байна. Ямааны цэцэг өвчин 2008 онд Дорнод аймгийн Хэрлэн суманд, 2013 онд хонины цэцэг Дорноговь аймгийн Хатанбулаг суманд гарсан.

Говьсүмбэр, Сүхбаатар, Төв, Хэнтий аймгийн зарим сумын нутаг дэвсгэрт 2007 оны 12 дугаар сарын 17-ны өдрөөс малын гоц халдварт хонины цэцэг өвчин гарч, 74 хонь үхэж, 265 малыг зориудаар устгаж, 11.4 сая төгрөгийн хохирол учирч Засгийн газрын нөөц хөрөнгөөс 539.6 сая төгрөгийн зардал гарчээ.



Хонины цэцэг өвчин 2015 онд Сүхбаатар аймгийн Баруун-Урт, Дарьганга, Онгон, Сүхбаатар, Халзан сум, Дорнод аймгийн Баянтүмэн, Булган, Матад сум, Хэнтий аймгийн Баян-Овоо сум, Дорноговь аймгийн Айраг, Өргөн, Сайхандулаан, Сайншанд, Замын-Үүд, Эрдэнэ, Улаанбадрах сум (4 аймгийн 16 сум)-анд тархаж 1431 мал өвчилснийг устгах, эрсдэл бүхий бүс нутгийн өвчлөмтгий мал сүргийг вакцинжуулах ажлыг зохион байгуулсан байна.

Уг өвчин 2016 онд Сүхбаатар аймгийн Сүхбаатар, Мөнххаан, Асгат, Түвшинширээ, Баяндэлгэр, Түмэнцогт, Баяндэлгэр, Халзан, Баруун-Урт сум, Хэнтий аймгийн Цэнхэрмандал, Дэлгэрхаан, Батноров сум, Дорнод аймгийн Баянтүмэн, Матад, Сэргэлэн, Хэрлэн сум, Төв аймгийн Баяндэлгэр, Мөнгөнморьт, Эрдэнэ, Баянчандмань, Сэргэлэн, Баянцагаан, Баян сум, Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэг (нийт 6 аймаг, нийслэлийн 42 сум, дүүрэг)-т гарч 6716 хонь өвчилсөнөөс 4422 хонийг устгасан.



Баян-Өлгий аймгийн Алтай, Сагсай сумын нутаг дэвсгэрт 2013 оны 6 дугаар сард мал, амьтны гоц халдварт шүлхий өвчин гарч 1286 малыг зориудаар устгажээ.



Монгол Улсад анх удаа 2016 онд Ховд аймгийн Мянгад, Дөргөн суманд бог малын мялзан өвчин гарч Баян-Өлгий аймгийн 1 сум, Говь-Алтай аймгийн 1 сум, Ховд аймгийн 11 сум, Увс аймгийн 2 сум, нийт 4 аймгийн 15 сумын 50 багийн 72 голомтод 83937 мал өвчилж, 12805 мал хорогдон, 102 малыг зориудаар устгажээ.



2004-2018 онуудад Монгол оронд хүний үйл ажиллагаатай холбоотой аюулт үзэгдэл 1968 удаа тохиолдож үүний улмаас 1753 хүн амь насаа алдан, 143 сая төгрөгийн хохирол учирч, хор уршгийг арилгах ажилд 21419 хүн, 3723 техник хэрэгсэл ажилласан байна.



Нийслэлийн Багануур дүүрэгт 2007 оны 12 дугаар сарын 30-ны өдрөөс 2008 оны 1 дүгээр сарын 1-нийг хүртлэх хугацаанд 32 хүн метилийн спиртэд хордож 15 хүн нас барсан тул "Азийн чоно" ХХК-ийн архины борлуултад хяналт тавьж, 8573 цэгээс 59369 лонх архи хурааж, 1609760 лонх архийг зарж борлуулахыг хориглож байлаа.



Дархан-Уул аймгийн Хонгор сумын төвд 2007 оны 4 дүгээр сард алтны агууламжтай хүдэр, шламнаас мөнгөн ус, натрийн цианид зэрэг химийн бодис ашиглан алт ялгах үйл ажиллагааг хууль бусаар явуулж, химийн бодисоор бохирдсон хаягдал усыг ил задгай асгаж байсны улмаас үүссэн хор уршгийг арилгах үйл ажиллагааг зохион байгуулж ус, хөрс, агаар дахь натрийн цианид, мөнгөн усыг зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл бууруулсан юм. Хонгор суманд үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан Онцгой байдлын асуудал эрхэлсэн сайд Засгийн газрын хуралдаанд 3 удаа, УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд 2 удаа мэдээлэл хийж байв.

Дээрх үйл явдлаас сургамж авч улсын хэмжээнд химийн бодис ашиглан үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд 2007, 2008 онд хяналт шалгалт хийж нийт 10 аймгийн 120 гаруй уст цэгт, 200 мянга орчим тонн хаягдал, шлам, 53 га талбай мөнгөн ус, цианидаар бохирдоод байгааг тогтоосон ба мөнгөн ус ашиглан алтны хүдэр боловсруулах үйл ажиллагаа явуулж байсан 145 тээрийг хураажээ.



Химийн хорт бодисоор бохирдсон шлам, ул хөрсийг саармагжуулах ажлыг зохион байгуулах комиссыг Засгийн газрын 2008 оны 127 дугаар тогтоолоор байгуулан шаардагдах зардлыг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргаж 2008-2009 онд нийт 9 аймгийн 37 сумын 230 цэгт хуримтлагдсан 131792 м³ буюу 197687 тонн шламыг булшилж, химийн бодисоор бохирдсон 128444 м² талбайн хөрсийг хуулж саармагжуулалт хийсэн.



Япон Улсаас 2011 онд оруулж ирсэн 23 автомашин, 2012 онд 22 автомашин, 2013 онд 20 автомашин, 2015 онд 3 автомашин, нийт 68 автомашинд цацрагийн бохирдол бууруулах, идэвхжил сулруулалт хийсэн байна.



Хөвсгөл аймгийн Мөрөн суманд үйл ажиллагаа явуулдаг "НИК" ХХК-ийн салбарын нийт 13250 литр шатахуун ачиж явсан хоёр автомашин "Хөвсгөл" нуурын мөсөн дээгүүр зорчиж яваад 2011 оны 2 дугаар сарын 8-ны өдөр Рэнчинлхүмбэ сумын 4 дүгээр багийн "Адуутын-Ам" гэдэг газар мөс цөмөрсний улмаас живсэн. Уг ослоос 2 хүн амьд гарч, 1 хүн нас барсан бөгөөд тус аймгийн Онцгой байдлын хэлтэс, Аврах тусгай ангийн аврагчид 8 хоног ажиллан 50 метрийн гүнээс осолдсон хүн болон автомашиныг гаргаж монголын цэнгэг усны 70 хувь, дэлхийн цэнгэг усны 0.4 хувь болох Хөвсгөл нуурын байгаль экологид учирч болох хохирлоос урьдчилан сэргийлсэн юм.



Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын нутаг дэвсгэр Алтай таван богд уулын "Хүйтэн"-ий оргилд авиралт хийж байгаад осолдсон 5 иргэнийг эрэн хайх ажиллагааг 2015 оны 7 дугаар сарын 13-16-ны өдрүүдэд зохион байгуулахад Онцгой байдлын ерөнхий газар, Аврах тусгай анги, нийслэлийн Аврах анги, Баян-Өлгий, Ховд аймгийн Онцгой байдлын газар, цагдаа, прокурор, шүүхийн шинжилгээний алба, Зэвсэгт хүчний 303 дугаар анги, Хилийн 0165, 0285 дугаар анги, Монголын уулын үндэсний холбооны нийт 70 хүн, 1 нисдэг тэрэг, 20 автомашинтай ажилласан. Уг ажиллагааг хурандаа Ц.Баттулга даргатай Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын хэлтэс богино хугацаанд амжилттай зохион байгуулан өндөр ууланд эрэн хайх ажиллагааны туршлага хуримтлуулсан юм.



2017 оны 10 дугаар сарын 22-ны өдөр Завхан аймгийн Отгон сумын нутаг дэвсгэр "Отгонтэнгэр" ууланд 27 хүний бүрэлдэхүүнтэй баг авиралт хийгээд буух явцад цасны хавтангийн гулгалт үүсч 17 хүн осолдсон.



Эрэн хайх ажиллагаанд Завхан, Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай, Увс, Ховд аймгийн Онцгой байдал, цагдаа, прокурор, шүүхийн шинжилгээ, мэргэжлийн хяналт болон нутгийн захиргааны байгууллага, Зэвсэгт хүчний 303, 325, 339 дүгээр анги, Гэмтэл согог судлалын үндэсний төв, аймгийн нэгдсэн эмнэлэг, "Алтай Улиастай эрчим хүч" ТӨХК, "Отгонтэнгэр" улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа, Монголын уулчдын үндэсний холбоо, "Юнител" ХХК, "Мобиком" ХХК, "Никпетровис" ХХК зэрэг байгууллагын 254 хүн, 43 автомашин, 2 нисдэг тэрэг, 77 цаг ажиллаж осолдогсдын цогцсыг хөлбөмбөгийн найман талбайг нийлүүлсэнтэй тэнцэх талбайд эрэн хайж, 2-8 метрийн зузаан цасны нуранги доороос олж гаргасан.

2018 оны 8 дугаар сард Дорноговь аймгийн Айраг сумын нутаг дэвсгэр дэх төмөр замын 747 дахь километр (Цомог-Айраг өртөө хооронд)-т төмөр замын суурь бүтэц үерийн усанд автсанаас Улаанбаатар-Сайншанд чиглэлийн 328 зорчигчтой галт тэрэгний цуваа осолдсон. Ослын хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд "Улаанбаатар төмөр зам" ХНН, Зам, тээврийн хөгжлийн яам, Онцгой байдлын ерөнхий газар, Дорноговь аймгийн онцгой байдал, цагдаа, эрүүл мэндийн болон нутгийн захиргааны байгууллага, Зэвсэгт хүчний 281, 336 дугаар ангийн 486 хүн, 106 автомашин, механизм ажиллаж богино хугацаанд сэргээн босгож, төмөр замын хөдөлгөөнийг хэвийн горимд шилжүүлсэн билээ.



Төв аймгийн Заамар сумын төвөөс баруун хойд зүгт 20 км-т орших Баянголын амны Ууцар гэдэг газарт 2019 оны 02 дугаар сарын 28-ны өдөр "Эко-Алтан Заамар" ХХК-ийн ашигт малтмалын олборлолтын 100 метр өргөн, 80 метрийн гүнтэй ил уурхайд нуралт болж зургаан хүн, КАТ-374 загварын эксковатор, КАТ-D-8-T загварын бульдозер дарагдсан осол гарсан. Уг осол болсон даруйд хоёр иргэнийг эсэнд мэнд гаргасан байв.



Ослын голомтод Онцгой байдлын байгууллага, Прокурор, Мэргэжлийн хяналт болон аймгийн Цагдаагийн газар, Шүүхийн шинжилгээний алба, "Эко-Алтан Заамар" ХХК-ийн нийт 207 хүн, 44 техник, хэрэгсэлтэйгээр есөн өдөр үүрэг гүйцэтгэж ажилласан. Нурангийн талбайд хөрсний усны ундрага ихтэй учир эрэн хайх ажиллагаа явуулах хүндрэлтэй байсан бөгөөд Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Үндэсний аврах бригадын усчин аврагчид мөстэй, шавартай усанд нийт 46 удаагийн шумбалт хийж, дөрвөн цогцсыг гаргаж, холбогдох мэргэжлийн байгууллагад хүлээлгэн өгсөн юм.



Япон улсад 2011 онд болсон хүчтэй газар хөдлөлт түүнээс үүдэлтэй цунамид нэрвэгдэгсдэд хандив тусламж үзүүлэх ажлыг УОК, ОБЕГ шуурхай зохион байгуулж, Монгол Улсын Засгийн газар, ард иргэдээс 2 сая долларыг Японы ард түмэнд дэмжлэг тусламж болгон өгсөн.



■ Гамшгийн үеэр Монгол Улсын Засгийн газраас Япон улсын цунамид өртсөн ард түмэнд туслах аврагчдыг илгээх шийдвэрийг гаргаж, Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар тухайн Онцгой байдлын ерөнхий газрын Гамшигтай тэмцэх газрын Шуурхай удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн хурандаа Ш.Ганболд, Аврах тусгай ангийн Эрэн хайх аврах бүлгийн дарга ахлах дэслэгч Ц.Эрдэнэбилэг, хүний их эмч дэслэгч Б.Ариунбат, аврагч химичин ахлах ахлагч Ю.Ганзориг, аврагч шүхэрчин О.Батбилэг, аврагч, ахлах ахлагч Ч.Ганзам, Х.Бямбадорж, С.Энхболд, Н.Цоггэрэл, Н.Хуягбаатар, Ж.Баяртогтох, ахлагч Ч.Бямбадорж нарын бүрэлдэхүүнтэй эрэн хайх, аврах, сэргээн босгох үйл ажиллагаанд үүрэг гүйцэтгэхээр 2011 оны 03 дугаар сарын 15-нд Япон улсыг зорьсон билээ.

➤ Энэхүү үйл явдал нь Онцгой байдлын байгууллагын аврагчид гамшиг болсон гадны улс оронд очиж үүрэг гүйцэтгэсэн анхны тохиолдол болсон төдийгүй Монгол Улс болон байгууллагын нэр хүндийг олон улсын тавцанд өндөрт өргөж, бие бүрэлдэхүүний мэргэжлийн ур чадвар дэлхийн хэмжээнд үнэлэгдэж, олон улсын хэмжээнд ажил үүрэг гүйцэтгэх чадвартай болсныг илтгэн харуулсан юм.

ОХУ-ын Бүгд найрамдах Буриад улсад гарсан ой, хээрийн түймрийн тархалт ихэсч, нөхцөл байдал хүндэрсэнтэй холбогдуулан Засгийн газрын шийдвэрээр Онцгой байдлын байгууллагаас түймрийг унтраах ажиллагаанд оролцох аврах бүлгийг 2015 оны 09 дүгээр сарын 03-нд ОХУ руу илгээсэн юм.



■ ОБЕГ-ын харьяа Аврах тусгай анги, Авто бааз, Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газрын 50 аврагчаас бүрдсэн тус багийг тухайн үеийн Аврах тусгай ангийн Агаар десантын 2 дугаар бүлгийн дарга, шүхрийн зааварлагч, онцгой байдлын ахлах дэслэгч Я.Сэргэлэн ахалж ажилласан юм. Аврагчид түймрийн голомтод гурав хоног ажилласан юм.

2004 - 2018 онд нийт 46167 удаагийн объектын гал түймрийн дуудлага ирж, гал түймэрт 925 иргэн өртөн нас барж, 604 иргэн түлэгдэж, гэмтэн, 116.4 тэрбум төгрөгийн хохирол учирчээ. Дээрх гал түймрийн аюулаас аврагч-гал сөнөөгчид 7436 хүний амь насыг аварч, төр, аж ахуйн нэгж, байгууллагын 314.5 тэрбум төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгаалсан байна. Энэ хугацаанд томоохон хохирол дагуулсан, олон хоног үргэлжилсэн гал түймрийн дуудлагууд цөөнгүй гарч, тухай бүрт Онцгой байдлын байгууллагын алба хаагчид үүргээ амжилттай биелүүлж ажиллаж ирлээ.

2006 онд Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 2-р хорооны нутаг дэвсгэрт "Алтжин" группын "Бөмбөгөр" худалдааны төвд гал гарсан нь томоохон дуудлагын тоонд багтаж байгаа юм. Уг гал түймрийг Нийслэлийн Онцгой байдлын газрын Аврах, гал түймэр унтраах арван дөрвөн ангийн 126 алба хаагч, 28 техник хэрэгсэлтэйгээр ажиллаж унтраасан.



Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 12 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах АНКО ХХК-ийн "Нарантуул-2" худалдааны төвд 2013.11.09-ний өдөр гарсан гал түймэрт нийслэлийн Онцгой байдлын газрын Аврах, гал түймэр унтраах дөрвөн ангийн 50 алба хаагч, найман техник хэрэгсэлтэйгээр ажиллаж унтраав.



■ Нийслэлийн Хан-Уул дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Говь” ХК-ийн үйлдвэрийн байранд 2017.06.14-нд гал түймэр гарч НОБ-ын Гал түймэр унтраах, аврах 14 анги, нийслэлийн Аврах анги, ОБЕГ-ын харьяа Аврах тусгай ангийн нийт 154 алба хаагч, 44 техник хэрэгсэлтэйгээр ажиллаж унтраасан. Гал түймэр гарсан объект нь төмөр бетонон дээвэртэй, дээгүүр нь 30 см орчим зузаантай шилэн хөвөн, хөөсөнцрөөр дулаалж, модоор давхарласан, 6-7 давхар хар цаасан хучлагатай байсан зэрэг нь гал тархан дэлгэрэх болон шатлага эрчимтэй явагдаж, унтраах үйл ажиллагаанд хүндрэл учруулж байсан.

Гал түймрийг газар авхуулалгүй, барилга доторх үйлдвэрийн тоног төхөөрөмж, бүтээгдэхүүн, эд зүйлсийг гал түймэрт өртөхөөс урьдчилан сэргийлж, бүрэн унтрааж чадсан.



■ Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 19-р хороо, Гоодойн зусланд хөрсний өнжмөл өвс шатаж байна гэсэн дуудлагаар Нийслэлийн Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах, аврах долоон анги, нийслэлийн Аврах ангийн нийт 124 алба хаагч, 18 техник хэрэгсэлтэйгээр 217 тонн ус, 1094,24 литр түлш зарцуулан унтраасан. Тус зусланд 30 айлын 15 га орчим газарт хөрсний өнжмөл өвс шатаж, эзэн холбогдогч нь тодорхойгүй 16 байшин, эзэн холбогдогч нь тодорхой долоон байшин, 6 ханатай гэр-1 тус тус шатаж, ард иргэдэд ихээхэн хэмжээний хохирол учирсан юм.

2004-2018 онд улсын хэмжээнд нийт 2651 удаагийн ой, хээрийн гал түймрийн дуудлага ирж, гал түймэрт 17 иргэн өртөж нас барж, 24 иргэн түлэгдэж, гэмтэн, нийт 11.2 сая га талбай түймэрт өртөж шатсан. 612.5 тэрбум төгрөгийн хохирол учирч, дээрх түймэрт Онцгой байдлын байгууллагаас 38495 алба хаагч, 15034 техник хэрэгсэлтэйгээр ажилласан байна.





■ 2017 онд Монгол Улсын хэмжээнд 14 аймгийн 75 сум, дүүрэгт 225 удаагийн ой, хээрийн гал түймэр гарч нийт 590 орчим мянган га талбай, түймэрт шатаж, 77 тэрбум сая төгрөгийн хохирол учирсан.

Түймрийг унтраахад Онцгой байдлын байгууллагаас 4020 албан хаагч, 402 автомашин, ХЦ, ЗХ-ний анги, байгууллагаас 896 албан хаагч, 61 автомашин, орон нутгаас 6703 иргэн, 744 автомашин, нийт 11.619 хүн, 1207 автомашин, 202 мотоцикль, 306 морьтойгоор ажилласан байна.

Түүнчлэн ард иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд хандивын аян өрнүүлж, 1.2 тэрбум төгрөгийн мөнгөн тусламж, техник, багаж төхөөрөмж, хүнсний бараа материалыг Онцгой байдлын байгууллагад хандивлаж, гал түймрийг унтраах ажиллагаанд сайн дураараа нэгдэн ажиллаж, тусламж дэмжлэг үзүүлсэн юм.




УЛСЫН ОНЦГОЙ КОМИСС

Улсын Онцгой комисс нь 1990 оны БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 5 дугаар сарын 25-ны өдрийн 276 дугаар тогтоолоор Улсын байнгын онцгой комисс, 2004 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн Засгийн газрын 34 дүгээр тогтоолоор Гамшигтай тэмцэх комисс, 2005 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн 183 дугаар тогтоолоор Улсын онцгой комисс /УОК/ хэмээн нэрлэгдэх болсон.



УБОК-ын даргын албыг 1990-1996 онд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн орлогч дарга, Монгол Улсын Шадар сайд, 1996-2004 онд Батлан хамгаалахын сайд, 2005-2007 онд онцгой байдлын асуудал эрхэлсэн Монгол Улсын сайд, 2007 оноос өнөөдрийг хүртэл Монгол Улсын Шадар сайд хашиж байна.



■ Комиссын ажлын албаны үүргийг Онцгой байдлын ерөнхий газар гүйцэтгэж, комиссын өдөр тутмын ажлыг орон тооны Нарийн бичгийн дарга эрхэлж байна.

Комиссын орлогч даргыг 1990-2004 онд Батлан хамгаалах яамны сайд, Улсын иргэний хамгаалалтын газрын дарга, Байгаль орчны сайд, 2004 оноос өнөөдрийг хүртэл Батлан хамгаалахын сайд, Эрүүл мэндийн сайд, Хүнс, хөдөө аж ахуйн сайд, Гамшгаас хамгаалах ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газрын дарга хашсаар иржээ.

Харин комиссын нарийн бичгийн даргын албыг 1990-2004 онд УИХГ-ын дэд дарга, 2004 оноос Гамшгаас хамгаалах ерөнхий газар /2005 оноос ОБЕГ гэх болсон/-ын хэлтсийн дарга давхар хашиж байгаад 2008 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн Засгийн газрын 11 дүгээр тогтоолоор Нарийн бичгийн даргын орон тоог эргүүлэн бий болгосон юм. Харин комиссын Ажлын албаны орон тооны мэргэжилтэнг 2010 оны 1 дүгээр сараас эхлэн томилжээ.



Улсын онцгой комиссын бүрэлдэхүүнийг үе үеийн Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний өөрчлөлттэй холбогдуулан өнгөрсөн хугацаанд Засгийн газрын тогтоолоор нийт 19 удаа шинэчилжээ.

Тухайн үеийн туйлширсан үзлээс болж комиссын гамшигтай тэмцэх үйл ажиллагааг шаардлагатай үед нэгдсэн, шуурхай удирдлагаар хангах, уялдуулан зохицуулах, тулгамдсан асуудлыг цаг хугацаа алдалгүй түргэн шийдвэрлэх зэрэг ажлын үндсэн зарчим алдагдахад хүргэсэн явдал ч гарч байсан юм.

Тухайлбал, 2004-2005 онд Засгийн газрын тогтоолоор Улсын байнгын онцгой комиссыг Гамшигтай тэмцэх комисс болгон өөрчилж, түүний дарга нь тодорхой нэг сайд биш харин гамшиг үүссэн салбарын сайд хариуцахаар болгон өөрчилсөн нь улс орны хэмжээнд тохиолдсон томоохон гамшиг, осол сүйрлийн үед ажлын хэсэг, түр комиссыг томилон ажиллуулахад хүргэж, энэ нь үүссэн асуудлыг бүрэн төгс шийдвэрлэлгүй хугацаа алдах, ажил удаашруулах, гамшгийн нөхцөл байдал, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар олон нийтэд янз бүрээр мэдээлэгддэг, зарцуулсан хөрөнгө болон хариуцлага хүлээх албан тушаалтан нь тодорхой бус, гамшгийн үед хэрэгжүүлэх эрх зүйн баримт бичиг байхгүй зэрэг дутагдал илэрхий ажиглагдах болжээ. Дээрх дутагдлаас сургамж авч 2005 оны Засгийн газрын 183 дугаар тогтоолоор Гамшигтай тэмцэх комиссыг Улсын онцгой комисс болгон өөрчилж, бүрэлдэхүүн, ажиллах дүрэм, журмыг шинэчлэн баталж, өнөөдрийг хүртэл үйл ажиллагаагаа амжилттай явуулж байна.



Улсын онцгой комиссоос Засгийн газарт оруулж шийдвэрлэсэн асуудлыг шуурхай хэрэгжүүлэх зорилгоор "Улсын онцгой комиссын ажиллах журам"-д холбогдох нэмэлт өөрчлөлтийг оруулж Засгийн газрын 2010 оны 284 дүгээр тогтоолоор батлуулснаар гамшгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, нэрвэгдэгсдэд тусламж үзүүлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажилд шаардагдах нэмэлт зардал болон бараа материал, тоног төхөөрөмжийг улсын нөөцөөс гаргах, буцаан нөхөн бүрдүүлэх зэрэг яаралтай авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх асуудлаар зөвхөн Сангийн яам, Хууль зүйн яамны саналыг нэн даруй авч Засгийн газрын хуралдаанд оруулж шийдвэрлүүлэхээр болсон.

Засгийн газрын шийдвэр гармагц түүнийг тухайн өдөрт нь багтаан албажуулж Сангийн яаманд хүргэх ажлыг Засгийн газрын хэрэг эрхлэх газар зохион байгуулж, шийдвэрлэсэн хөрөнгийг Сангийн яам ажлын 24 цагийн дотор холбогдох байгууллагуудад багтаан олгох арга хэмжээг авна гэж тусгасан нь Улсын онцгой комиссын ажлыг шуурхай явуулах үндсэн эрх зүйн баримт бичиг болсон юм.



Өнгөрсөн хугацаанд Монгол Улсад тохиолдсон гамшигт нэрвэгдсэн иргэдэд тусламж үзүүлэх, учирсан хохирлыг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд Засгийн газар, Улсын онцгой комисс нийт 173,4 тэрбум төгрөгийн хөрөнгийг зарцуулаад байна. Үүнийг он дарааллаар нь үзвэл, 1990-2004 онд 42,5 тэрбум, 2005-2007 онд 2,8 тэрбум, 2008-2018 онд 128,1 тэрбум төгрөг болно.

Энэ хугацаанд гарсан томоохон гамшгаас дурдвал, 2008 оны 5 дугаар сарын 26, 27-ны өдрүүдэд сүүлийн 20 гаруй жилд ажиглагдаагүй онц хүчтэй салхи, шуурга шуурсаны улмаас 52 хүн /14 хүүхэд/ осгон нас барж, 362195 толгой мал хорогдсон.

УИХ-ын 2008 оны 50 дугаар тогтоолоор 5 дугаар сарын 31-ний өдрийг улс орон даяар гашуудлын өдөр болгон зарлаж, Засгийн газрын 2008 оны 201 дүгээр тогтоолоор төрийн далбааг 45 хэм бөхийлгөж, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахыг хориглов. Улсын Онцгой комисс талийгаачдын ар гэрт тусламж үзүүлж, орон гэргүй болсон өрхүүдэд улсын нөөцөөс 1663 гэр олгож, энэхүү гамшгийг даван туулахад Засгийн газрын нөөц сангаас 649,2 сая төгрөгийг гаргуулж байв.



Мөн 2009 оны 10 дугаар сард H1N1 вирус халдварын улмаас 32 хүн нас барсан явдал, 2009-2010 онд 15 аймгийн 80 сумыг хамарч, 9,9 сая мал хорогдсон зудын гамшиг, 2010, 2012, 2014 онд зүүн аймгуудад гарсан мал, амьтны гоц халдварт шүлхий өвчин, 2012 оны Дорнод аймагт гарсан гал түймрийн үеэр онцгой байдлын албан хаагчид амь насаа алдсан харамсалтай хэрэг, 2014 онд Архангай аймгийн Хашаат сумын нутаг дэвсгэрт болсон догшин хуй салхины аюул, 2012, 2015 оны зүүн аймгуудад гарсан ой, хээрийн түймэр, 2017 онд Отгонтэнгэр ууланд осолдсон 17 иргэнийг эрэн хайх ажиллагаа, 2018 онд тохиолдсон үерийн аюул зэрэг гамшгийн үед Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комисс, аймаг, нийслэлийн Онцгой комисс, онцгой байдлын алба, үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд, бусад мэргэжлийн байгууллагууд учирсан аюулыг даван туулах чиглэлээр бүхий л боломжит арга хэмжээг шуурхай зохион байгуулж, нэрвэгдэгсдэд тусламж үзүүлэх, сэргээн босгох ажлыг амжилттай зохион байгуулсан юм.

Аймаг, нийслэлийн Онцгой комисс Улсын онцгой комиссоос батлан гаргасан "Аймаг, нийслэлийн Онцгой комиссын үлгэрчилсэн журам"-ыг үндэслэл болгон үйл ажиллагаагаа явуулж байна.

Эхний шатанд өөрийн харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд тохиолдсон гамшгаас хамгаалах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгоход шаардлагатай хөрөнгийг Засаг даргын нөөц сангийн хөрөнгөөс зарцуулдаг. Энэхүү хөрөнгө нь дууссан тохиолдолд Улсын онцгой комисст зардлын тайлан, нэмэлт санхүүжилт авах тухай хүсэлтээ ирүүлсний эцэст шаардлагатай хөрөнгийн асуудлаа шийдвэрлүүлж байна.



2012 оноос эхлэн аймаг, нийслэлийн Засаг даргын нөөц санд жил бүр дунджаар 11,6 тэрбум төгрөгийн хөрөнгийг гамшигийн хохирлыг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээ, цаг үеийн шинжтэй зарим асуудлыг шийдвэрлэхэд зарцуулж, гамшгаас хамгаалах сангийн зарцуулалтад Сангийн яам, Улсын онцгой комисс хяналт тавин ажиллаж байна. Сүүлийн 5 жилийн хугацаанд гамшигтай тэмцэх үйл ажиллагаанд аймаг, нийслэлийн Засаг даргын нөөц хөрөнгөөс нийт 22,1 тэрбум төгрөгийг зарцуулжээ.



ТАВДУГААР БҮЛЭГ

ХҮМҮҮНЛЭГИЙН ТУСЛАМЖ, СЭРГЭЭН
БОСГОХ АЖИЛЛАГАА





Улсын нөөцийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх, бараа, материалын нэр төрөл, тоо хэмжээг шинэчлэн тогтоох, бүрдүүлэх, хадгалах, хамгаалах, зарцуулах, төвлөрүүлэн удирдах хариуцлагатай үүргийг 1977 оноос БНМАУ-ын Улсын төлөвлөгөөний комиссын Улсын материал-техникийн хангамжийн хороонд улсын дайчилгааны нөөц хариуцсан Тусгай хэлтэс, 1981 оноос Материал-техникийн хангамжийн улсын хороо, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтөөс хамааран 1988 оноос Эдийн засгийн гадаад харилцаа, хангамжийн яам, 1990 оноос Худалдаа, хамтын ажиллагааны яамны Тусгай хэлтэс, Худалдаа, үйлдвэрийн яамны Үйлдвэр, техникийн хэлтэс тус тус хариуцан ажиллаж байв.

Монгол Улсын Их Хурлын 1996 оны 40 дүгээр тогтоол, Засгийн газрын 1996 оны 314 дүгээр тогтоолоор Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага болох Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Улсын нөөцийн газар (хэрэгжүүлэгч агентлаг)-ыг 1996 оны 9 дүгээр сарын 20-нд байгуулж, төрөөс явуулах улсын нөөцийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх болжээ.



Харин 2004 онд Онцгой байдлын байгууллага нэгдсэн тогтолцоонд шилжсэнээр Онцгой байдлын ерөнхий газрын Улсын нөөцийн газар дээрх үүргийг гүйцэтгэх болсон бөгөөд Засгийн газрын 2014 оны 387 дугаар тогтоол, Монгол Улсын Шадар сайдын 2015 оны 4 дүгээр тушаал, 2017 онд шинэчлэн батлагдсан "Гамшигаас хамгаалах тухай хууль"-ийн дагуу Онцгой байдлын ерөнхий газрын бүтцэд улсын нөөцийн асуудал хариуцсан нэгжид дотоод, гадаадын хүмүүнлэгийн тусламж хүлээн авах, хадгалах, зохицуулах чиг үүргийг нэмж тусгаснаар Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн газар нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Онцгой байдлын байгууллага байгуулагдсан 15 жилийн хугацаа нь улсын нөөцийн хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгоход томоохон өөрчлөлтийг хийсэн он жилүүд байлаа.



Улсын Их Хурлын 2007 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаар Улсын нөөцийн тухай хууль хэлэлцэгдэн батлагдсан нь улсын нөөцийн бараа, материалыг бүрдүүлэх, хадгалах, тээвэрлэн хүргэх, шинэчлэх, захиран зарцуулах, санхүүжүүлэхтэй холбогдсон харилцааг анх удаа хуулиар зохицуулах нөхцөл бүрдсэн түүхэн тэмдэглэлт үйл явдал болсон билээ.



Улсын нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор УИХ-ын 2008 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 30 дугаар тогтоолоор "Стратегийн нөөцийн бараа, материалын нэр төрөл батлах тухай", Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 199 дүгээр тогтоолоор "Нөөцийн бараа, материалыг хүлээн авах, хадгалах,

шинэчлэх, хэвийн хорогдол тооцох журам", "Гамшгийн нөөцөөс бараа, материал захиран зарцуулах, нөхөн бүрдүүлэх журам", Монгол Улсын Засгийн газрын 3 удаагийн маш нууц тогтоолоор улсын нөөцийн бараа, материалын байршил, нэр төрөл, тоо хэмжээг тус тус батлуулан мөрдлөгө болгон ажиллаж байна.

Өнгөрч буй 15 жилд улсын нөөцөөс Монгол Улсын хэмжээнд тохиолдсон гамшгийн хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд 197.7 сая төгрөгийн хүнсний бараа, материал, 32.1 тэрбум төгрөгийн 105.6 мян.тонн өвс, 81.2 мян.тонн тэжээл, 1.18 тэрбум төгрөгийн 977 гэр, 2.9 тэрбум төгрөгийн 256 автомашин, 8.4 тэрбум төгрөгийн эрчим хүчний тоног төхөөрөмж, дулаан хувцас хэрэглэл, 228.3 сая төгрөгийн 248.89 тонн шатахуун нийлүүлэх ажлыг зохион байгуулсан байна.



■ Нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, зах зээл дэх барааны эрэлт нийлүүлэлтийг тэнцвэржүүлэх хүрээнд газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжихэд 22.2 тэрбум төгрөгийн 41,290.43 тонн үр тариа, 2.5 тэрбум төгрөгийн 2,944.87 тонн шатахуун, агаарын тээврийн хэвийн үйл ажиллагааг хангахад 330.7 сая төгрөгийн 700.0 тонн онгоцны түлш, газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангахад 20.11 тэрбум төгрөгийн 11,086.27 тонн шатахуун, нийт 90.4 тэрбум төгрөгийн бараа, материалыг улсын нөөцөөс Засгийн газрын шийдвэрээр олгох үүргийг гүйцэтгэв.



Улсын нөөцөөс зарцуулсан бараа, материалыг нэр төрлөөр нь авч үзвэл улс орны хэмжээнд тохиолдсон ган, зуд, хүчтэй цасан болон шороон шуурга, гал түймэр, үер ус зэрэг байгалийн гамшигт үзэгдлийн хор уршгийг арилгах, гамшигт нэрвэгдсэн ард иргэдэд 68.6 мянган тонн гурил, 47.8 мянган тонн цагаан будаа, 7.5 мянган тонн шар будаа, 4.9 мянган тонн элсэн чихэр, 11 кг хуурай сүү, 2.3 тонн ногоон цай, 5.0 тонн давс, 6.4 тонн лаа, 48.2 мянган ширхэг лаа, 1.3 тонн ургамлын тос, 14.6 тонн махан нөөш, 845.0 тонн үхрийн мах, 7042.0 мянган ширхэг цэвэр ус буюу нийт 197.79 сая төгрөгийн хүнсний болон өргөн хэрэглээний бараагаар хангах үүргийг гүйцэтгэсэн болно.

▶ Шатахууны хомсдолт байдал, “Атрын 3 дугаар аян”-ыг эхлүүлэх, байгалийн гамшиг ослын үед шаардлагатай хоол хүнс, хүч хэрэгсэл, бараа, материалыг тээвэрлэн хүргэх зэрэг улс орны өмнө тохиолдсон хүндрэл бэрхшээлийг даван туулахад Монгол Улсын Засгийн газрын 10 удаагийн шийдвэрээр улсын нөөцөөс 23.2 тэрбум төгрөгийн 14.9 мянган тонн газрын тосны бүтээгдэхүүн ханган нийлүүлсэн байна.





Төрөөс газар тариалангийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах, хүн амын хүнсний стратегийн нөөцийг нэмэгдүүлэхэд зориулан давхардсан тоогоор 1200 гаруй аж ахуйн нэгж, иргэдэд Засгийн газрын 16 удаагийн шийдвэрээр 22.1 тэрбум төгрөгийн 40.6 мянган тонн таримал ургамлын үр нийлүүлэх ажлыг зохион байгууллаа.

Гамшгийн хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд зориулан Монгол Улсын Засгийн газрын 67 удаагийн тогтоолоор нийт 1.1 тэрбум төгрөгийн 977 иж бүрэн гэр, 2.9 тэрбум төгрөгийн 256 автомашин, 8.4 тэрбум төгрөгийн 19 иж бүрэн эрчим хүчний тоног төхөөрөмж болон хүн болон малын эм, био бэлдмэл, малын вакцин, ариутгал халдваргүйжүүлэлтийн бодис, дулаан хувцас хэрэгсэл зэрэг нийт 12.4 тэрбум төгрөгийн үйлдвэрлэл-техникийн бараа, материалыг зарцуулсан байна.



Өнгөрсөн түүхийн хугацаанд мал аж ахуйд тулгарсан зудын гамшгийн хор уршгийг арилгахад **3.5** тэрбум төгрөгийн 29.9 мянган тонн өвс, **6.2** тэрбум төгрөгийн 33.8 мянган тонн тэжээлийг бэлэн мөнгөөр, 255.9 сая төгрөгийн **5.3** мянган тонн өвс, 193.0 сая төгрөгийн 1.7 мянган тонн тэжээлийг зээлээр, **9.8** тэрбум төгрөгийн 50.7 мянган тонн өвс, 321.2 сая төгрөгийн 1.7 мянган тонн тэжээлийг үнэгүй, 2.5 тэрбум төгрөгийн 19.6 мянган тонн өвс, 9.2 тэрбум төгрөгийн **43.8** мянган тэжээлийг үнэ хямдруулан нийт **32.1** тэрбум төгрөгийн 186.8 мянган тонн өвс, тэжээлийг улсын нөөцөөс малчин иргэдэд олгосон байна.



ГАДААД УЛС ОРНУУДААС ҮЗҮҮЛСЭН ХҮМҮҮНЛЭГИЙН ТУСЛАМЖ

Монгол Улсад тохиолдсон байгаль, цаг уурын хүндрэл, бэрхшээлийг даван туулахад зориулан 2009 онд ОХУ, БНХАУ, Турк, Энэтхэг, БНКазакстан, Итали, БНФилиппин зэрэг гадаад улс орнууд болон Азийн хөгжлийн банк, НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөр, Хүнс хөдөө, аж ахуйн байгууллага, Хүүхдийн сан, Дэлхийн зөн, Швейцарын хөгжлийн хамтын ажиллагааны агентлаг зэрэг Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй олон улсын аж ахуйн нэгж байгууллага, иргэдээс нийт 31.1 тэрбум төгрөгийн бараа, материал болон мөнгөн хэлбэрээр тусламж үзүүлснийг хүлээн авч Улсын Онцгой комиссоос гаргасан хуваарийн дагуу Монголын Үйлдвэрчний холбоо, Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг, бусад төрийн болон төрийн бус байгууллагын хяналтан дор хуваарилан иргэд, малчдад олгох ажлыг зохион байгууллаа.



ДОТООДЫН ХҮМҮҮНЛЭГИЙН ТУСЛАМЖ



2009-2010 онуудад тохиолдсон зудын гамшигт дотоодын төрийн болон төрийн бус байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газар, их дээд, ерөнхий боловсролын сургууль, аж ахуйн нэгж, иргэдээс Монгол Улсын хэмжээнд тохиолдсон зудын гамшгийн үед 870.0 сая төгрөгийн мөнгөн болон эд материалын, 2017 онд Төв, Сэлэнгэ, аймгийн нутаг дэвсгэрт гарсан ой хээрийн түймрийг унтраах, түймрийн голомтонд ажиллаж

байгаа алба хаагчид болон ард иргэдэд туслалцаа үзүүлэх зорилгоор иргэдийн санаачлагаар эхлүүлсэн сайн дурын аяны хүрээнд 832 аж ахуйн нэгж иргэдээс 1403.0 сая төгрөгийн бэлэн мөнгө, 99 аж ахуйн нэгж байгууллага, иргэдээс 62 нэр төрлийн 425.02 сая төгрөгийн эд материалын хандив ирүүлснийг Улсын Онцгой комиссоос баталсан хуваарийн дагуу олгох ажлыг зохион байгуулсан.



■ МУГЖ С.Жавхлан, МУГЖ Г.Баясгалан нар хамтран “Илгээлтийн эзэд” хандивын аяныг санаачлан зохион байгууллаа.



МОНГОЛ УЛСААС ГАДААД ОРНУУДАД ҮЗҮҮЛСЭН ХҮМҮҮНЛЭГИЙН ТУСЛАМЖ

Монгол Улс гадаад улс орнуудад гамшгийн нөхцөл байдал үүссэн үед Монголын ард түмний нэрийн өмнөөс Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр хүмүүнлэгийн тусламж үзүүлж байсан юм. Тухайлбал, террорист халдлагад өртсөн ОХУ-ын Беслан хотын иргэдэд 10,3 сая төгрөгийн эм, тариур, газар хөдлөлтөд өртсөн Япон улсын

иргэдэд 10,0 сая төгрөгийн ноосон хөнжил, БНХАУ-ын Цинхай мужийн ард түмэнд 50.0 мян.ам доллар, Иракийн ард түмэнд 100 ширхэг ноосон хөнжил, БНАСАУ-д болсон үерийн гамшигт нэрвэгдсэн ард иргэдэд 40 сая төгрөгийн 500 ширхэг хөнжил, 200 ширхэг дулаан хувцсыг хүмүүнлэгийн тусламжаар олгожээ.



Улсын нөөцийн талаар баримтлах бодлого, стратеги болон удирдлагын талаар судалгаа хийж зөвлөмж гаргах, бараа материалын бүрдүүлэлт, тэдгээрийн хадгалалтын нөхцөл, бүтээгдэхүүний чанар байдалд туршилтын эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх зорилгоор Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар Гамшиг судлалын хүрээлэнгийн дэргэд Улсын нөөц судлалын төвийг 2018 онд шинээр байгуулан ажиллаж байна. Тус төв нь тэжээлийн үйлдвэр, сорт сорилын гэсэн хоёр хэсэгтэйгээр үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Төв аймгийн Жаргалант сумын нөөцийн салбарыг түшиглэн, тэжээлийн үйлдвэрийг байгуулав.



Гамшгийн нөхцөл байдал үүссэн үед малчдад өртөг багатай, малын тэжээлээр хангах зорилгоор “Байгалийн эрдэст багсармал тэжээл”-ийн үйлдвэр-ийг байгуулан ажиллаж байна. Таримал ургамлын үрийн сортыг Увс аймгийн Баруунтуруун сум, Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Шар тал, Булган аймгийн Сэлэнгэ сум, Сэлэнгэ аймгийн Орхонтуул сум, Төв аймгийн Жаргалант сумдад тариалан, анхны ургацаа аваад байна.

Улсын нөөцийн бараа, материалыг технологийн дагуу хадгалах, хамгаалах, агуулахын аж ахуйг орчин үеийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хөгжүүлэх, сүүлийн үеийн техник технологи нэвтрүүлэхэд онцгойлон анхаарч 2004-2019 онуудад шинээр цогцолбор барилга барихад 4.8 тэрбум төгрөг, бараа, материалын хадгалах агуулахын барилга, сав, тоног төхөөрөмжийн их засвар, үйлчилгээний ажилд 7.4 тэрбум төгрөг, техник тоног төхөөрөмж, галын багаж хэрэгслээр хангахад 1.3 тэрбум, нийт 13.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийгээд байна.


2010 онд ОХУ-аас Монгол Улсад нийлүүлэх агаарын тээврийн хөлгийн шатахууны хангамж тасалдсны улмаас 7 хоногийн нөөцтэй болсон үед Засгийн газрын 29 дүгээр тогтоол гарч улсын нөөцөөс 700.0 тонн онгоцны түлшийг зарцуулснаар агаарын тээврийн үйл ажиллагаа хэвийн байдалд шилжсэн.

Засгийн газрын 2008 оны 265 дугаар тогтоол "ISO 9001 стандарт хэрэгжүүлэх", Засгийн газрын 344 дүгээр тогтоол "Үндэсний чанарын хөтөлбөр"-ийн хүрээнд 2017 онд Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Улаанбаатар хот дахь Хүнсний нөөцийн салбар, 2018 онд Улаанбаатар хот дахь Шатахууны нөөцийн салбар, "Объект №03" Улсын нөөцийн салбар ISO 9001:2015 стандартын удирдлагын системийн тогтолцоог нэвтрүүллээ.



Чанарын менежментийн тогтолцооны олон улсын ISO 9001:2015 стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлснээр ОБЕГ-ын харьяа Хүнсний нөөцийн салбар нь төр, захиргааны болон Засгийн газрын агентлагууд дотроос анхдагч байгууллага болж, улсын нөөцийн бараа, материалыг нөхөн бүрдүүлэх, сэлгэн шинэчлэх хадгалан хамгаалах, тээвэрлэн хүргэх үйл ажиллагаа олон улсын жишигт хүрсэн алба ёсны гэрчилгээтэй болсон юм.

Мөн тус салбар "Агуулахын удирдлагын систем"-ийг үйл ажиллагаандаа анх удаа нэвтрүүлэн бараа, материалын байршил, агуулахын нөхцөл, хүчин чадал, дүүргэлт, хяналтыг дэвшилтэд техник, технологийг ашиглан хяналт тавьж ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэн улсын нөөцийн бараа, материалын хадгалалт, хамгаалалтын чанар, аюулгүй байдлыг хангах зорилгоор 2017 онд "Улсын нөөцийн нэгдсэн лаборатори" байгууллаа.




Улсын нөөцийн гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэхэд анхаарч ажилласны үр дүнд ОХУ-ын Холбооны улсын нөөцийн байгууллага (Росрезерв)-тай нягт хамтран ажиллаж байна.

ОХУ-ын Холбооны улсын нөөцийн газрын орлогч дарга Земсков А.Е. тэргүүтэй төлөөлөгчид 2007 оны 9 дүгээр сарын 26-28-ны өдрүүдэд Монгол Улсын Онцгой байдлын ерөнхий газарт албан ёсны айлчлал хийж, Монгол Улсын нөөцийн байгууллага түүний салбар нэгжтэй танилцсаны зэрэгцээ Монгол Улс, ОХУ-ын нөөцийн байгууллагуудын цаашдын хамтын ажиллагааны үндсэн чиглэл, хэлбэр, нөхцөлийн талаар санал солилцон тохиролцоонд хүрч ажлын уулзалтын протоколд гарын үсэг зурав.

■ 2008 онд Монгол Улсын Онцгой байдлын ерөнхий газрын төлөөлөгчид ОХУ-ын Холбооны улсын нөөцийн газрын дарга А.А.Григорьевийн урилгаар Москва хотод албан ёсны айлчлал хийж Төвийн болон Приволги бүсийн зарим нөөцийн салбаруудын үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцан Монгол Улсын Онцгой байдлын ерөнхий газар, ОХУ-ын Холбооны улсын нөөцийн газруудын 2008-2009 онд улсын нөөцийн чиглэлээр хамтран ажиллах протокол байгуулав.



БНЧУ-ын Прага хотод 2008 оны 10 дугаар сард болсон “Хямралын үеийн материалын нөөц” сэдэвтэй олон улсын бага хуралд Онцгой байдлын ерөнхий газрын төлөөлөгчид оролцов. Уг бага хуралд нийт 19 орны төлөөлөгчид оролцсон бөгөөд Венгри, Румын, Болгар, Чех, Швейцар, ОХУ, Хорват улсын төлөөлөгчид өөрийн орны улсын нөөцийн тулгамдсан асуудлаар тавьсан илтгэлийн хэлэлцүүлэгт оролцож байв.



ОХУ-ын Холбооны улсын нөөцийн газрын даргын зөвлөх Гатилов С.Я тэргүүтэй төлөөлөгчид 2013 оны 5 дугаар сарын 15-17-ны өдрүүдэд Монгол Улсын Онцгой байдлын ерөнхий газарт айлчилж Монгол Улсын нөөцийн байгууллага түүний салбар нэгжтэй танилцан Монгол Улс, ОХУ-ын нөөцийн байгууллагуудын цаашдын хамтын ажиллагааны ажлын уулзалт зохион байгуулж, протоколд гарын үсэг зурав.

■ 2013 онд Монгол Улсын Онцгой байдлын ерөнхий газар нь Тусгаар улсуудын хамтын нийгэмлэгийн гишүүн орнуудын “Улсын нөөцийн асуудал эрхэлсэн байгууллагуудын дарга нарын Зөвлөлдөх хороо”-нд ажиглагчаар элсэн орж, тус хорооны олон улсын хуралд Монгол Улсын Онцгой байдлын ерөнхий газраас жил бүр төлөөлөгч оролцож байна.



▶ 2012-2018 онд ОХУ-ын Холбооны улсын нөөцийн газар (Росрезерв)-ын харъяа Торжокийн политехникийн коллежид Монгол Улсын нөөцийн байгууллагын 49 албан хаагчийг бараа, материалын хүлээн авалт, удаан хадгалалт, агуулах, савны бэлтгэл бэлэн байдлын талаар 10 хоногийн гэрчилгээтэй сургалтанд хамруулав.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

ОЛОН ТАЛТ ХАМТЫН
АЖИЛЛАГАА



Монгол Улсын гамшигийн эрсдэлийг бууруулах, гамшигтай тэмцэх чадавхыг бэхжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөр, үйл ажиллагааг олон улсад сурталчлан таниулах, харилцан туршлага солилцох, Онцгой байдлын байгууллагын хүн хүч, техник тоног төхөөрөмжийн чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор бүс нутгийн болон дэлхийн улс гүрнүүдийн ижил төстэй чиг үүрэг бүхий байгууллагуудтай хоёр талын болон олон талт харилцаа, хамтын ажиллагааг бүх талаар хөгжүүлсээр ирсэн.



Одоогийн байдлаар ОХУ, БНХАУ, БНСУ, БНАСАУ, Япон Улс, Унгар Улс, БНФранц Улс, АНУ, Австрали Улс, БНБеларусь Улс, БНКазахстан Улс, БНКиргиз Улс, БНПольш Улс, БНСВУ, БНТУ, БНЭУ, ШХУ зэрэг 17 улс орны ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай хамтран ажиллаж байна.



АНУ-ын Номхон далайн цэргийн командлал, Аляскийн үндэсний гвардын төлөөлөгчид Монгол Улсад 2004 онд айлчилж, улмаар “Гамшигийн бэлэн байдал болон аюулыг бууруулах ажиллагааг үнэлэх хөтөлбөр”-ийг 2005 оноос хэрэгжүүлэн ажиллаж байна.



Монгол Улсад гамшигийн аюулыг бууруулж, менежментийн тогтолцоог боловсронгуй болгох нь” төслийн хүрээнд ГХЕГ-ын тэргүүн дэд дарга О.Үржин тэргүүтэй төлөөлөгчид 2004 онд Норвеги, Швед, Финлянд улсад айлчилж харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар санал солилцов.



Гамшгаас хамгаалах ерөнхий газар байгуулагдсаны дараахан дарга, хошууч генерал П.Даш Унгар улсын Гамшгаас хамгаалах ерөнхий газрын дарга, хошууч генерал Татар Аттила тааламжтай цагтаа Монгол Улсад айлчлахыг урьжээ. Хошууч генерал Татар Аттила урилгыг хүлээн авч мөн оны наймдугаар сард айлчлахаар болсон боловч Унгар улсад томоохон хэмжээний үерийн гамшиг тохиолдсоноос айлчлал хойшлогдсон байна.

Улмаар Унгар Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд Иллеш Михайтай хамтран ажилласны үр дүнд тэрбээр 2005 оны гуравдугаар сард Монгол Улсад айлчилжээ.



■ Энэхүү айлчлалын үр дүнд Монгол Улс, Унгар улсын хооронд гамшгаас хамгаалах салбарт хамтран ажиллах Хамтарсан мэдэгдлийг байгуулж, Монгол Улс анх удаа галын иж бүрэн лабораторитай болсон байна.

“Үйлдвэрлэлийн осол, байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, тэдгээрийн үр дагаврыг арилгах салбарт хамтран ажиллах тухай” Монгол Улс, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд Онцгой байдлын ерөнхий газар 2006 онд ОХУ-ын Иргэний хамгаалалт, онцгой байдал, байгалийн гамшгийн үр дагаврыг арилгах хэрэг эрхлэх яам /ОБЯ/-тай “Монгол Улсын Онцгой байдлын байгууллага, ОХУ-ын Иргэний хамгаалалт, онцгой байдал, байгалийн гамшгийн үр дагаврыг арилгах хэрэг эрхлэх яам хоорондын хамтын ажиллагааг идэвхжүүлэх протокол”-д гарын үсэг зурсан юм.

▶ Энэхүү протокол нь манай хоёр байгууллагын харилцаа, хамтын ажиллагааг улам бүр идэвхтэй хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой баримт бичиг болсон. Түүнчлэн Монгол Улсын Онцгой байдлын албаны алба хаагчдыг ОХУ-ын Онцгой байдлын яамны харьяа Иргэний хамгаалалтын болон Гал эсэргүүцэх албаны академи, сургалтын төвүүдэд ОХУ-ын сонсогчдын нэгэн адил нөхцөлөөр сургах талаар тохиролцсон бөгөөд 2008 оны хичээлийн жилээс магистрын сургалтад оюутнууд суралцаж эхлээд байна.





БНХАУ-ын Иргэний хэргийн яам, Ойн улсын хороо, Газар хөдлөлтийн агентлагтай тогтоосон харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын Шадар сайд болон Онцгой байдлын ерөнхий газрын удирдлага БНХАУ-ын Иргэний хэргийн сайдтай 2005, 2015 онуудад тус тус уулзаж, харилцаа, хамтын ажиллагааны талаар санал солилцсон.



Одоогийн байдлаар, БНХАУ-ын Газар хөдлөлтийн агентлагийн сургалтын төвд Монгол Улсын Онцгой байдлын албаны аврагчдыг сургаж, эрэн хайх, аврах ажиллагааны мэргэжлийн ур чадварыг дээшлүүлж байна.



Европын болон улс үндэстнүүдийн хүн амыг аюул ослоос амжилттай хамгаалахад дэмжлэг үзүүлэх зорилгоор “Хүн амыг гамшгаас хамгаалах, гамшгийн үеийн удирдлагын менежмент” сэдвийн доор зохион байгуулагдсан Европын 6 дугаар конгресст 2010 оны 9 дүгээр сарын 8, 9 нд оролцож харилцан туршлага солилцлоо. Конгрессоор хүн амыг хамгаалах Европын стратеги, олон улсын хамтын ажиллагаа, тусламж үзүүлэх үйл ажиллагаа, ХБНГУ-ын үндэсний стратеги, гамшгийн үеийн болон хүн амыг хамгаалахад технологийн дэвшлийг ашиглах тухай, уур амьсгалын өөрчлөлтөөс хүн амыг хамгаалах асуудлуудыг хэлэлцэв.

“Хил орчмын ой, хээрийн түймэртэй тэмцэх талаар хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”, түүнийг хэрэгжүүлэх нарийвчилсан журмын хүрээнд “Монгол Улс, БНХАУ-ын Хил орчмын бүсийн ой, хээрийн түймэртэй тэмцэх хамтарсан комиссын хуралдаан”-ыг хоёр жил тутамд зохион байгуулж хэвшсэн.



Гадаад орон, олон улсын байгууллагатай тогтоосон харилцаа, хамтын ажиллагааг илүү өргөн хүрээнд өргөжүүлэн бэхжүүлэхийн тулд Бүгд Найрамдах Киргиз Улстай "Онцгой байдлаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Онцгой байдлын ерөнхий газар, Бүгд Найрамдах Киргиз Улсын Онцгой байдлын яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг" (2016), БНСУ-тай Монгол Улсын Онцгой байдлын ерөнхий газар, БНСУ-ын Онцгой байдлын ерөнхий газар хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг (2006), санамж бичгийг хэрэгжүүлэх хөтөлбөрийн баримт бичиг (2012), БНХАУ-тай "Хил орчмын ой, хээрийн түймэртэй тэмцэх талаар хамтран ажиллах Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг хэрэгжүүлэх нарийвчилсан журам (2011), Монгол Улсын Онцгой байдлын ерөнхий газар, БНХАУ-ын Газар хөдлөлтийн удирдах газар хоорондын газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх чадавхыг бэхжүүлэх салбарт хамтран ажиллах санамж бичиг (2013) зэргийг байгуулсан байна.



■ Харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд Онцгой байдлын байгууллагаас жилд дунджаар давхардсан тоогоор 250 гаруй алба хаагч гадаад улс, оронд зохион байгуулагдаж буй албан айлчлал, хурал чуулган, уулзалт, сургалт, семинар, дасгал сургуульд оролцож байна.



НҮБ болон түүний төрөлжсөн байгууллагууд, Олон улсын иргэний хамгаалалтын байгууллага, Гамшгийн аюулыг бууруулах Азийн бүсийн төв, Азийн гамшгийн бэлэн байдлын төв, Олон улсын галын байгууллагын дарга нарын Азийн холбоо, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Япон Улс, БНСУ, Швейцарийн Холбооны Улс, БНТУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллагууд зэрэг 20 гаруй бүс нутгийн болон дэлхийн хэмжээний олон улсын байгууллагуудтай харилцаа, хамтын ажиллагаатай ажиллаж байна.

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын гамшгийн аюулыг бууруулах анхны тусгай төлөөлөгч хатагтай Маргарета Волстром Монгол Улсын Шадар сайд У.Хүрэлсүхийн урилгаар Монгол Улсад 2015 оны 05 дугаар сард ажлын айлчлал хийв.





Айлчлалын хүрээнд “Гамшгийн эрсдэлийг бууруулах, цаг уурын өөрчлөлтөд дасан зохицох, тогтвортой хөгжлийг хангах үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, чадавхыг бэхжүүлэх нь” сэдэвт өндөр түвшний бодлогын хэлэлцүүлэг болон “Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний платформ”-ын танилцуулгыг тус тус зохион байгуулсан нь “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ 2015-2030” баримт бичгийн талаарх өргөн хүрээний ойлголтыг төр засгийн удирдагчид, албаны хүмүүс, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн ажилтнуудад өгсөнөөрөө өндөр ач холбогдолтой болсон.



■ Онцгой байдлын байгууллага гадаад улс оронд эрэн хайх, аврах ажиллагааг явуулах чадавхтай олон улсын дунд хэмжээний багтай болохыг зорин, эхний ээлжинд Швейцарийн хамтын ажиллагааны байгууллага, БНХАУ-ын Газар хөдлөлтийн байгууллагатай хамтран үндэсний эрэн хайх, аврах чадавхыг дээшлүүлэх төслийг 2017 оноос эхлүүлээд байна.

Алба хаагчдыг ОХУ-ын ОБЯ-ны харьяа Иргэний хамгаалалтын болон Гал эсэргүүцэх албаны академи, Санкт-Петербургийн Гал эсэргүүцэх албаны их сургууль, БНПУ-ын Галын ерөнхий сургууль болон Унгар, Австрали, Тайландын Вант Улс, БНХАУ-ын холбогдох их дээд сургуулийн академик түвшний сургалтуудаар бэлтгэж байна. Мөн гадаад улс орнуудад зохион байгуулагдаж буй урт болон богино хугацааны мэргэжлийн сургууль, дамжаа, сургалт, семинар, дасгал сургуульд тогтмол оролцуулсаар ирсэн.



БНСУ-ын Гёнги мужийн Галын академи, Япон улсын Саппоро хотод гал унтраах, аврах ажиллагааны чиглэлийн сургалт



Онцгой байдлын ерөнхий газар нь Олон улсын иргэний хамгаалалтын байгууллага, Азийн гамшгийн бэлэн байдлын төв, Олон улсын Галын байгууллагын дарга нарын холбоо, Азийн Галын дарга нарын холбоо, Олон улсын галын инженерүүдийн холбоо, Олон улсын галын аюулгүй байдлын шинжлэх ухаан технологийн холбоонд гишүүнчлэлтэй.



Цаашид хоёр талын болон олон талт харилцаа, хамтын ажиллагааг эрчимтэй хөгжүүлэх зорилгоор Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс, Бүгд Найрамдах Беларус Улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улс, БНСВьетнам Улс, Колумби зэрэг улстай хамтын ажиллагааг эхлүүлэхээр ажиллаж байна.

Түншлэл, хамтын ажиллагаа



Онцгой байдлын ерөнхий газар нь гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах чиглэлээр 2014 оноос “Барилга хот байгуулалтын яам”, “Цагдаагийн ерөнхий газар”, “Хил хамгаалах ерөнхий газар”, “Монголын үндэсний олон нийтийн радио телевиз”, Зам тээврийн яамны харъяа “Далайн захиргаа”, “Үндэсний статистикийн хороо”, “Хууль сахиулахын их сургууль”, “Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим”, “Эс Эс Ай Эм Эн ХХК”, “Дат консалтинг” ХХК, “Тэкол ХХК”, “Шинэболд ХХК”, “Буман девелопмент ХХК”, “Гео-Информэшн ХХК”, “Монголын улаан загалмайн нийгэмлэг”, “Дэлхийн зөн-Монгол”, “Мерси Кор” Олон улсын байгууллага, “JCI Чэйрмэн” салбар байгууллага, “Гамшгийн эсрэг

үндэсний төв ТББ”, “Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо”, “Монголын байгаль орчин, аюулгүй байдлын төв”, “Гамшиг, гал түймрээс хамгаалах Монголын нийгэмлэг”, “Оргил өөд клуб”, “Гамшгаас хамгаалах судалгаа, шинжилгээний үндэсний төв ТББ”, “Гамшгаас хамгаалах Үүрд тэгш нийгэмлэг”, “Тамбов-Цэргийн химичид ТББ”, “Ази номхон далайн бүс нутгийн түншлэл судалгааны төв” зэрэг нийт 25 байгууллагатай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулан гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах, иргэд, олон нийтэд мэдээлэл, сургалт, сурталчилгаа зохион байгуулах, хүмүүнлэгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх зэрэг чиглэлээр хамтран ажиллаж байна.

Тухайлбал, Онцгой байдлын ерөнхий газар, Монголын Улаан загалмай нийгэмлэг нь “Төр-Улаан загалмайн хамтын ажиллагааны чиглэл”-ээр 2015 онд хамтран ажиллах санамж бичиг байгуулсан бөгөөд уг санамж бичгийг 2015-2020 оны хооронд 5 жилийн турш хэрэгжүүлэхээр хоёр тал баталгаажуулав.


Санамж бичгийн хүрээнд Онцгой байдлын ерөнхий газрын дэргэд Монголын Улаан Загалмай Нийгэмлэгийн дунд шатны хороо, орон нутгийн ОБГ-ын дэргэд анхан шатны хороодыг тус тус байгуулан ажиллаж байна.

Нийслэлийн 9 дүүрэг, 21 аймагт тус бүр нь 15 гишүүдтэй 30 гамшгаас хамгаалах “Сайн дурын бүлэг” байгуулан ажилласан. Улсын хэмжээнд нийт 30 сайн дурын бүлгийн 450 гишүүдийг гамшгаас хамгаалах, анхны тусламжийн чиглэлээр “Сургагч багш”-аар бэлтгээд байна.



Төсөл, хөтөлбөр

Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа, хүн хүч, техник, тоног төхөөрөмжийн чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор Австрали Улс, Австри Улс, Унгар Улс, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, НҮБ-ын Гамшгийн аюулыг бууруулах газар, Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк, ЖАЙКА, КОЙКА, Азийн гамшгийн бэлэн байдлын төв зэрэг олон улсын байгууллагуудтай хамтран 15 жилийн хугацаанд нийт 34 төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж ажилласан байна.



■ НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн “Монгол Улсад гамшгийн аюулыг бууруулах менежментийн тогтолцоог боловсронгуй болгох нь” МОН/02/305 төсөл, Гамшгаас хамгаалах ерөнхий газар хамтран “Монгол Улсын гамшгийн удирдлагын шинэчлэлт” сэдэвт үндэсний бага хурлыг 2004 оны 05 дугаар сарын 21-ний өдөр Улаанбаатар хотноо зохион байгууллаа. Бага хуралд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, УИХ, Засгийн газар, Гамшгаас хамгаалах төв, орон нутгийн байгууллага, яам, агентлаг, төрийн бус байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүрэг, Улсын нөөцийн салбар, НҮБ болон гадаад орнуудаас манай оронд суугаа депломат төлөөлөгчдийн газар, олон улсын байгууллагын нийт 160 гаруй төлөөлөгч оролцов.

Люксембургийн Засгийн газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн санхүүжилтээр 2002-2016 онд 4 үе шаттайгаар хэрэгжсэн “Монгол Улсад гамшгийн аюулыг бууруулах менежментийн тогтолцоог боловсронгуй болгох нь” төслийн хүрээнд Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хууль, “Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого”, “Гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх үндэсний хөтөлбөр” зэрэг бодлогын баримт бичгүүдийг боловсруулан батлуулж, давхардсан тоогоор 6000

гаруй офицер, ахлагчийг мэргэшүүлэх болон дадлагажуулах сургалтад хамруулж, 760,500 ам.долларын техник, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсэн байна.

Энэхүү төсөл нь гамшгаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах удирдлага, зохицуулалтын механизмыг хэрэгжүүлэх замаар гамшгийн удирдлагын төвлөрлийг багасгах, хот суурин газар, хөдөө орон нутгийн эмзэг байдлыг бууруулахад бодит хувь нэмрийг оруулсан.



"Дэлхийн зөн Монгол" олон улсын байгууллага нь НҮБ-ын Гамшгийг бууруулах Олон Улсын стратегийн байгууллагаас санаачилсан "Гамшигт тэсвэртэй хотуудыг бий болгоё" уриан дор хот, суурин газрын гамшгийн эрсдэлийг бууруулах, түүнийг даван туулах чадавхыг бэхжүүлэх хөтөлбөрийг түгээн дэлгэрүүлэх, "Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах" үндэсний хөтөлбөрт хувь нэмэр оруулах үүднээс "Гамшигт тэсвэртэй Улаанбаатар" төслийг хоёр жилийн хугацаатай хэрэгжүүлж байна. Энэхүү төслийн хүрээнд нийслэлийн Онцгой байдлын газарт 2017-2018 онд буюу сүүлийн хоёр жилийн хугацаанд нийт 233.5 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт хийгджээ.



Онцгой байдлын ерөнхий газар Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага ЖАЙКА-тай хамтран "Монгол Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх төсөл"-ийг хэрэгжүүлж байна.



■ Төслийн хүрээнд НОБГ-ын Нийслэлийн иргэдийг гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төвд 52 сая иен буюу 1,2 тэрбум төгрөгийн өртөг бүхий "Газар хөдлөлтийн чичирхийллийг биеэр мэдрэх төхөөрөмжийг суурилууллаа."

Мөн барилга байгууламжийн газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ хийхэд болон төслийн хүрээнд төлөвлөгдсөн сургалтуудад ашиглагдах таван төрлийн багаж, тоног төхөөрөмжүүдийг Онцгой байдлын ерөнхий газарт хүлээлгэн өгөв.



Japan
Fund for
Poverty
Reduction



Монгол Улсын Засгийн газар Азийн хөгжлийн банкттай 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдөр “Зуд болон ой, хээрийн түймэртэй тэмцэх олон нийтийн чадавхыг бэхжүүлэх” төслийг 2016-2019 онд хэрэгжүүлэхээр буцалтгүй тусламжийн гэрээг үзэглэсэн билээ. Уг төслийн санхүүжилт болох гурван сая америк долларыг Япон улсын Засгийн газраас Азийн хөгжлийн банкны Ядуурлыг бууруулах Японы Сангаас, хоёр зуун мянган америк долларын санхүүжилтийг Монгол Улсын Засгийн газраас мөнгөн бус хэлбэрээр гаргасан байна.



Гамшгийн эрсдэлийн удирдлагын үндэсний болон орон нутгийн байгууллага, багийн иргэдийн зуд болон ой, хээрийн түймрийн эрсдэлийг удирдах чадавхыг бэхжүүлэх зорилготой энэхүү төслийг Онцгой байдлын ерөнхий газартай хамтран Дорнод, Сүхбаатар, Говь-Алтай, Хөвсгөл аймгийн 12 суманд хэрэгжүүлсэн.



Төсөл хэрэгжүүлэх нэгжийн хамт олон. Баруун гар талаас: Д.Эрдэнэбат, Ч.Эрдэнэчимэг, Д.Цэвээн-Үр, Г.Халиунзул, Д.Нямдорж, М.Нандинчимэг, Б.Алтанчимэг, Р.Ганбат, С.Хажидсүрэн

Нутгийн иргэдэд түшиглэсэн 139 Багийн хөршийн бүлгийг байгуулсан бөгөөд эдгээр бүлгүүд нь 1811 өрх, 6918 хүн амтай, 4246 гишүүнтэйгээс 1955 нь эмэгтэй (46 хувь) гишүүн байна. Үүний 63 нь (45,3 хувь) эмэгтэй ахлагчтай. Багийн хөршийн бүлгүүд бүгд хамтран ажиллах гэрээтэй, сумын Засаг даргын Тамгын газар, аймгийн Онцгой байдлын газарт бүртгүүлсэн. 139 БХБ бүр гамшгаас хамгаалах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан батлуулж, сумын гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөг шинэчилсэн.



Сумын зохицуулагч нар. Баруун гар талаас: С.Золжаргал, Д.Цэвээн-Үр, М.Нандинчимэг, Б.Алтанчимэг, Ч.Эрдэнэчимэг, П.Ганхуяг, Г.Ганцогт, А.Энхтуул, Ю.Цэпэлмаа, Б.Үүрийнтуяа, П.Лхагвабаатар, С.Гантуяа, Т.Тамир, Н.Мөнхдорж, Ч.Одгэрэл

Төслийн хүрээнд Онцгой байдлын байгууллагын алба хаагчид, нутгийн байгууллага, сумын захиргааны гамшигтай тэмцэх чадавхыг бэхжүүлэх, олон нийтийн оролцоотой гамшгийн эрсдэлийг үнэлэх, төлөвлөх, хэрэгжүүлэх чиглэлээр нийт 39 удаагийн сургалтыг ОБЕГ, "Боловсролын шинжлэх ухааны академи" ТББ, Японы сансрын агентлаг, Хууль сахиулахын их сургуулийн Онцгой байдлын сургууль, олон улсын зөвлөх доктор Иан Валдерспийн, үндэсний зөвлөх доктор П.Даш, ХАА-н шинжлэх ухааны академийн гишүүн, шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, доктор, профессор С.Цэрэндаш, Монгол Улсын зөвлөх мал зүйч, доктор, профессор Б.Биньээ нартай хамтран зохион байгуулж, давхардсан тоогоор 8959 /эмэгтэй 34,6 хувь/, давхардаагүй тоогоор 6752 /эмэгтэй 48,3 хувь/ хүн хамруулсан байна.



Онцгой байдлын байгууллага, сумын захиргаа, багийн хөршийн бүлгийн гишүүдийг зуд болон ой хээрийн түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, гамшигтай тэмцэх чадавхыг бэхжүүлэх зорилгоор олон төрлийн бараа, техник тоног төхөөрөмжөөр хангасан. Үүнд:

Онцгой байдлын байгууллагад:

- Үүрэн холбооны сүлжээ үүсгэгч
- Нисгэгчгүй нисэх төхөөрөмж
- Шуурхай удирдлагын төвийн мэдээллийн технологийн төхөөрөмж
- Газар зүйн мэдээллийн техник тоног төхөөрөмж
- Орчуулга дамжуулах төхөөрөмж
- Амьсгалын хамгаалах хэрэгсэл
- Үүргийн гал унтраагуул
- Үлээгч төхөөрөмж
- Усны завь
- Хүнд даацын автомашины дугуй
- Усны нөөц сав, шахуурга, помп, хоолойн хамт
- Аймгийн нөөцийн салбарын агуулахын засвар
- Дорнод аймгийн Баян-Уул суман дах сайн дурын аврагч бэлтгэх байр





Сумын захиргаанд:

- Гамшгийн зарлан мэдээллийн дуут дохиоллын төхөөрөмж
- Усны нөөц сав чиргүүлтэй
- Үлээгч төхөөрөмж
- Гал түймрийн хамгааллын хувцас
- Бага оврын трактор дагалдах хэрэгслийн хамт
- Трактор дагалдах хэрэгслийн хамт
- Гамшгийн аюулын дотоод зарлан мэдээллийн системийн төхөөрөмж



Багийн хөршийн бүлгийн гишүүдэд:

- Гал түймрийн хамгааллын хувцас, гутал, малгай, бээлий
- Барометр
- Малын хашаа, саравч, хөцөө барих, засварлах материал
- Өвс тэжээлийн агуулах барих, засварлах материал
- Бэлчээрийн худаг шинээр гаргах
- Хадлангийн талбайн усжуулалтын систем сайжруулах
- Ногооны талбайн усжуулалтын систем сайжруулах
- Түймрийн зурвас татах шатахууны дэмжлэг

**Төсөл хэрэгжүүлэх нэгжид:**

- Албан тасалгааны тавилга
- Компьютер цахилгаан хэрэгсэл
- Суудлын автомашин
- Мотоцикл



Төслийн худалдан авалтын төлөвлөгөөний дагуу нийт 3,214,344,000 төгрөгийн гамшгаас хамгаалах хувцас, багаж, тоног төхөөрөмж нийлүүлсэн байна.

ОЛОН УЛСЫН ХУРАЛ

▲ Азийн гамшгийн бэлэн байдлын төвтэй хамтран "Гамшгийн менежментийн бүсийн зөвлөлдөх хорооны 10 дугаар хуралдаан"-ыг Монгол Улсад анх удаа зохион байгууллаа.

■ Тус хуралдаанд дэлхийн 19 орон, олон улсын 20 гаруй байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагын 130 орчим төлөөлөгч оролцож "Ази, Номхон далайн бүсэд гамшгийн эрсдлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох болон тогтвортой хөгжлийг орон нутгийн түвшинд уялдуулан төлөвлөх төлөвлөгөөг боловсруулж, санал бодол, туршлагаа солилцон гамшгийн эрсдлийг бууруулахад Азийн гамшгийн бэлэн байдлын төвтэй илүү нягт хамтран ажиллах чиглэлийг тодорхойлсон байна.



■ Энэтхэг улсын Шинэ Дели хотноо 2016 оны 11 дүгээр сарын 02-05-ны өдрүүдэд болсон Гамшгийн эрсдэлийг бууруулах Азийн сайд нарын чуулга уулзалтад Монгол Улсын Шадар сайд У.Хүрэлсүх тэргүүтэй Онцгой байдлын ерөнхий газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Монголын Улаан загалмай нийгэмлэг зэрэг төр, олон нийтийн байгууллагын төлөөлөгчид оролцлоо.



■ Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах газартай хамтран Улаанбаатар хотноо зохион байгуулсан "Гамшгийн эрсдэлийг бууруулах Олон Улсын стратегийн Азийн түншлэлийн хурал"-д 19 улс, 20 гаруй олон улсын байгууллагаас нийт 140 орчим төлөөлөгч оролцов.



■ Мексикийн Нэгдсэн Улсын Канкун хотноо болсон Гамшгийн эрсдэлийг бууруулах дэлхийн чуулганд 189 орны төрийн болон Засгийн газрын тэргүүн, сайд, парламентын гишүүд, НҮБ-ын дээд түвшний удирдлага, эрдэм шинжилгээний байгууллага, иргэний нийгэм, залуучуудын байгууллагын 7000 гаруй төлөөлөгч оролцсон. Энэ үеэр Монгол Улсын Шадар сайд У.Хүрэлсүхийг НҮБ-ын “Манлайлагч-Төрийн түшээ”-гээр өргөмжлөв.



■ НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах газрын “Азийн түншлэлийн хуралдаан, Үндэсний болон орон нутгийн түвшинд гамшгийн эрсдэлийг бууруулах стратегийн хэлэлцүүлэг” Тайланд Улсын Бангкок хотноо зохион байгуулагдлаа. Энэ удаагийн хуралдаанд бүс нутгийн 20 улсын Засгийн газрын төлөөлөгч, НҮБ-ын төрөлжсөн 15 байгууллага, Засгийн газар хоорондын болон бүсийн хамтын ажиллагааны 15 байгууллага, хувийн хэвшлийн зэрэг нийт 150 төлөөлөгч оролцсон байна.

■ Монгол Улсын Шадар сайд Ө.Энхтүвшин, ОБЕГ-ын дарга, хошууч генерал Т.Бадрал тэргүүтэй төлөөлөгчид Женев хотноо зохион байгуулагдсан “Гамшгийн эрсдэлийг бууруулах дэлхийн платформ”-д оролцов. Хурлын үеэр Шадар сайд Ө.Энхтүвшин, НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын Гамшгийн эрсдэлийг бууруулах тусгай төлөөлөгч хатагтай Маами Мизүторитай уулзлаа.



ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ АЗИЙН САЙД НАРЫН ХОЁРДУГААР БАГА ХУРАЛ-2018

■ Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах газар, Онцгой байдлын ерөнхий газартай хамтран Улаанбаатар хотноо Гамшгийн эрсдэлийг бууруулах Азийн сайд нарын бага хурлыг 2018 оны 07 дугаар сарын 03-06-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа.






■ Гамшгийн эрсдэлийг бууруулах Азийн сайд нарын хуралд Ази, Номхон далайн 50 гаруй улс орны өндөр дээд түвшний төлөөлөгчид хүрэлцэн ирсэн юм. Тухайлбал, Малайз, Самоа, Тувалу, Кирибати, Индонези, Бангладеш, Узбекистан болон Энэтхэг зэрэг улсын сайдууд, Камбожи, Өмнөд Солонгос, Лаос, Шри-Ланк, Токелау, Вьетнам, БНХАУ, Тайланд болон Мьянмар зэрэг улсын дэд сайдууд, Австрали улсаас Парламентын гишүүн хүрэлцэн ирж, нийт 3500 гаруй зочид төлөөлөгч оролцсон өндөр дээд хэмжээний хурал болсон юм.



■ Тус хурлаар Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийн эхний гурван жилийн үйл ажиллагааг, Азийн бүсийн төлөвлөгөө 2016-2018 оны хэрэгжилт, гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр бүс нутгийн улс орнуудын хүлээсэн үүрэг, амлалт, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний ахиц дэвшлийг үнэлж дүгнэн, “Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийг хэрэгжүүлэх Азийн бүсийн 2018-2020 оны төлөвлөгөө”, хоёр жилд хэрэгжүүлэх “Улаанбаатарын тунхаглал”, “Оролцогч талуудын мэдэгдэл” баримт бичгүүдийг батлан гаргав.



■ “Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийг хэрэгжүүлэх Азийн бүсийн 2018-2020 оны төлөвлөгөө”, “Улаанбаатарын тунхаглал”, “Оролцогч талуудын мэдэгдэл” баримт бичгүүдийг батлан гаргаснаар ирэх 15 жилд дэлхий нийтээр гамшгийн эрсдэлийг бууруулахад баримтлах үндсэн зарчим, арга хэмжээ болох Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах олон нийтийн чадавхыг бэхжүүлэхэд орон нутгийн болон үндэсний цаашлаад бүс нутгийн хүчин чармайлтыг нэгтгэн уялдуулах боломж нөхцөл бүрдлээ.



ДОЛООДУГААР БҮЛЭГ

СУРГАЛТ, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ,
ИННОВАЦИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА



Аливаа салбар шинжлэх ухаанд суурилж хөгжихөд гол тулдаг тулгуур нь эрдэм шинжилгээний байгууллага юм. Онцгой байдлын байгууллагад шинжлэх ухаан технологи, инновацийг хөгжүүлэх, Гамшиг судлалын ухааныг хөгжүүлэх талаар Монгол Улсын төрийн бодлого, үе үеийн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрүүд, тэдгээрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнүүдэд тухай бүр зааж, хэрэгжүүлж ирсэн.

2004-2008 оны Монгол Улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөрт "Гамшгаас хамгаалах байгууллагуудын үйл ажиллагааг бэхжүүлж, гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох чадавхыг нэмэгдүүлэх чиглэлээр цогц арга хэмжээ авч хэрэгжүүлнэ" гэсэн зорилт багтсан.

2008-2012 онд Монгол Улсын Засгийн Газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд "Гамшгаас хамгаалах талаар онолын суурь болон хавсарга судалгааг хөгжүүлнэ. Гамшгийн судалгааны байгууллагыг тусгай хөтөлбөрөөр хөгжүүлж, эрдэм шинжилгээ, туршилт, үйлдвэрлэлийн материаллаг баазыг бэхжүүлнэ. Гамшгийн судалгаа, эрдэм шинжилгээ, туршилт зохион бүтээх ажлын үр дүнг гамшгаас хамгаалах арга хэмжээнд нэвтрүүлнэ" гэж тусгагдсан.



Монгол Улсын Их Хурлын 2011 оны 22 дугаар тогтоолоор баталсан Гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх үндэсний хөтөлбөрт "гамшиг судлалын шинжлэх ухааныг хөгжүүлж, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнг гамшгаас хамгаалах арга хэмжээнд нэвтрүүлэх" талаар тодорхой зааж өгсөн.

ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ЗӨВЛӨЛ


ГХЕГ-ын даргын 2004 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 78, 79 дугаар тушаалаар шинжлэх ухаан технологийн талаар баримтлах Гамшгаас хамгаалах ерөнхий газрын бодлогын үндсийг тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх талаар зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг байгуулах тухай шийдвэрийг гаргаж, "Гамшгаас хамгаалах ерөнхий газрын Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн дүрэм, зөвлөлийн бүрэлдэхүүнийг тус тус баталжээ.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд гамшгийн эрсдэлийн удирдлагын үүрэг, оролцоо нэмэгдэж байгаатай уялдуулан Онцгой байдлын байгууллагын сургалт, эрдэм шинжилгээний нэгжийг нэгдмэл удирдлага, зохион байгуулалтаар хангах, үйл ажиллагааг нь уялдуулах зорилгоор Шинжлэх ухаан технологийн орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнийг ОБЕГ-ын даргын 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн А/330 дугаар тушаалаар шинэчлэн баталсан байна.



■ Шагналыг 2018 оноос олгож эхэлсэн бөгөөд анхны цомыг Гамшиг судлалын хүрээлэнгийн Химич-судлаач, доктор, ахмад П.Чимэдцэрэн, хувцасны технологи хариуцсан судлаач бөгөөд секторын эрхлэгч, хошууч А.Ариунбилэг нарын хамтран гаргасан Химийн хорт бодисын эрсдэлийг бууруулахад ашиглах "Шингээгч иж бүрдэл ОБА.СОРБ.18.01" бүтээл хүртсэн байна.

Эрдэмтэн, судлаачдын үзэл, бодол, дүгнэлт санал, судалгааны үр дүнг нийтийн хүртээл болгоход дэмжлэг үзүүлэх "Гамшиг судлал, инноваци" онол, арга зүйн мэргэжлийн сэтгүүлийг 2018 оноос эрхлэн гаргаж эхлэв.



■ Гамшгаас хамгаалах болон гамшгийн эрсдэлийг бууруулахад бодит хувь нэмэр оруулахуйц судалгаа, шинжилгээний ажил гүйцэтгэсэн гадаадын болон дотоодын байгууллага, судлаачдын баг, хувь хүнд олгох Хурандаа генерал С.Равдангийн нэрэмжит "Гамшигийн эрсдэлийг бууруулах" үндэсний шагналыг бий болгож, уг шагналд шалгарсан бүтээлд 10 сая хүртэл төгрөгийн мөнгөн шагнал олгох болов.

■ Цом нь дунд хэсэгтээ голчоос хажуу тийш товойсон квадрат, түүний дотор гурвалжин дүрслэлтэй. Энэ нь аюул, осол, гамшгийн хор уршгийг арилгаж, сэргээн босгох, даван туулах гэсэн утга илэрхийлнэ.

Дээд хэсэгтээ 45 хэмийн өнцөгдсөн, нүүрэн талдаа хурандаа генерал С.Равдангийн нэрэмжит үндэсний шагнал гэсэн хуучин монгол бичвэртэй, бичвэрийн дээд талд С.Равдангийн цээж зураг байрлуулсан.

Зурагны доод талд тарианы түрүү дүрсэлсэн, хоёр хажуу болон ар талд шүхэрчин аврагч, гал сөнөөгч, уул уурхайн аврах ажиллагаа, усчин аврагчдыг дүрсэлсэн бөгөөд энэ нь агаарт, газар дээр, газар доор, усан доор үйл ажиллагааг явуулдаг гэсэн утгатай.



ГАМШИГ СУДЛАЛ

Онцгой байдлын асуудал эрхэлсэн Монгол Улсын сайдын 2005 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 63 тоот тушаалаар гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох үйл ажиллагаанд орчин үеийн дэвшилтэд техник, технологи, инновацийг нэвтрүүлэх зайлшгүй шаардлага бий болж буйг харгалзан сургалт, судалгаа, шинжилгээний төвүүдийг нэгтгэж "Гамшгаас хамгаалах сургалт, эрдэм шинжилгээний хүрээлэн"-г байгуулав.

■ ОБЕГ-ын даргын 2006 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн ОБЕГ-ын даргын 546 тоот тушаалаар тус хүрээлэн нь Онцгой байдлын албаны эрдэм шинжилгээний хүрээлэн нэртэй болж, шинэчилсэн зохион байгуулалтаар Гамшгаас хамгаалах судалгааны төв, Галын шинжилгээний төв гэсэн хоёр төвтэй, 18 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж эхэлсэн байна.



▣ Монгол Улсын Засгийн Газрын 2008 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 156 тоот тогтоолоор Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Онцгой байдлын албаны эрдэм шинжилгээний хүрээлэнг Онцгой байдлын ерөнхий газрын харъяаны Гамшиг судлалын хүрээлэн болгон өргөтгөн зохион байгуулж, тус хүрээлэн нь 2008 оны 6-р сарын 16-нд БСШУЯ-наас Улсын бүртгэлийн гэрчилгээ авснаар Төрийн өмчийн 35 дахь эрдэм шинжилгээний хүрээлэн болсон юм.

Хүрээлэнгийн судалгааны ажлын цар хүрээ жилээс жилд гүнзгийрч анх байгуулагдахдаа гамшигт үзэгдлийн шинж чанарыг тодорхойлох төдийхнөөр хязгаарлагдаж байсан бол 2006 оноос гамшгийн эрсдэлийн түвшинг тогтоох судалгаанаас эхлээд 2008 оноос улс орны хэмжээнд гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, төрийн бодлогыг боловсруулахтай холбоотой судалгаа цаашлаад 2015 оноос гамшгаас хамгаалах салбарт дэвшилтэт арга барил, технологи, инновацийг нэвтрүүлэх чиглэлд улам бүр өргөжин тэлж байна. Хүрээлэнгийн бүтцэд 2018 оноос Нөөц судлалын төв байгуулагдаж манай оронд нөөц судлалыг хөгжүүлэх үндэс суурийг бүрдүүлж өгсөн.



■ "Эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ" сэдэвт анхны эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулав. 2006 он


2005-2018 онд судалгааны нийт 90 гаруй тайлан бичиж, судалгаа, шинжилгээний ажлын үр дүнд тулгуурлан сурах бичиг, ном, гарын авлага 53, эрдэм шинжилгээ, сурталчилгааны өгүүлэл 90 гаруйг дотоод, гадаадад нийтлүүлж, Монгол Улсын шинэ бүтээлийн 2 патент авч, стандарт, заавар зөвлөмж 30 гаруйг манай оронд түгээмэл тохиолддог байгалийн аюулт үзэгдэл, хүний үйл ажиллагаанаас үүдсэн ослын эрсдэлийг үнэлэх 30 гаруй аргачлал боловсруулсан.



■ Гамшиг судлалын хүрээлэнгийн судалгааны ажлын эмхэтгэл 2009-2017

Гамшигийн холбогдолтой үндсэн ойлголт, нэр томъёог тодорхойлж, нийтэд ойлгомжтой болгох зорилгоор нийт 126 нэр томъёо, тодорхойлолтуудыг багтаасан "Гамшигийн холбогдолтой нэр томъёо, ерөнхий анги" MNS6010-2009 үндэсний стандартыг анх удаа Стандартчлал хэмжилзүйн газрын Үндэсний зөвлөлөөр батлуулан гаргав.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд түгээмэл хэрэглэгддэг 600 гаруй нэр томъёог монгол, англи, орос хэлээр түүвэрлэж, эх хэл дээрх тайлбарын хамт эмхэтгэсэн "Гамшигийн нэр томъёоны тайлбар толь" -ийг 2012 онд хэвлүүлэв.




■ Тус хүрээлэн нь гамшигийн мэдээллийн сан, зайнаас тандан судлал хөгжихөд чухал үүрэг гүйцэтгэж ирсэн. Монгол оронд тохиолдсон аюулт үзэгдэл, ослын мэдээг аюул, ослын төрлөөр холбогдох үзүүлэлтийг хамтатган, аймаг, нийслэл, сум дүүргээр түүвэрлэж нэгдсэн загварт оруулан монгол, англи хэлээр гурван удаа хэвлэн гаргасан нь энэ салбартаа анхны мэдээний ном болсон юм.

"Онцгой байдлын албаны томъёолсон тэмдэг"-ийн эмхэтгэл болгон нийт 388 тэмдэг, тэмдэглэгээг тоон хэлбэрт хөрвүүлэх ажлыг 2014 хийсэн байна.

Гамшиг судлалын хүрээлэн нь 2015 онд MNS ISO/IEC-17025:2007 стандартын шаардлагад нийцүүлэн галын болон цацраг химийн лабораториудаа итгэмжлүүлсэн.



■ Галын лабораторид 2004-2018 онд жилд дунжаар аж ахуйн нэгж, иргэний хүсэлтээр 250 гаруй дээжинд галын аюулгүй байдлын дүгнэлт, "Шинжээч томилж, шинжилгээ хийлгэх тухай" мөрдөгчийн тогтоолтой 100 орчим дээжинд шинжээчийн дүгнэлт гаргадаг.



■ ААН, Байгууллага, иргэний хүсэлтийн тоо ■ Шинжилгээ хийсэн бүтээгдэхүүний тоо

■ 2005-2016 онд Галын лабораторид материалын галын аюулын үзүүлэлтийг тодорхойлсон бүтээгдэхүүний тоо ба шинжээчээр ажиллаж дүгнэлт гаргасан тоо



Химийн лабораторид энэ хугацаанд "Шинжээч томилж, шинжилгээ хийлгэх тухай" мөрдөгчийн тогтоолын дагуу жилд дунджаар 150 гаруй дээжинд шинжилгээ хийж дүгнэлт гаргадаг. Химийн лаборатори химийн хорт болон аюултай бодистой холбоотой нийт 50 гаруй удаагийн ослын голомтод ажиллаж, хэмжилт шинжилгээ хийн, хор уршгийг арилгах, саармагжуулах, хоргүйжүүлэх үйл ажиллагаанд мэргэжлийн туслалцаа үзүүлж ажилласан байна.



Цацрагийн лаборатори энэ хугацаанд 36 удаагийн дуудлагаар ажиллан, Улаанбаатар хотын цацрагийн фон хэмжих ажиллагааг тогтмол хийж ирсэн байна. Хүрээлэн нь үйл ажиллагаагаа өргөтгөн 2019 онд шатахууны лабораторийг шинээр байгуулаад байна.

Гамшгаас хамгаалах арга хэмжээнд нисгэгчгүй хөөрөх төхөөрөмжийг ашиглах боломж нөхцөлийг тодорхойлох судалгаа хийж, онцгой байдлын албанд уг төхөөрөмжийг ашиглах анхны гарын авлагыг боловсруулав.



Онцгой байдлын албаны алба хаагчдын зуны хээрийн хувцасны даавуунд нанотехнологийн боловсруулт хийн албан хаагчдад ажлын нөхцөл байдалд нь өмсөж хэрэглүүлэн туршилт хийж, дүрэмт хувцасны материалын эдэлгээний шинж чанарыг сайжруулах судалгаа хийгдсэн.

Монгол орны байгалийн шаварлаг түүхий эд болох цеолитийг үндсэн түүхий эдээр сонгон авч, химийн боловсруулалт хийж шингээх чадварыг нь нэмэгдүүлэх замаар химийн хорт бодисоос үүсэх аюулыг бууруулахад ашиглах "Шингээгч иж бүрдэл ОБА.СОРБ.18.01" бүтээлийг гарган авсан.



Газарзүй, геоэкологийн хүрээлэн, Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн, Байгалийн голомтот халдварт өвчин судлалын үндэсний төв, Барилгын хөгжлийн төв, Ургамал газар тариалангийн хүрээлэн, Ургамал хамгааллын хүрээлэн зэрэг байгууллагуудтай судалгаа, шинжилгээний ажлыг уялдуулан ажиллахын зэрэгцээ, тусгай чиг үүргийн хүрээнд Цагдаагийн ерөнхий газар, Авлигатай тэмцэх газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын хүрээнд гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж Унгар, ОХУ, БНСУ болон Япон улсын ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг хүрээлэн, их сургууль, төвүүдтэй болон Азийн гамшигийн аюулыг бууруулах төв, Азийн гамшигийн бэлэн байдлын төв зэрэг олон улсын судалгааны байгууллагатай хамтран ажиллаж байна.

2007 онд БНСУ-ын олон улсын хамтын ажиллагааны агентлаг (KOICA), Гамшигийн удирдлагын агентлаг (NEMA of Korea)-аас хэрэгжүүлсэн "Гамшгаас хамгаалах судалгааны төвийг хөгжүүлэх" 1,2 сая ам.долларын өртөг бүхий төслийг хэрэгжүүлж судлаач, эрдэм шинжилгээний ажилтнуудын ур чадварыг дээшлүүлж, хүрээлэнгийн байрыг өргөтгөн 3 давхар болгож, иж бүрэн химийн лаборатори суурилуулсан нь хүрээлэнгийн хөгжил, бэхжилтэд үнэтэй хувь нэмэр оруулсан юм.



2010 онд Гамшиг судлалын хүрээлэнд Азийн гамшигийн бэлэн байдлын төв, Япон улсын Агаар сансрын судалгаа, шинжилгээний газар (JAXA), UN-SCAP, UN-SPIDER, AP-SCO зэрэг байгууллагуудтай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд хиймэл дагуул, сансрын технологи, холбоо мэдээллийн технологийг ашиглан бүс нутгийн гамшигийн удирдлагад дэмжлэг үзүүлэх "Азийн харуул" 2 дахь шатны системийн бүсийн сервер "Виндс" антенныг суурилууллаа.



Японы Нагоягийн их сургууль, Монгол Улсын Их Сургуулийн Резилиенс хамтарсан судалгааны төвтэй хамтран 1957 оны Могодын газар хөдлөлтийн хагарлын хээрийн судалгаа, Улаанбаатар хот орчмын шинэ хагарлын хээрийн судалгааг хийв.



Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн, Үндэсний хөгжлийн хүрээлэн, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн, Олон улс судлалын хүрээлэн, Үндэсний тагнуулын академи, Олон улсын харилцааны сургууль, Монгол Улсын Их Сургууль, Стратеги судалгааны хүрээлэн, Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв зэрэг байгууллагуудтай Монгол улсын үндэсний аюулгүй байдлын асуудлаар судалгаа шинжилгээний ажлыг уялдуулах, мэдээлэл харилцан солилцох, эрдэм шинжилгээний байгууллагын гаргасан санал, зөвлөмжийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэх, үйл ажиллагааг нэгтгэх зорилготой санамж бичигтэй хамтран ажиллаж байна.

ТҮҮХЭН МУЗЕЙ



Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2015 оны А/262 дугаар тушаалын дагуу 2016 оны 06 дугаар сарын 20-нд буюу Онцгой байдлын байгууллагын 13 жилийн ойн өдрөөр Албаны түүхэн музей нээлтээ хийв.

■ Албаны музейд Онцгой байдлын албаны түүхэн замнал, анхдагч, гавьяат үйлстнүүдтэй холбоотой баримт сэлтүүд, цөмийн зэвсгээс хамгаалах хэрэгсэл, багажууд, сургалтын материал, ном, сурах бичиг, аврагч, гал сөнөөгчдийн хэрэглэж байсан хувцас, багаж хэрэгсэл, улсын нөөцөд хадгалагддаг бараа материалын дээж зэрэг 500 гаруй эд, өлгийн үнэт зүйлс дэлгэгдэж, олон нийтийн хүртээл болж байна.



Мөн төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагууд аймаг, орон нутаг болон байгууллагын үйл ажиллагаа, онцлогийг харуулсан "Түүхэн музей" -г байгууллаа.

БИЕ БҮРЭЛДЭХҮҮНИЙ СУРГАЛТ



Гамшгаас хамгаалах чиг үүрэгтэй байгууллагуудыг шинэ бүтэц, зохион байгуулалтад шилжсэн үед анхны Сургалтын хэлтсийн даргаар хурандаа Гансүх /Гал түймэртэй тэмцэх газрын/ томилогдож, 3 байгууллагын сургалтын нэгжид ажиллаж байсан бүрэлдэхүүн хамтран ажиллаж байжээ. Гамшгаас хамгаалах ангиллын сургалтаас гадна бие бүрэлдэхүүний сургалтыг зохион байгуулахад анхаарч аймаг, нийслэлийн Гамшгаас хамгаалах штаб, Улсын нөөцийн салбаруудын удирдах ажилтнуудын анхны сургалт-семинарыг 2004 онд зохион байгуулжээ.

Онцгой байдлын албаны чадавхыг дээшлүүлэх үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг нь нийт бие бүрэлдэхүүний мэдлэг, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх, тэмцэх, бэлтгэл бэлэн байдлыг хангахаар жил бүр тусгай удирдамж, төлөвлөгөөгөөр зохион байгуулдаг бие бүрэлдэхүүний сургалт байдаг.

14 жилийн түүхийн хугацаанд Онцгой байдлын ерөнхий газрын бүтцийн нэгж Бодлого төлөвлөлт, хамтын ажиллагааны газрын Сургалтын хэлтэс, Гамшгаас хамгаалах газрын Сургалт сурталчилгааны хэлтэс, Захиргааны удирдлагын газрын Хүний нөөцийн хэлтэс, Гамшгаас урьдчилан сэргийлэх газрын Сургалтын хэлтэст бие бүрэлдэхүүний сургалт болон хүний нөөцийн бодлого, сургалт хариуцсан мэргэжилтэн бие бүрэлдэхүүний сургалтыг хариуцан ажиллаж байжээ.



Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 08 дугаар тушаалаар батлагдсан “Онцгой байдлын ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн нэгжийн хөтөлбөр”-ийн Онцгой байдлын ерөнхий газрын үйл ажиллагааны гуравдугаар зорилт “Захиргааны удирдлагаар хангаж, боловсон хүчин, дотоод албаны болон бие бүрэлдэхүүний сургалтыг зохион байгуулах, хүний нөөцийн хөгжлийн бодлого, захиргааны эрх зүйн баримт бичгийг боловсруулж, хэрэгжүүлэх”-ийн тулд анх удаа бие бүрэлдэхүүний сургалтын нэгж “Сургалтын хэлтэс”-ийг 2018 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс байгуулан ажиллаж байна.

Онцгой байдлын байгууллага нь 2015 оны 85 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичигт зааснаар төрийн цэргийн байгууллагын бүрэлдэхүүнд орсонтой холбогдуулан “бие бүрэлдэхүүний сургалт” гэдэг нэр томъёог Зэвсэгт хүчний “цэргийн сургалт бэлтгэл”- гэсэнтэй дүйцүүлэн өөрчилж, Онцгой байдлын албаны сургалтын бодлого, Сургалт бэлтгэлийг зохион байгуулах ерөнхий журам, Сургалт бэлтгэлийг шалгаж үнэлэх зааврыг баталж, сургалт бэлтгэлийн агуулга, технологид өөрчлөлт хийж, штабын бэлтгэл, хамтарсан дадлага сургуульд ихээхэн анхаарал хандуулж ажилласан.



■ Онцгой байдлын ерөнхий газраас зохион байгуулдаг нэгдсэн сургалтын дүн мэдээнээс харвал, 2015 онд 20 удаагийн нэгдсэн сургалтад 580 алба хаагч хамрагдаж байсан бол 2018 оны эцсийн байдлаар 41 удаагийн нэгдсэн сургалтад 1751 алба хаагч хамрагдсан нь тухайн үеийнхээс даруй 3,5 дахин нэмэгдсэн байна.



▣ Сургалт бэлтгэлийг удирдан зохион байгуулах, хэрэгжүүлэх албан тушаалтныг бэлтгэх, чадавхжуулах, тэднийг сургагч багшаар сургаж хөгжүүлэх, улмаар сургах зүйн боловсрол олгоход анхаарч Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын яамны холбогдох газар, Боловсролын хүрээлэнтэй хамтран 4 удаа "Сургах зүйн боловсрол олгох сургалт"-ыг амжилттай зохион байгуулж, албаны хэмжээнд нийт 116 алба хаагчийг сургаж, багшлах эрхийн гэрчилгээг олгосон байна. Ингэснээр бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийг зохион байгуулахад сургалтын технологи, шинэчлэлийг хийх, заах арга зүйн чадвар эзэмшиж, сургалтын чанарт ахиц гарна гэж үзэж байна.



Онцгой байдлын ерөнхий газрын сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөнд асуудал хариуцсан мэргэжилтэн, тодорхой албан тушаалтны сургалтыг жил бүр тусган, алба хаагчдын мэргэжлийн мэдлэг, чадварыг дээшлүүлэн сургахын зэрэгцээ орчин үеийн техник технологийн хөгжлийн чиг хандлага, нийгэм, эрх зүйн орчны өөрчлөлт, хөгжлийг алдалгүй шинэлэг байдлаар сургалтыг явуулахад анхаарч, нисгэгчгүй нисэх төхөөрөмжийн, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэшүүлэх, газар зүйн мэдээллийн систем /ARC GIS/-ийн ашиглалт зэрэг сургалтуудыг холбогдох нэгжтэй нь хамтран зохион байгуулж байна.



Алба хаагчдад мэргэжил олгох, мэргэшүүлэх, боловсролын зэрэг ахиулах сургалтад суралцах боломжийг нэмэгдүүлж ДХИС-ийн ОБС-д бакалаврын үндсэн дамжаанаас гадна ахлагч бүрэлдэхүүнд 5 жилийн, офицер бүрэлдэхүүнд 3 ба 1.5 жилийн эчнээ дамжааны сургалтыг эхлүүлж, мөн Гамшиг судлалын магистр, докторын хөтөлбөрт офицеруудыг, Хууль сахиулахын удирдлагын болон Батлан хамгаалахын удирдлагын академид дунд шатны удирдах албан тушаалтнуудыг өдөр, эчнээ, гарагийн ангид суралцуулж байна.




■ 2018 оны байдлаар нийт алба хаагчдын 6% нь ажиллахын зэрэгцээ суралцаж байна.

ХСИС-д суралцагчдын тоон үзүүлэлт 252

• Бакалаврт суралцагчдын тоо-160


□ 1.5 жилийн эчнээ □ 3 жилийн эчнээ
□ 5 жилийн эчнээ ■ Үндсэн дамжаа



- Магистрын хөтөлбөрт суралцагчид -76
- Докторын хөтөлбөрт суралцагчид -16

Гадаадын их, дээд сургуульд суралцагчдын тоон үзүүлэлт

Гадаадад суралцагчдын тоо 63



■ Алба хаагчдын чадавхыг олон улсын түвшинд хүргэхийг чухалчилж, ОХУ /Австрали, Тайланд/-д магистрын хөтөлбөрт суралцдаг байсан бол одоо ОХУ-д бакалавр, магистр, докторын зэргээр, БНСУ, БНПУ, БНУУ, Япон улсуудад мөн зэргүүдээр суралцах нөхцлийг бүрдүүлж одоогоор 63 алба хаагч амжилттай суралцаж байна.



Төрөл мэргэжлийн аврагчид болон тусгай мэргэжлийн зарим сургалтыг Үндэсний батлан хамгаалахын их сургуультай хамтран ажиллах хүрээнд сургалтын хэрэгцээ, захиалга, хүсэлтийг өгч тусгай хөтөлбөрөөр алба хаагчдыг мэргэшүүлэн сургаж бэлтгэж байна. Тухайлбал, 2016 онд ой, хээрийн түймэр унтраахад ашиглах зорилгоор тусгай зориулалтын явган цэргийн байлдааны машины механик жолооч бэлтгэх сургалтыг тус их сургуулийн Цэргийн нэгдсэн сургууль, Зэвсэгт хүчний сургалтын нэгдсэн төвийг түшиглэн 45 хоногийн хугацаатайгаар явуулж 10 механик жолоочийг бэлтгэж, мөн тэсэлгээчин аврагчдыг 3 удаа 14 хоногийн хугацаатайгаар мэргэшүүлэх сургалтад хамруулж, давхардсан тоогоор 65 алба хаагчдыг мэргэшүүлжээ.



▮ Бүсийн офицер бүрэлдэхүүний штабын дадлага, команд штабын сургуулийн Гамшгаас урьдчилан сэргийлэх газар, Гамшигийн шуурхай удирдлагын газар хамтран нэгдсэн удирдамж, төлөвлөгөөгөөр зохион байгуулж, офицер бүрэлдэхүүнийг чадавхжуулж байна.

ОХУ-ын Тува улсад 2007 онд зохион байгуулагдсан “Тува улс болон хөрш зэргэлдээ Монгол Улсын нутаг дэвсгэрт шувууны томуу өвчин тархсан тохиолдолд Тува улсын Онцгой байдлын болон бусад байгууллагуудын ажиллагаа” сэдэвт команд штабын сургуульд Онцгой байдлын ерөнхий газраас холбогдох албан тушаалтнууд оролцсон байна.

Олон улсын Иргэний хамгаалалтын байгууллагаас Женев хотноо зохион байгуулагдсан “Томоохон хэмжээний байгалийн гамшгууд” сэдэвт сургалт-семинарт Онцгой байдлын ерөнхий газраас холбогдох албан тушаалтныг оролцууллаа.

БНСУ-ын Свёл хотноо болсон Химийн зэвсгээс хамгаалах, туслалцаа үзүүлэх сургалт, БНХАУ-ын Бээжин хотноо зохион байгуулагдсан “Хөгжиж буй орнуудын гамшигийн удирдлагын асуудал” сэдэвт сургалтад Онцгой байдлын ерөнхий газраас холбогдох албан тушаалтныг оролцуулжээ.

Филиппин Улсад 2008 онд зохион байгуулагдсан НҮБ-ын Хүмүүнлэгийн хэргийг зохицуулах албаны Эрэн хайх авран туслах олон улсын зөвлөлдөх бүлгийн Ази, Номхон далайн бүсийн хот суурин хот суурин газрын эрэн хайх ажиллагаа, газар хөдлөлт, хор уршгийг арилгах олон улсын дадлага сургуульд Онцгой байдлын ерөнхий газрын төлөөлөгчдийг оролцуулжээ.

БНТУ-ын Олон улсын хамтын ажиллагааны агентлагын шугамаар хүсэлт тавин тус улсын иргэний хамгаалалтын байгууллагын сургалтын төвийн багш, зааварлагчдыг урьж ирүүлэн Улаанбаатар хотноо газар хөдлөлтийн гамшигийн тухай сургалтыг зохион байгуулжээ. Сургалтад 60 гаруй алба хаагч оролцсон байна.

2010 онд Аляскийн үндэсний гвардиас АНУ-ын Аляска мужийн Анкорож хотноо зохион байгуулагдсан газар хөдлөлтийн “VIGILANT GUARD” сэдэвт дасгал сургуульд Онцгой байдлын ерөнхий газраас төлөөлөл оролцжээ.



Холбоочдын бүсчилсэн сургалтыг анх Булган аймагт 2011 онд зохион байгуулж, холбоо, зарлан мэдээлэл хариуцсан мэргэжилтэн, дуудлага хүлээн авагч, жолооч-холбоочдыг хамруулсан ба энэхүү сургалтыг жил бүр зохион байгуулж хэвшээд байна.




"Уснаас эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулах журам"-ыг хэрэгжүүлэх, аврагч-усчин, шумбагчдыг бэлтгэх, чадавхжуулах зорилгоор Онцгой байдлын байгууллагын мэргэжлийн аврагч-усчин, шумбагчийн анхан шатны сургалтыг 2014 онд Орхон аймгийн Эрдэнэт үйлдвэрийн усан спорт сургалтын төвд, 2016 онд нийслэлийн усан спорт сургалтын төвд, 2018 онд нийслэлийн Баянгол дүүргийн усан спорт сургалтын төвд нийт 155 алба хаагчдыг сургаж, 2019 онд дунд шатны сургалтыг Давтан сургалт сэргээн заслын төвийн харъяа Гүний усны сургалтын төвд нийт 23 алба хаагчдыг сургаж бэлтгэсэн.



Мөн ОХУ-ын ОБЯ-ны Байгалийн эрэн хайх, аврах отрядад уснаас эрэн хайх, аврах ажиллагааны "Сургагч багш" бэлтгэх сургалтад 2014 онд 10 хүнийг амжилттай бэлтгэсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын "Цэргийн бие бялдрын стандартыг тогтоон мөрдүүлэх тухай", Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын А/505 дугаар тушаалаар батлагдсан "Цэргийн биеийн тамирын бэлтгэлийн стандарт"-ыг Онцгой байдлын байгууллагын хэмжээнд мөрдүүлэн ажиллаж, сүүлийн 3 жилийн дүнгийн үзүүлэлтээр алба хаагчдын биеийн зохистой харьцаа сайжирч нийт алба хаагчдын 65% нь хэвийн жинтэй болоод байна.





Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018 оны А/397 дугаар тушаалаар "Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын бие бялдрын бэлтгэлжилтийн норматив"-ыг батлан 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдүүлж, жилд хоёр удаа сорил, шалгалт авч ажиллаж байна.



■ 2019 оны 01 дүгээр сард зохион байгуулсан Онцгой байдлын байгууллагын удирдах ажилтны цугларалтаар нийт удирдах бүрэлдэхүүнээс биеийн зохистой харьцаа, бие бялдрын бэлтгэлжилтийн нормативын сорил авав.

▶ Сургалтын хөтөлбөр төлөвлөгөөний дагуу алба хаагчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, бэлтгэл бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд офицер бүрэлдэхүүний команд штабын сургуулийг бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулж байна.



АНГИЛЛЫН СУРГАЛТ



Гамшгаас хамгаалах ерөнхий газрын даргын 2004 оны А/260 дугаар тушаалаар тус газар байгуулагдсанаас хойшхи анхны Гамшгаас хамгаалах команд штабын сургуулийг Баян-Өлгийн аймагт 2004 оны 08 дугаар сарын 05-06 ны өдрүүдэд зохион байгуулсан байна.

Сургуулийн удирдагчаар Гамшгаас хамгаалах ерөнхий газрын тэргүүн дэд дарга, хошууч генерал О.Үржин, штабын даргаар Бодлого зохицуулалтын газрын дарга, хурандаа Ч.Намсрайжав нар томилогдон ажиллаж, аймгийн төр захиргааны байгууллагууд, орон нутгийн гамшгаас хамгаалах албадын удирдлагууд нийт 85 алба хаагчийг хамруулан сургаж, дадлагажуулж байжээ.


Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2005 оны А/354 дүгээр тушаалаар 09 дүгээр сарын 14-17 ны хооронд Хөвсгөл аймагт анхны Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг зохион байгуулжээ. Сургуулийн бэлтгэл ажлыг хангуулахаар Мэргэжлийн удирдлагын газрын дарга, дээд ахмад Д.Батбаатараар ахлуулсан ажлын хэсэг ажилласан байна.

Уг сургуульд аймгийн төр захиргааны байгууллагууд, орон нутгийн гамшгаас хамгаалах албад, 24 сум, баг, 18 аж ахуйн нэгж, байгууллага, 2440 иргэн, 73 автомашин, техникийг хамруулсан байна.



Хөвсгөл аймгийн хэмжээнд явуулсан уг сургуулийг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, тэргүүн комиссар П.Даш, штабын даргаар Стратеги төлөвлөлт, гадаад харилцааны орлогч, стратегийн төлөвлөлтийн хэлтсийн дарга, тэргүүн ахмад Б.Ууганбаяр нар удирдан явуулжээ. Иж бүрэн сургуульд Монгол Улсын сайдын зөвлөх, хошууч генерал Д.Базарсад оролцож байжээ.





Түүхийн энэ хугацаанд Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг 19 аймагт 19 удаа, Команд штабын сургуулийг 19 аймаг, нийслэлийн дүүргүүдэд нийт 26 удаа тус тус зохион байгуулан явуулжээ. Эдгээрээс хамгийн их анхаарал татсан, хамгийн олон хүн хамруулсан дадлага сургуулиар 2019 оны 04 дүгээр сарын 24-26-ны өдрүүдэд зохион байгуулсан нийслэлийн Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль зүй ёсоор нэрлэгдэх юм.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 116 дугаар тогтоолын дагуу Онцгой байдлын ерөнхий газар, нийслэлийн Засаг даргын Тамгын газар хамтран 2019 оны 04 дүгээр сарын 24-27-ны өдрүүдэд нийслэлийн хэмжээнд гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг зохион байгууллаа. Энэ нь сүүлийн 29 жилийн хугацаанд нийслэлийн иргэдийг бүхэлд нь хамруулан зохион байгуулагдаж буй сургууль гэдгээрээ онцлог юм. Сургуулийн удирдагчаар ОБЕГ-ын дэд дарга, хурандаа Б.Ууганбаяр ажиллалаа.

■ Нээлтийн арга хэмжээнд нийт 116 байгууллагын 4408 томилгоот бүрэлдэхүүн жанжин Д.Сүхбаатарын талбайд жагсав.



■ Сургуулийн нээлтийн ёслолын арга хэмжээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газрын удирдлагууд оролцож, Монгол Улсын Ерөнхий сайд Ухнаагийн Хүрэлсүх нээж үг хэллээ.



Танхимын команд штабын сургуульд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, УИХ-ын Тамгын газар, Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага, яам, агентлаг, гамшгаас хамгаалах улсын алба, Нэгдсэн Үндэстний байгууллагын 12 кластер, нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, Онцгой комисс, Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын алба, дүүргүүдийн Онцгой комисс, нийслэлийн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, томоохон аж ахуйн нэгж, байгууллага, худалдаа үйлчилгээний төвийн томилгоот 890 гаруй удирдах албан тушаалтан оролцлоо.



■ Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийн хүрээнд нийслэлийн Засаг даргын захирамжаар Улаанбаатар хотын авто замын хөдөлгөөнийг бүрэн зогсоож, “Зарлан мэдээллийн дохио”-г нийслэл даяар дуугаргаж, нийслэлийн төвийн 6 дүүргийн иргэд аюулгүй талбайд “Нүүн шилжих” дадлага, сургуулийг зохион байгуулав. Энэ дадлага сургуульд нийслэлийн 101486 өрхийн 402.000 иргэн идэвхтэй оролцов. Нүүн шилжсэн талбайгаас тодорхой тооны иргэдийг газар хөдлөлтийн голомтоос нүүлгэн шилжүүлэх дадлага хийсэн. Уг дадлага сургуульд 6 дүүргийн 3725 иргэн хамрагдсан.



■ Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийн хүрээнд иргэдийг нүүлгэн шилжүүлэх дадлага сургуулийг нийслэлийн зургаан дүүрэгт зохион байгууллаа. Нүүлгэн шилжилт хийсэн шинэ суурьшлын бүсэд нийслэлийн хэмжээнд 200 гаруй гэр, майхан, 100 орчим байшин, платка байршуулж эмнэлэг, банк, сургууль, иргэдийг байршуулах байр зэргийг тохижуулан, нийслэлийн 3000 гаруй иргэнийг хамруулав.





■ Нийслэлийн Баянгол дүүрэг “Төмөр замын дээд сургууль”, Баянзүрх дүүрэг “Халдварт өвчин судлалын үндэсний төв”, Сүхбаатар дүүрэг “Централ тауэр”, Сонгинохайрхан дүүрэг “Номин агуулах”, Хан-Уул дүүрэг “Гэгээнтэн цогцолбор төвийн залгаа баригдаж байгаа барилга”, Чингэлтэй дүүрэг “Засгийн газрын 11 дүгээр байр”-ны талбайд эрэн хайх, аврах ажиллагааны дадлага сургуулийг тус тус зохион байгуулав. Тус сургуульд гамшгаас хамгаалах албад, мэргэжлийн анги, Үндэсний аврах бригад нийт 125 байгууллагын 1810 алба хаагч, 3500 гаруй иргэд, 185 тусгай зориулалтын автомашин техник, 56 нэр төрлийн 950 багаж хэрэгсэл, Үндэсний аврах бригадын Эрэн хайх, аврах салбар, Эрэлч нохойн алба оролцлоо.





■ Хээрийн эмнэлэг дэлгэх дадлага, сургуулийг Хүй долоон худаг “Монгол наадам” цогцолборт зохион байгуулсан. Хээрийн эмнэлэг дэлгэх үйл ажиллагаанд 21 байгууллагаас 512 хүн хүч, 79 автомашин ажиллав.




Нийслэлийн гамшгаас хамгаалах ижбүрэн сургуульд давхардсан тоогоор нийт 262 байгууллага, 484,642 хүн оролцож, 264 автомашин, 41 гэр, 135 платка дэлгэн зохион байгууллаа.



■ Хөвсгөл аймагт 2017 онд зохион байгуулагдсан Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийн үеэр орон нутгийн онцлогийг харгалзан анх удаа уснаас эрэн хайх аврах ажиллагааны үзүүлэх сургалтыг явууллаа.





■ Сүүлийн үед иргэд амарч зугаалах, ууланд авирах нь олширч, улмаар өндөр уулнаас эрэн хайх, аврах ажиллагааны дуудлагууд нэмэгдэх болсон. Тийм учраас Монгол Улсын хамгийн өндөр цэг болох Алтай Таван Богд, Хүйтний Оргил зэрэг өндөр уулсын орон Баян-Өлгий аймагт зохион байгуулсан Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийн хүрээнд анх удаа уулнаас эрэн хайх, аврах ажиллагааны дадлага сургуулийг зохион байгуулав.



■ Хөвсгөл аймагт зохион байгуулагдсан Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийн Газар хөдлөлтийн гамшгийн үеийн нүүлгэн шилжүүлэх дадлага сургуулиар 32 мянган иргэн аюулгүй талбайд цугласан нь Монгол Улсын хэмжээнд анхны тохиолдол болсон юм. 2017.04.11



Онцгой байдлын ерөнхий газрын дэргэд хэрэгжиж байгаа "Шувууны томуу, хүний томуугийн цар тахалтай тэмцэх чадавхийг сайжруулах төсөл"-ийн санхүүжилтээр тус төсөлтэй хамтран Гамшигтай тэмцэх газрын Сургалт, сурталчилгааны хэлтэс Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Өвөрхангай, Булган, Орхон, Хөвсгөл, Архангай, Баянхонгор, Завхан аймгийн сумдын Тамгын газрын дарга нарт "Гамшгаасхамгаалах арга хэмжээ" сэдэвт сургалтыг зохион байгуулжээ. Сургалтад нийт 130 хүн хамрагдсан.



Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339 дүгээр “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”, 340 дүгээр “Гамшгийн үеийн дайчилгаа, нүүлгэн шилжүүлэх журам”, 2017 оны 67 дугаар “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр” тогтоолоор батлагдсан журмын хэрэгжилтийн хүрээнд Онцгой байдлын байгууллагаас Монгол Улсын хэмжээнд “Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх” нэгдсэн сургалт, дадлага сургуулийг зохион байгуулж хэвшсэн.



2012-2019 онуудад Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор давхардсан тоогоор 2020 гаруй гамшгаас хамгаалах улсын болон орон нутгийн алба, 4209 орчим мэргэжлийн анги, 15476 гаруй аж ахуйн нэгж, байгууллага, иргэд олон нийтэд танхимын болон дадлага сургалтыг 25643 удаа зохион байгуулсан. Аюулгүй газарт нүүн шилжих дадлага сургуульд нийт 3.8 сая гаруй хүн хамрагдсан байна.



Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 303 дугаар тогтоолоор батлагдсан "Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын гамшгаас хамгаалах мэдлэгийг нэмэгдүүлэх, болзошгүй гамшгийн үед өөрийгөө болон бусдыг авран хамгаалах дадлыг эзэмшүүлэх зорилгоор "Өсвөрийн аврагч" тэмцээнийг жил бүр уламжлал болгон зохион байгуулж байна.



■ Улсын хэмжээнд 2016-2018 онд "Өсвөрийн аврагч тэмцээн"-д төв, орон нутгийн ерөнхий боловсролын сургуулиудын 487, "Өсвөрийн аврагч бүлэг"-ийн 3820 сурагч оролцож, гамшгаас хамгаалах мэдлэг, мэдээллээ дээшлүүллээ.



2018 онд Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хууль, Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр, Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд иргэд, олон нийтэд аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, өөрийгөө болон бусдыг авран хамгаалах, аюул, эрсдэлгүй орчинд аж төрөх мэдлэг боловсрол эзэмшүүлэх зорилгоор Онцгой байдлын ерөнхий газар, Дэлхийн Зөн-Монгол Олон улсын байгууллага, Монголын улаан загалмай нийгэмлэг, Жайка Олон улсын байгууллагатай хамтран "Бэлэн бай" багц сургалтын модулийг боловсруулав. Тус сургалтын багцаар 21 аймаг, 9 дүүрэгт 2229 удаагийн сургалтыг зохион байгуулж нийт 279791 хүнийг хамруулаад байна.





Онцгой байдлын ерөнхий газар НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран сургуулийн өмнөх наснаас эхлэн бүх насны суралцагчдад зориулсан сургалтын хөтөлбөр, сэдэвчилсэн төлөвлөгөөний төслийг цогц байдлаар боловсруулан БСШУС-ын сайдын А/103 дугаар тушаалаар 2017-2018 оны хичээлийн жилээс эхлэн "Гамшгаас хамгаалах менежментийн үндэс" хичээлийг их, дээд сургуулиудын заавал судлах суурь хичээлийн хөтөлбөрт орууллаа. Энэ нь оюутнуудад гамшгаас хамгаалах, гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны үндсэн ойлголт, болзошгүй аюул, ослын эрсдэлийг үнэлж, урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах арга хэмжээг удирдан зохион байгуулах чадвар, дадал эзэмшүүлэх чухал ач холбогдолтой юм.



➤ **Онцгой байдлын ерөнхий газраас БСШУСЯ, Боловсролын хүрээлэн, Багшийн мэргэжил дээшлүүлэх институттэй хамтран "Аюулгүй амьдрах ухаан" сургалтын хөтөлбөрийг боловсруулж, БСШУС-ын сайдын 2018 оны 04 дүгээр сарын 06-ны 181 дүгээр тушаалаар батлуулан, 2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулиудад хэрэгжүүлж байна.**

"Аюулгүй амьдрах ухаан"-ы сургалтыг цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хөтөлбөрт оруулсантай холбогду орон нутгийн сургагч багш бэлтгэх сургалтыг улсын хэмжээнд зохион байгуулж, 150 гаруй сургагч багш бэлтгээд байна.



Онцгой байдлын ерөнхий газар АНУ-ын Ойн албатай харилцан хамтын ажиллагааг "Гэнэтийн ослын удирдлага" сургалтыг анх 2013 онд Булган аймагт зохион байгуулж байсан бол 2016 онд цуврал сургалтыг явуулжээ.



2019 оны 04 дүгээр сарын 01-05-ны өдрүүдэд "Гэнэтийн ослын удирдлага" сэдэвт сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгууллаа. Сургалтын зорилго нь Гэнэтийн ослын удирдлагын тогтолцоог Монгол Улсын гамшгийн удирдлагын тогтолцоонд нэвтрүүлэх сургагч багшийг бэлтгэх бөгөөд сургалтаар олж авсан мэдлэгийг нийслэлийн хэмжээнд зохион байгуулагдсан Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийн үеэр туршин үзсэнээрээ онцлог юм.



■ Сургагч багшийг бэлтгэх сургалтад Онцгой байдлын ерөнхий газар, нийслэлийн Онцгой байдлын газар, Гамшгаас хамгаалах улсын албад, баруун, хойд, өмнөд, зүүн бүсийн Онцгой байдлын газрын төлөөлөл нийт 45 алба хаагч хамрагдав.



ОЛОН УЛСЫН СУРГАЛТ, ДАДЛАГА

➤ Онцгой байдлын байгууллага нь гамшгаас хамгаалах төрөөс баримтлах бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах, хүн амыг аюулгүй амьдрах зан үйлд сургах, төлөвшүүлэх, алба хаагчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх ажлыг зөвхөн дотоодын сургалтаар хязгаарласангүй. Алба хаагчдаа олон улсын хэмжээнд сургалтад оролцуулж, өөрийн улсад олон улсын сургалтуудыг зохион байгуулж ирсэн.

АНУ-ын Номхон далайн цэргийн командлал, Аляскийн үндэсний гвардын төлөөлөгчид Монгол Улсад айлчлан “Гамшгийн бэлэн байдал болон аюулыг бууруулах ажиллагааг үнэлэх хөтөлбөр”-ийг 2005 оноос хэрэгжүүлэхээр тохиролцсон байна. Улмаар 2005 онд АНУ-ын Аляскад зохион байгуулагдсан Гамшгийн үеийн харилцан ажиллагаа хээрийн сургуульд Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын удирдах албан тушаалтан ажиглагчаар оролцож байжээ.



■ Харин 2007 онд Онцгой байдлын ерөнхий газрын даргын А/346 дугаар тушаалаар Монгол Улсад анх удаа Эрэн хайх, аврах олон улсын зөвлөлдөх бүлэг /INSARAG/- тэй хамтран “Газар хөдлөлтийн үед хотын дотор эрэн хайх, аврах ажиллагаа”-ны дадлага сургуулийг 07 дугаар сарын 31-нээс 08 дугаар сарын 02-ны хооронд зохион байгуулжээ. Уг сургуульд 13 улс, олон улсын 8 байгууллагын 76 төлөөлөгч оролцож байв.



Хоёр дахь хамтарсан олон улсын дадлага сургуулийг Улаанбаатар хотноо 2015 оны 06 дугаар сарын 22-26-ны өдрүүдэд зохион байгуулав. Уг сургуульд Монгол, Индонез, Шри Ланка, Камбож, Малайз, Тайланд, Филиппин, Австрали, БНХАУ, АНУ, Япон, Шинэ Зеланд, ОХУ, Швед, Швейцарь, Арабын нэгдсэн Эмират, Их Британи гэх мэт 30 орчим орны 120 гаруй зочид төлөөлөгч оролцсон.




■ *Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар 2018 оны 08 дугаар сард анх удаа өндөр ууланд эрэн хайх, аврах ажиллагааны олон улсын хамтарсан дадлага сургалтыг Баян-Өлгий аймгийн Цэнгэл, Улаанхус сумдын нутагт орших Алтай таван богд ууланд зохион байгуулсан. Дадлага сургалтыг Монгол Улс, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Киргиз Улсын Онцгой байдлын яам, агентлагийн мэргэжлийн сургагч багш нар, уулын спортын мастерууд удирдан явуулж, Алтай таван богд уулын "Малчин" оргилд /4056м/ дээрх гурван улсын 65 алба хаагч нэгэн зэрэг амжилттай авиралт хийсэн.*



Дадлага сургалтад Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Ховд аймгийн Онцгой байдлын газрууд, Зэвсэгт хүчний 331, 340 дүгээр анги, Монголын уулчдын үндэсний холбоо, ОХУ болон Киргиз Улсын уулын спортын сургагч багш нийт 98 хүн, 21 техник хэрэгсэлтэйгээр оролцов.

■ Онцгой байдлын ерөнхий газраас баруун бүсийн таван аймгийн Онцгой байдлын газарт уулын аврах ажиллагааны иж бүрэн хувцас, хэрэглэлийг олгож, туршилт судалгааны ажил, сургалт дадлагыг амжилттай зохион байгуулсан.

Онцгой байдлын ерөнхий газар Америкийн Нэгдсэн Улсын Гамшгийн удирдлага, хүмүүнлэгийн тусламжийн сургалтын төвтэй хамтран "Говийн чоно-01" сургалтыг анх удаа 2009 оны 03 дугаар сарын 30-ны өдрөөс 04 дүгээр сарын 10-ны өдрүүдэд зохион байгуулжээ. Тус сургууль нь "төмөр замын ослын үеийн улсын албадын харилцан ажиллагаа" сэдвийн хүрээнд зохион байгуулагдсан бөгөөд нийт 56 алба хаагч оролцсон байна.



➤ Онцгой байдлын ерөнхий газар, АНУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны цэргийн атташегийн алба, АНУ-ын Ази, Номхон далайн цэргийн командлал, Аляскын үндэсний гвардтай хамтран өдгөө Улаанбаатар хот, Орхон, Өмнөговь, Ховд аймгуудад "Говийн чоно" олон улсын дадлага, сургуулийг нийтдээ долоон удаа зохион байгуулаад байна.



"Говийн чоно" олон улсын сургалт, дадлага сургуулийн хүрээ жилээс жилд өргөжин, олон улсын түвшинд хүрч, харилцан туршлага солилцож, жил ирэх бүр ажиглагч улс орнууд болон гадаад, дотоодын оролцогчдын тоо нэмэгдэж байгаа нь сургуулийн үр дүн, ач холбогдлыг тодорхойлж байна.

Тухайлбал, Ховд аймагт зохион байгуулагдсан "Говийн чоно-2018"-д Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс аймгийн Онцгой комисс, Онцгой байдлын газруудын алба хаагчид, гамшгаас хамгаалах улсын болон орон нутгийн албад, яам, агентлагийн төлөөлөл, АНУ-ын оролцогчдоос гадна Балба, ШриЛанка улсын төлөөлөл, Австрали, Канад, Франц улсын Элчин сайдын яамд, НҮБ-ын төрөлжсөн агентлагийн төлөөлөл болон гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг олон улсын байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн 350 гаруй төлөөлөгч оролцсон юм.



НАЙМДУГААР БҮЛЭГ

БИДНИЙ БАХАРХАЛ



Онцгой байдлын алба нэр шигээ онцлог ихтэй, онцгойрох зүйл арвинтай билээ. Хийж бүтээж, хөгжил дэвшлийн төлөө зүтгэсэн 15 жилийн хугацаанд албаны хувьд бэхжиж, ажил үйлс, амжилт бүтээлээрээ төрдөө нэртэй, түмэндээ хүндтэй, алдрыг олсон албыг бид бүтээж чаджээ. Хүний амьдралаар бол хүслийнхээ жигүүрийг дөнгөж дэлгэж буй энэ 15 жилд Онцгой байдлын хэмээн өөриймсөн овоглох хоёр генерал цолтон,

ахмад үеийнхээ амжилтыг буухиалан аврагчдын дундаас төрсөн залуухан гавьяаттайгаа нийлээд таван "Үйлчилгээний гавьяат ажилтан", нэг "Гавьяат аграномич", нэг "Ардын багш"-ийг эгнээнээсээ төрүүлсэн байна. Энэ бол Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын хүлээсэн үүргээ нэр төртэйгөөр биелүүлсээр ирснийг Монгол Улсын Төр засаг, ард түмэн үнэлж буйн томоохон илрэл, бидний бахархал билээ.



Нэгдсэн тогтолцоонд шилжиж, Онцгой байдлын байгууллага байгуулагдсанаас хойш 11 жилийн дараа 2015 оны 03 дугаар сарын 18, Монгол цэргийн өдрөөр ОБЕГ-ын дарга Т.Бадрал бригадын генерал цол хүртсэн нь Онцгой байдлын байгууллагаас төрсөн анхны цэргийн дээд цолтон болсон юм. Мөн 2017 онд Тулгар төрийн 2226 жил, Их Монгол Улс байгуулагдсаны 811 жил, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 106 жил, Ардын хувьсгалын 96 жилийн ой, Үндэсний их баяр наадмыг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар тус албанаас төрсөн анхны хошууч генерал цолтон болсон билээ.

Онцгой байдлын байгуулага 2017 оны 03 дугаар сарын 18-нд хоёр дахь цэргийн дээд цолтноо хүлээн авав. Монгол цэргийн өдрийг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар ОБЕГ-ын тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга Г.Ариунбуян бригадын генерал цол хүртсэнээр Онцгой байдлын албанаас төрсөн хоёр дахь цэргийн дээд цолтон болсон юм.





Лувсанчимэдийн СОСОРБАРАМ

Монгол түмний уламжлалт сар шинийн баярыг тохиолдуулан 2019 оны 02 дугаар сарын 03-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Монгол Улсын гавьяат багш, улсын арслан Л.Сосорбарамыг "Ардын багш" цолоор шагнасан юм.

1959 онд 22 настайдаа Монголын үндэсний бөхийн улсын начин цолыг, заан цолтой нь нэг өдөр хэдхэн цагийн зайтайгаар авч, 1963 онд МБАТ-ний хоёрдугаар спартакиадаар 30 бөхийн тойргийн барилдаанд ганц ч өвдөг шороодолгүй түрүүлж улсын арслан цол хүртэж, Үндэсний их баяр наадамдаа 16 удаа шөвгөрч байсан тэрбээр Үндэсний бөхийн улсын шүүгч, бөхийн чөлөөт, самбо, жудогийн төрлөөр Олон улсын болон өөрийн орны уралдаан тэмцээнүүдэд олонтаа оролцож аваргын алт болон мөнгө, хүрэл зэрэг 20 гаруй медаль хүртсэн спортын мастер цолтон гэдгийг бөх сонирхогч түмэн андахгүй мэдэх биз ээ.

Мөн тэрбээр Улсын иргэний хамгаалалтын салбарт буюу ХААИС-ийн Иргэний хамгаалалтын багшаар ахлах дэслэгчээс дэд хурандаа хүртлээ 40 гаруй жил ажилласан ахмад зүтгэлтэн учир ийнхүү Онцгой байдлын байгууллагын бахархах үйлстнээр зүй ёсоор нэрлэгдэж байгаа билээ.

МАНАЙ ГАВЬЯТУУД



Түмбүүгийн ОТГОН

Тэртээ 1966 онд Нийслэлийн Аврах, гал унтраах 10 дугаар ангийн гал сөнөөгчөөс ажлын гараагаа эхэлж, тус газрын орлогч, сургалт хариуцсан ахлах байцаагчаар тасралтгүй 50 орчим жил ажилласан бэлтгэл дэд хурандаа Т.Отгоныг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар 2005 онд Үйлчилгээний гавьяат ажилтан цолоор шагнасан юм.

Гал түймэр, үер усны аюулаас 50 гаруй хүний амь нас, төр, аж ахуйн нэгж байгууллагын 260,5 гаруй сая төгрөгийн эд хөрөнгийг авран хамгаалсан тэрбээр шинэ залуу гал сөнөөгчдийг сургаж дадлагажуулах, гал унтраах хүнд хөдөлмөрийг боловсронгуй болгох талаар шинэлэг арга барил нэвтрүүлэх, Гал унтраах техникийн олон төрөлт спортыг хөгжүүлэхэд үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулсан шилдэг тамирчин, олон улсын хэмжээний мастер, багш, дасгалжуулагч билээ. Түүний шавь нараас эдүгээ спортын мастер, дэд мастерын болзол хангасан олон шилдэг тамирчин төрөн гарсан нь гал унтраах мэргэжлийн спорт болон гал сөнөөгчдийн бие бялдрыг хөгжүүлэхэд үнэлж баршгүй хувь нэмэр, үлгэр дууриал болсоор байна.



Гаргилын НЭРГҮЙ

Хөдөө аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх, хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмрээ оруулсан тэрбээр даршийг үр тариагаар хачирлан тариалах, уриншийг эдлэншүүлэх цогцолбор технологи, үр тариа хураах ажилд цагийн графикийг боловсруулан ургац хураалтын хугацаа алдалгүй хаягдал багатай хураан авах технологийг хэрэгжүүлж, үр тариаг автомашинаас буулгах хугацааг хоёр дахин багасгах төхөөрөмж санаачлан ШБОС-ын гэрчилгээ авсан байна.

Харин улсын нөөцөд өвс, тэжээл бэлтгэх зорилгоор хадлангийн салаа санаачлан зохион байгуулсан нь өвсийг хямд зардлаар бэлтгэн нийлүүлж, салбарын төсвийн санхүүжилтийн 30-35 хувийг бүрдүүлж байжээ.

Ийнхүү түүний газар тариалангийн салбар төдийгүй Онцгой байдлын байгууллагын тулгын чулуу болсон улсын нөөцийн байгууллагад оруулсан хувь нэмэр, хүч хөдөлмөр, зүтгэлийг төр засгаас үнэлж 2007 онд "Гавьяат агрономич" цолыг хүртээсэн юм.



Пүрэвийн ДАМДИН

Бэлтгэл хурандаа, доктор П.Дамдингийн хувьд 1973-1990 онд улс, аймаг, хот, улсын алба, тусгай газар, олон нийтийн төв байгууллага, сум, дүүрэг, байгууллагуудын иж бүрэн сургууль явуулах, бэлэн байдлыг хангах, штаб, алба, мэргэжлийн ангийн бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, хууль эрхзүйн баримт бичгийг боловсруулах зэрэг үндсэн асуудлуудыг хариуцан, нийт 84 байгууллагатай хамтран ажиллаж, аймаг, хот, дүүрэгт давхардсан тоогоор 157 удаа, улсын алба яам, тусгай газарт 118 удаа очиж ажиллан, 142 удаагийн сургуулийн бодлого, төлөвлөгөөг боловсруулж удирдан явуулсан байна. Улмаар 1981 онд Улсын иргэний хамгаалалтын оперативын төлөвлөгөөг боловсруулан батлуулах ажлыг гардан гүйцэтгэсэн бол 2013-2014 онд "Монгол Улсын иргэний хамгаалалтын төлөвлөгөө"-г Монгол Улсын гамшгаас хамгаалах өнөөгийн эрхзүйн орчин, бодлого, хэрэгцээ, шаардлага, олон улсын жишигт нийцүүлэн боловсруулсан нь Онцгой байдлын байгууллагын түүхэнд онцлон тэмдэглэгдэх гавьяат үйлсээр үнэлэгдэж, төр засгаас "Үйлчилгээний гавьяат ажилтан" цолоор шагнасан юм.

Мөн тэрбээр гамшгийн удирдлагыг боловсронгуй болгох, эрхзүйн орчин бий болгох, хуучин тогтолцооноос шинэ тогтолцоонд оруулах бодлогын төлөвлөлт, сургалт, сурталчилгааны баримт бичгүүд боловсруулах, онол арга зүйн олон арван ном, гарын авлага бэлтгэж олны хүртээл болгосон билээ.



Сосорбарамын БААВГАЙ

Ажиллах хугацаандаа хамт олноо удирдан зохион байгуулж, давхардсан тоогоор 61 аймаг, сум, суурин газарт гамшиг ослын 1232 удаагийн дуудлагаар үүрэг гүйцэтгэн 82 хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалж, 268 буцалтгүй нэрвэгдэгчийг гаргажээ.

Мөн Төв, Сэлэнгэ, Архангай, Хөвсгөл, Булган, Хэнтий, Завхан аймаг болон нийслэлийн ногоон бүсэд гарсан ой, хээрийн түймрийн голомтод хариуцсан салаагаа удирдан зохион байгуулж, 3200 гаруй мал амьтан, 20 гаруй өвөлжөө, хаваржаа, 200 тонн өвс, 60 айлыг гал түймрийн аюулаас авран хамгаалж, албан үүргээ амжилттай биелүүлсэн гавьяа зүтгэлийг Монгол Улсын төр засгаас үнэлэн "Үйлчилгээний гавьяат ажилтан" цолыг хүртээсэн юм.

Тэрбээр сургагч багш төдийгүй үлээвэр хөгжимчин, Соёлын тэргүүний ажилтан бөгөөд барилгын цэргийн 158, Зэвсэгт хүчний 122 дугаар ангийг мэргэжлийн үлээвэр найрал хөгжимтэй болоход идэвх санаачлагатай ажиллажээ.



Дамбын ХИШИГБААТАР

Онцгой байдлын байгууллагын тулгын гурван чулууны нэг Гал түймэртэй тэмцэх байгууллагын хууль эрхзүйн орчныг бүрдүүлэх, материаллаг баазыг бэхжүүлэх, мэргэжлийн боловсон хүчнийг сургаж бэлтгэхэд үнэтэй хувь нэмрээ оруулж, 1999 онд Галын аюулгүй байдлын тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг ахлан хуулийг УИХ-аар батлуулсан бол 2015 онд шинэчлэн найруулах ажлын хэсэгт мөн ажилласан юм.

Түүнчлэн Улаанбаатар хотын Гал түймэртэй тэмцэх хэлтсийн техник, холбооны хэрэгслийг шинэчлэн сайжруулахад байнга анхааран ажиллаж, нийслэлийн нутаг дэвсгэрт гарсан 24 мянга гаруй гал түймрийг унтраах ажиллагааг удирдан, аж ахуйн нэгж, иргэдийн 85.2 тэрбум төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгаалсан байна.

Гал түймэртэй тэмцэх газрын даргаар ажиллах хугацаандаа мэргэжлийн боловсон хүчнийг сургаж бэлтгэхэд онцгой анхаарч, эдийн засгийн хүндрэлтэй нөхцөлд санхүүгийн эх үүсвэрийг галын гэрээт байгууллагуудаас төвлөрүүлж,

ОХУ-ын Гал эсэргүүцэх академид боловсон хүчнээ тасралтгүй бэлтгэж ирсэн төдийгүй үндэсний боловсон хүчин бэлтгэх анхны суурийг тавьж, Цагдаагийн дээд сургуульд галын техникийн анги бий болгосон нь өнөөдөр сургууль болтлоо өргөжин 450 гаруй мэргэжлийн алба хаагч төгсгөөд байгаа юм.

Монголын гал унтраах техникийн олон төрөлт спортын холбооны дэд ерөнхийлөгч, ерөнхийлөгчөөр сонгогдон ажиллаж материаллаг баазыг бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн тэрбээр ОБЕГ-ын Ахмадын хорооны удирдах зөвлөлийн дарга, Онцгой байдлын байгууллагын Ахмадын холбооны тэргүүнээр сонгогдон Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль, ахмад настны талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд идэвх санаачлагатай ажиллаж ирсэн зэрэг гавьяа зүтгэлийг нь төр засаг үнэлж 2018 онд "Үйлчилгээний гавьяат ажилтан" цол хүртээсэн юм.

Жамсрангийн БАЯРТОГТОХ

ОБЕГ-ын харьяа Үндэсний аврах бригадын тэргүүн ахлагч Ж.Баяртогтох нь 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдөр Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний баярын өдрийг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар "Үйлчилгээний гавьяат ажилтан" цолыг хүртэж, ажил үүргээ гүйцэтгэж байгаа аврагчдын дундаас энэхүү эрхэм цолыг хүртсэн залуу гавьяат гэдгээрээ Онцгой байдлын байгууллагын түүхэнд нэрээ мөнхөллөө.

Тэрбээр Онцгой байдлын байгууллагад 14 дэх жилдээ ажиллаж байгаа бөгөөд ажиллах хугацаандаа ой хээрийн түймэр унтраах ажилд 60 гаруй удаа томилогдон 720 гаруй хоног түймрийн голомтод үүрэг гүйцэтгэж, олон мянган га ой мод, малын бэлчээр, 1000 гаруй айл өрхийн эд хөрөнгө, 3000 гаруй тонн хадлан тэжээл, галын аюулд өртөж амь насаа алдаж болзошгүй 1500 гаруй иргэний амь насыг авран хамгаалсан бол усны ослоос 45 буцалтгүй нэрвэгдэгчийг гаргаж, үерийн усанд хашигдсан 5000 гаруй толгой мал, 18 иргэний амь насыг аварч, 60 гаруй айл өрхийг нүүлгэн шилжүүлэх ажилд оролцож, төр, ард түмний өмнө хүлээсэн үүргээ амжилттай биелүүлж явна.

Түүнчлэн 2011 онд Хөвсгөл нууранд "НИК" ХХК-ийн шатахуун тээвэрлэгч хоёр автомашин осолдож, нэг иргэн нас барсан ослын дуудлагаар өдөртөө -24-26 хэм, шөнөдөө 34-36 хэм хүйтэн байгаль, цаг уурын хүндрэлтэй нөхцөлд, нуурын эргээс 220 метрийн зайд, 54 метрийн гүнээс 13.2 тонн шатахуунтай хоёр автомашиныг татан гаргах үүргийг долоо хоног гүйцэтгэхдээ 192 метр куб мөсийг хагалж зурвас гарган байгаль орчинд учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлж, аврах үйл ажиллагаанд мэргэжлийн өндөр ур чадвар гарган хариуцсан бүлгээ амжилттай удирдан зохион байгуулж байлаа. Энэхүү аврах ажиллагаа нь монголын усчин аврагчид түүхэндээ хамгийн гүнд шумбаж аврах ажиллагаа явуулсан гэдгээр тэмдэглэгдэн үлдсэн.

Мөн 2011 онд Японд болсон цунамиин гамшгийн голомтод болон Африкийн Өмнөд Судан улсад Энхийг дэмжих ажиллагаанд, 2015 онд ОХУ-д гарсан ойн түймэрт үүрэг гүйцэтгэж, Монгол Улсынхаа төдийгүй Онцгой байдлын байгууллагынхаа нэрийг өндөрт өргөн ажиллаж байгаа шилдэг албан хаагчдын нэг юм.





Онцгой байдлын байгууллагын хөгжил дэвшлийн 15 жилд Монгол цэргийн өдөр, Үндэсний их баяр наадам, Үндэсний эрх чөлөө, Тусгаар тогтнолын өдрүүдийг тус тус тохиолдуулан нийт 2200 алба хаагч төрийн дээд одон медаль болон Онцгой байдлын байгууллагын шагналаар шагнагдсан байна.



АРДЫН БАГШ
1



ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАВЬЯАТ АЖИЛТАН
6



ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ УЛААН
ТУГИЙН ОДОН
49



ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН
ТУГИЙН ОДОН
18



АЛТАН ГАДАС
61



ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОН
161



ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛЬ
679



ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛЬ
144



ШУДАРГА ЖУРАМ
246



ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН
405



ОНЦ ГАЛ СӨНӨӨГЧ
430



Монгол Улс Олон улсын иргэний хамгаалалтын байгууллагад 1992 онд ажиглагч, 2002 онд жинхэнэ гишүүнээр элссэн билээ.

Олон улсын иргэний хамгаалалтын байгууллага нь гамшгаас хамгаалах чиглэлээр амжилт гаргасан хүмүүсийг "БААТАР" одонгоор шагнадаг уламжлалтай.

Монгол Улсаас энэхүү нэр хүндтэй шагналыг дараах алба хаагчид хүртжээ.

2005 он:

Нийслэлийн Баянгол дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга, дээд ахмад Г.НЭРГҮЙ

2009 он:

Нийслэлийн Онцгой байдлын газрын дарга, дээд ахмад С.ЦОГТБААТАР

Ховд аймгийн Онцгой байдлын хэлтсийн дарга, дээд ахмад Я.БУЯНТӨР

2010 он:

Төв аймгийн Онцгой байдлын хэлтсийн дарга, дээд ахмад Л.ГАНБАТ,

НОБГ-ын Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга, дээд ахмад А.ДАМЦАГДОРЖ,

Аврах тусгай ангийн шүхэрчин-гал сөнөөгч, дээд түрүүч Д.ЗУУННАСТ

2011 он:

ОБЕГ-ын Гал түймэртэй тэмцэх газрын Гал түймэртэй тэмцэх хэлтсийн дарга, дээд ахмад Я.ИШЖАМЦ,

Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газрын дарга, дээд ахмад Ш.ЛХАГВАСҮРЭН,

Аврах тусгай ангийн бүлгийн дарга, шадар дэслэгч Х.ӨЛЗИЙХУТАГ

2013 он:

Нийслэлийн Онцгой байдлын газрын дарга, онцгой байдлын хурандаа Н.УЛАМБАЯР,

Аврах тусгай ангийн захирагч, онцгой байдлын хурандаа Д.ЧИНЗОРИГ,

НОБГ-ын Сүхбаатар дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга, онцгой байдлын хурандаа Б.ГАНБАТ

2014 он:

Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга, хурандаа Т.БАДРАЛ

Нийслэлийн Аврах ангийн Эрэн хайх салбарын усчин аврагч, ахлах ахлагч Л.ЭНХТӨР

НОБГ-ын Баянгол дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга, хурандаа Ё.АМАРБАЯСГАЛАН,

Архангай аймгийн Онцгой байдлын хэлтсийн Эрэн хайх салбарын аврагч, ахлах ахлагч Ч.БЯМБАЖАВ,

Аврах тусгай ангийн захирагч, хурандаа Д.НАМСРАЙ,

Дорнод аймгийн Онцгой байдлын хэлтсийн Эрэн хайх, аврах салбарын аврагч, жолооч, холбоочин

ахлах ахлагч Д.АМАРБААТАР,

Хөвсгөл аймгийн Онцгой байдлын хэлтсийн Эрэн хайх, аврах салбарын аврагч, гал сөнөөгч

ахлах ахлагч Р.БАЯНМӨНХ,

Өвөрхангай аймгийн Онцгой байдлын хэлтсийн дарга, хурандаа Т.ЭНХБААТАР,

Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын хэлтсийн дарга, хурандаа Б.УУГАНБАЯР,

Булган аймгийн Онцгой байдлын хэлтсийн дарга, хурандаа Д.УУГАНБАЯР

2016 он:

ОБЕГ-ын Гал түймэртэй тэмцэх газрын дарга, хурандаа С.ЗАЛУУХҮҮ,

Аврах тусгай ангийн ахмад дайчин, бэлтгэл ахлах дэслэгч С.БААВГАЙ

2017 он:

Гамшиг судлалын хүрээлэнгийн Гамшигийн удирдлагын судалгааны төвийн дарга, хошууч генерал П.ДАШ,

ОБЕГ-ын Бодлого зохицуулалт, хамтын ажиллагааны газрын Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга,

хурандаа Ч.АРИУНАА,

Онцгой байдлын ерөнхий газрын ахмад ажилтан, бэлтгэл хурандаа Т.ОТГОН

2018 он:

Нийслэлийн Аврах анги-105-ын Эрэн хайх, аврах салбарын аврагч, ахлах ахлагч Г.ОТГОНБАЯР,

Төв аймгийн Онцгой байдлын газрын Эрэн хайх, аврах 24-р ангийн аврагч-гал сөнөөгч,

ахлах ахлагч Г.БАЯРСАЙХАН,

Дорнод аймгийн Онцгой байдлын газрын Эрэн хайх, аврах салбарын аврагч, ахлах ахлагч Ж.АСМАРЖАРГАЛ,

Үндэсний аврах бригадын Агаарын ажиллагааны салбарын захирагч, шүхрийн ахлах зааварлагч,

ахмад Ж.ГЭРЭЛТ-ОД

САЛБАРЫН ЭРДЭМТЭД

Гамшиг судлал нь өөрөө байгалийн болон нийгмийн шинжлэх ухааны олон салбарыг хамардаг салбар дундын шинжлэх ухаан. Тийм ч учраас зөвхөн гамшиг судлал төдийгүй шинжлэх ухааны өөр олон салбарт гамшгаас хамгаалах үйл ажиллагаатай холбоотой судалгаа, эрдэм шинжилгээний ажлууд хийгдэж магистр, докторын зэрэг хамгаалж, салбарын мэргэшсэн судлаачид төрөн гарч байна.



О.ҮРЖИН

Доктор Sc.D



П.ДАШ

Доктор Ph.D



Ц.АМГАЛАНБАЯР

Доктор Ph.D



П.ДАМДИН

Доктор Ph.D



П.БАТТОГТОХ

Доктор Ph.D



Б.БАЯРЖАРГАЛ

Доктор Ph.D



С.ХҮРЭЛСҮХ

Доктор Ph.D



П.ЦЭДЭВ

Доктор Ph.D



Х.МЯГМАРЖАВ

Доктор Ph.D



Г.ДАВААДОРЖ

Доктор Ph.D



Г.ЦАЦРАЛ

Доктор Ph.D



В.БАТСАЙХАН

Доктор Ph.D



Ц.ГАНЗОРИГ

Доктор Ph.D



Д.СЭРЖМЯДАГ

Доктор Ph.D



Ш.БОЛДБААТАР

Доктор Ph.D



Д.БАЗАРРАГЧАА

Доктор Ph.D



Н.БАТСАЙХАН

Доктор Ph.D



Ц.БЯМБАРАГЧАА

Доктор Ph.D



Д.АЛТАНГЭРЭЛ

Доктор Ph.D



Т.ӨСӨХЖАРГАЛ

Доктор Ph.D



Э.ОЮУНГЭРЭЛ

Доктор Ph.D



П.ЧИМЭДЦЭРЭН

Доктор Ph.D



Я.ЖАРГАЛСАЙХАН

Доктор Ph.D



Онцгой байдлын байгууллагын баг тамирчид Турк улсын Измир хотноо 2017 онд зохион байгуулагдсан Гал унтраах техникийн олон төрөлт спортын Дэлхийн аварга шалгаруулах 13 дахь удаагийн тэмцээнээс анхны хүрэл медалийг хүртэж, түүхэн амжилтын эзэд боллоо. Анхны хүрэл медалийг Гал унтраах техникийн олон төрөлт спортын байлдааны тархалтын төрөлд 27:08 секундын амжилтаар хүртсэн бөгөөд энэ нь Онцгой байдлын байгууллагын түүхэнд Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс хүртэж буй анхны медаль болсноороо онцлог юм.





МАРТАХ УЧИРГҮЙ

Нэгдсэн тогтолцоонд шилжиж, шинэ хөгжлийн аянд гарсан зам маань тэр бүр дардан байсангүй. Ард иргэдийнхээ амь насыг авран хамгаалж, аюул ослоос гэтэлгэсэн баяр бахдалын дунд мөр зэрэгцэн үүрэг гүйцэтгэсэн эрэлхэг дайчин нөхдөө эгнээсээ алдсан харуусал бас байв. Өргөсөн тангарагтаа үнэнчээр үлдэж, угтах аюулыг сөрж давшсан анд нөхдөө бид мартах учиргүй билээ.



Ой хээрийн түймрийг унтраахаар Онцгой байдлын байгууллагын алба хаагчдыг авч ниссэн МИ-8 нисдэг тэрэг осолдсон гэсэн мэдээ Онцгой байдлын байгууллага төдийгүй Монгол Улсыг тэр чигт нь цочроосон харууслын мэдээ байв.

Сэлэнгэ аймгийн Мандал суманд гарсан ой, хээрийн түймрийг унтраахаар 2007 оны 06 дугаар сарын 14-ний өглөө ОБЕГ-ын удирдах бүрэлдэхүүний 4, Аврах тусгай

ангийн 15 шүхэрчин гал сөнөөгч, онгоцны экипажийн 3, нийт 22 хүний бүрэлдэхүүнтэй хөөрсөн Хилийн цэргийн 8220 дугаартай МИ-8 нисдэг тэрэг Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутаг, Шар Товгор уулын энгэрт осолдсон байлаа. Тус нисдэг тэрэгтэй холбоо тасарснаас хойш нэг хоногийн дараа эрэн хайх ажиллагаа эхэлж, гурав хоногийн дараа "Тэнгэрийн улаач" компанийн онгоц ослын газрыг олж тогтоосон юм.



Ослын талаар УИХ-д танилцуулав

Энэ харамсалтай ослоор албан үүргээ гүйцэтгэж явсан ОБЕГ-ын Онцгой үеийн шуурхай удирдлагын газрын дарга комиссар Д.Батбаатар, Урьдчилан сэргийлэх хяналтын хэлтсийн дарга, дээд ахмад Д.Цэрэнням, тэргүүн дэслэгч С.Дашбазар, тэргүүн түрүүч Э.Ариунсанаа, тэргүүн түрүүч Ө.Дүүбаатар, дээд түрүүч Г.Лхагвасүрэн, тэргүүн түрүүч л.Баярмагнай, тэргүүн түрүүч Ё.Эрдэнэцогт, дээд түрүүч Ц.Ганболд, дээд түрүүч Ц.Болд, тэргүүн түрүүч Т.Оргилсайхан, тэргүүн түрүүч Л.Булган, нисэх багийн дарга, гавьяат нисгэгч, хурандаа Т.Сугар, хоёрдугаар нисгэгч, дэд хурандаа А.Наранбат бортмеханик хошууч ч.Гантөмөр нарын 15 алба хаагч амь насаа алдаж, шадар дэслэгч Д.Пүрэвдорж, дээд түрүүч Ж.Бадамжунай, дээд түрүүч С.Батдалай, тэргүүн түрүүч Г.Ганжигүүр, тэргүүн түрүүч Х.Сүхбаатар, шадар түрүүч П.Цогжаргал, "Аврагч" студийн зураглаач Т.Мөнхтөр нар ослоос эсэн мэнд үлдсэн юм.



Албан үүргээ гүйцэтгэж яваад амь үрэгдсэн анд нөхдийнхөө гэгээн дурсгалд зориулж Онцгой байдлын байгууллагын алба хаагчид өөрсдийн хандив санаачлагаар хурандаа генерал С.Равдангийн нэрэмжит Үндэсний аврах бригадад гэрэлт хөшөөг босгож, жилийн бүрийн зургадугаар сарын энэ өдрийг хүндэтгэл үзүүлэх ёслолын өдөр болгосон билээ.



Гэрэлт хөшөөг дэслэгч Г.Норовсамбуу, хошууч П.Амарсайхан, ахмад Д.Пүрэвдорж нар манлайлан Монголын урчуудын эвлэлийн шагналт зураач, уран барималч Г.Сэрээтэрийн удирдлаган дор барьсан юм.

Тэнгэрийн цээл рүү дүүлэн нисэх онгоцыг дүрсэлсэн гэрэлт хөшөөний нүүрэн талд төрийн алтан соёмбыг сийлж, "Албан үүргээ гүйцэтгэж яваад амь эрсэдсэн аврагч дайчдынхаа гэгээн дурсгалд зориулав. 2008.06.14" хэмээн бичсэн нь бий.

■ Аврагчдын гэгээн дурсгалд зориулсан хөшөөний нээлт





2012.05.06

Дорнод аймгийн Баяндун сумын нутаг, хилийн хоёрдугаар заставын хариуцсан 858-859 дүгээр тэмдэгтийн чиглэлд Шивэртийн ам гэдэг газарт гарсан түймрийг унтраахаар цурам тавин ажиллаж байсан алба хаагчид гэнэтийн хүчтэй галан хуйд өртөж амь насаа алдсан харамсалтай мэдээ орон даяар түгэв.

Энэ ослын үед Дорнод аймгийн Онцгой байдлын хэлтсийн Эрэн хайх, аврах салбарын бүлгийн дарга, онцгой байдлын дэслэгч Ч.Намжилдаш, ахлагч, аврагч усчин С.Бат-Эрдэнэ, ахлагч, эмнэлгийн зааварлагч Ж.Одбаяр нар газар дээрээ

амь эрсдэж, онцгой байдлын ахлах ахлагч, химичин аврагч Г.Багабиш дэд ахлагч, аврагч А.Болорсүхийг доороо оруулан нөмрөн хэвтсэнээр галаас амь гарсан ч 90 хувийн түлэгдэлтийн улмаас ахлах ахлагч Г.Багабиш эмчилгээний явцад амь насаа алдсан юм.

Хожим дэд ахлагч А.Болорсүх нэгэн ярилцлагадаа, "Багабиш ахаас яагаад Болорсүхийг хамгаалсан юм бэ гэхэд арай залуу нь амьд үлдэг гэж бодсон гэж хариулсан байна билээ" гэж дурссан байдаг.

Ийнхүү гал, усны гашуун зовлонгоос хүрээлэн буй орчин, ард иргэдийнхээ амь нас, эд хөрөнгийг авран хамгаалахаар яваад амь үрэгдсэн энх цагийн баатруудынхаа гэгээн дурсгалыг хүндэтгэж, үе үеийн аврагч, гал сөнөөгчдийг алдаршуулах, баатарлаг үйлсийг нь ард иргэддээ сурталчлах, шинэ үеийн залууст эх оронч үзлийг төлөвшүүлэх зорилгоор Дорнод аймгийн Онцгой байдлын газрын алба хаагч санаачлан тус аймгийн төв "Аврагчин гараас амьдрал цэцэглэнэ" хөшөөт цогцолборыг бүтээгээд байна.



Гал, ус, гамшиг, ослоос ард иргэдээ авран хамгаалах ариун тангарагтай Онцгой албаны эрэлхэг эгнээс энэ 15 жилийн хугацаанд 28 алба хаагч ажил үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан байна.


Эх орон, ард түмнийхээ халуун сэтгэлээс Энэ цагийн эгэл баатрууд хэмээх эрхэм алдрыг хүртэж, улс орныхоо өмнө тулгарсан гал, усны гашуун зовлонг сөрж, амар амгалан амьдралыг авчрахын тулд халуун амиа зориулсан эрэлхэг хөвгүүдээ бид мартаж учиргүй ээ.

Үг: Д.Батсайхан



Ая: Б.Батгэрэл

МАНАЙ ОНЦГОЙХОН



Аадар шаагиж аянга нүргэлэхэд
 Аюул зарлаж томилолт өгөхөд
 Аврал эрсэн эрсдэл бүхэнтэй
 Амь сөрөн тулах тангарагтай
 Газар хөдөлж гамшиг ирэхэд
 Галаар тургиж аймшиг нүүрлэхэд
 Үхлийг сөрөн амьдрал бэлэглэсэн
 Үйлс ариун цэрэг эрс ээ
 Эрэлхэг зоригт манай Онцгойхон
 Эгэл олныхоо итгэлт аврагчдаа
 Эгнээ жигдхэн манай Онцгойхон
 Энэ цагийн эрэлхэг дайчдаа
 Буу мөрлөж хилээ манаагүй ч
 Бусдын төлөө амиа хайрлахгүй
 Хатуухан тангаргийн эзэн болсон
 Хамаг монголын хайртай хөвгүүд
 Авсан тушаал нь амины үнэтэй
 Алдар гавьяа нь мөнхийн гэрэлтэй
 Санаа зорилго нь үргэлж өөдрөг
 Саруул Монголын Онцгой эрс ээ
 Эрэлхэг зоригт манай Онцгойхон
 Эгэл олныхоо итгэлт аврагчдаа
 Эгнээ жигдхэн манай Онцгойхон
 Энэ цагийн эрэлхэг дайчдаа

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

ГЭРЭЛ ЗУРАГ ТҮҮХ
ӨГҮҮЛНЭ






■ Гамшгаас хамгаалах байгууллагын удирдах ажилтны сургалт 2004 он

















■ Онцгой байдлын албаны удирдах ажилтны цугларалт 2006 он






























■ 2012 оны Үндэсний их баяр наадмын баярын жагсаал



■ Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын удирдах ажилтны цугларалт 2014 он


















■ Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын удирдах ажилтны цугларалт 2015 он


























































































































































































UNISDR



ASIAN MINISTERIAL CONFERENCE
ON DISASTER RISK REDUCTION

JULY 8-10, 2018
ULANBAATAR, MONGOLIA

АЮУЛГҮЙ Д



ЭЛХИЙН ТӨЛӨӨ ХАМТДАА



ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ
АЗИЙН САЙД НАРЫН БАГА ХУРАЛ
МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ
2018.07.03-06



ХАВСРАЛТ

1. Улсын Их Хурлын 2003 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар “Гамшгаас хамгаалах тухай” хуулийг батлав.
2. 2004 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар Гамшгаас хамгаалах ерөнхий газрыг байгуулах анхны шийдвэр гарчээ.
3. Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 2 дугаар тогтоолоор хошууч генерал П.Дашийг Гамшгаас хамгаалах ерөнхий газрын даргаар зургаан сарын хугацаатай түр томилсон байна.
4. Монгол Улсын Ерөнхий сайдын 2004 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн “Хөтөлбөр, бүтэц, удирдлагын орон тооны тухай” 8 тоот захирамжаар Гамшгаас хамгаалах ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын хөтөлбөр, бүтэц, удирдлагын орон тоог баталжээ.
5. Монгол Улсын Ерөнхий сайдын 2004 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн “Улсын албад байгуулах тухай” 13 дугаар захирамжаар гамшгаас хамгаалах 9 улсын албыг байгуулж, удирдлагыг томилов.
6. Монгол Улсын Ерөнхий сайдын 2004 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн “Дүрэм батлах тухай” 17 дугаар захирамжаар Гамшгаас хамгаалах ерөнхий газрын дүрмийг батлав.
7. Гамшгаас хамгаалах ерөнхий газрын даргын 2004 оны 17 дугаар тушаалаар ГХЕГ-ын дэргэд Ахмадын хороог байгуулахаар болов.
8. Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн “Комиссын ажиллах журам, бүрэлдэхүүн батлах тухай” 34 дүгээр тогтоолоор Гамшгаас хамгаалах тухай хуулийн 17, 23.2-т заасныг үндэслэн “Бий болсон цагийн байдалтай уялдуулан гамшгийн хор уршгийг арилгах, голомт тэлэхээс урьдчилан сэргийлэх, аврах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг зохицуулах, шуурхай зохион байгуулах үүрэг бүхий Гамшигтай тэмцэх комиссын ажиллах журмыг батлуулан мөрдөж эхлэв.
9. Гамшгаас хамгаалах ерөнхий газрын даргын 2004 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 78, 79 дүгээр тушаалаар тус газрын Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн дүрэм, зөвлөлийн бүрэлдэхүүнийг тус тус батлав.
10. Монгол Улсын Засгийн газрын урилгаар НҮБ-ын Гамшгийн үнэлгээ, зохицуулалтын баг 2004 оны 06 дугаар сарын 27-ноос 07 дугаар сарын 09-ний өдрүүдэд Монгол Улсад ирж ажиллан, Монгол Улсын гамшгийн бэлэн байдал, түүнтэй тэмцэх чадавхад үнэлгээ хийн 33 зүйлтэй зөвлөмж бүхий тайлан илтгэл бэлтгэж Монгол Улсын Засгийн газарт танилцуулав.
11. Гамшгаас хамгаалах ерөнхий газрын даргын 2004 оны А/260 дугаар тушаалаар ГХЕГ байгуулагдсанаас хойшхи анхны Гамшгаас хамгаалах команд штабын сургуулийг Баян-Өлгий аймагт 08 дугаар сарын 05-06 ны өдрүүдэд зохион байгуулав.
12. 2004 оны 09 дүгээр сард Сингапур Улсад зохион байгуулагдсан Олон улсын эрэн хайх, авран туслах зөвлөлдөх бүлгийн Ази, номхон далайн бүсийн хуралдаан, Хот дахь эрэн хайх, авран туслах бүлгийн хуралдаанд Гамшгаас хамгаалах ерөнхий газрын дарга, тэргүүн комиссар П.Даш, тэргүүн дэд дарга, хошууч генерал О.Үржин, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн Ш.Алтанчимэг нар оролцов.
13. Монгол Улсын Их Хурлын 2005 оны 01 дүгээр сарын 18-ны хуралдаанаар Гамшгаас хамгаалах тухай хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулав.
14. Гамшгаас хамгаалах ерөнхий газрын даргын урилгаар 2005 оны 03 дугаар сард Унгар улсын Гамшгаас хамгаалах ерөнхий газрын дарга, хошууч генерал Татар Аттила Монгол Улсад айлчиллаа.
15. 2005 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар бэлтгэл дэд хурандаа Т.Отгоныг “Үйлчилгээний гавьяат ажилтан” цолоор шагнав.
16. Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 48 дугаар тогтоолоор Гамшгаас хамгаалах ерөнхий газрын нэрийг Онцгой байдлын ерөнхий газар болгон өөрчилж, аймаг, нийслэл, дүүргийн Гамшгаас хамгаалах штабыг Онцгой байдлын хэлтэс гэж нэрлэхээр шийдвэрлэсэн байна.
17. Онцгой байдлын асуудал эрхэлсэн Монгол Улсын Сайдын 2005 оны 03 дугаар сарын 31-ний 36 дугаар тушаалаар Онцгой байдлын байгууллагын бэлгэ тэмдгийн тодорхойлолт, загвар хэрэглэх журмыг батлав.
18. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2005 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн “Тангараг өргөх ёслолын журам батлах тухай” 50 дугаар зарлигаар “Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын төрийн тусгай албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам”-ыг батлав.
19. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2005 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн “Цол олгох журам батлах тухай” 51 дүгээр зарлигаар “Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын төрийн тусгай алба хаагчийн

- цололгох журам"-ыг баталж, Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын төрийн тусгай албан тушаал эрхэлдэг албан хаагчийн албан тушаалын ангилал, цолны зэрэглэлийг энэхүү журамтай нийцүүлэн тогтоохыг Онцгой байдлын асуудал эрхэлсэн сайд /У.Хүрэлсүх/-д даалгав.
20. 2005 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр "Монгол Улсын Онцгой байдлын ерөнхий газар, АНУ-ын Аляскийн Үндэсний гвард хоорондын хамтын ажиллагааны зөвлөлдөх санамж бичиг"-ийг байгуулав.
 21. Онцгой байдлын асуудал эрхэлсэн Монгол Улсын Сайдын 2005 оны 04 дүгээр сарын 29-ний 60 дугаар тушаалаар "Ажлын тусгай хувцасны загвар" батлагдаж, эхний ээлжинд аврах ажиллагаанд оролцдог алба хаагчид ажлын тусгай хувцсаар хангагдаж байв.
 22. Онцгой байдлын асуудал эрхэлсэн Монгол Улсын сайдын 2005 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 63 тоот тушаалаар Сургалт, судалгаа, шинжилгээний төвүүдийг нэгтгэж "Гамшгаас хамгаалах сургалт, эрдэм шинжилгээний хүрээлэн"-г байгуулав.
 23. Онцгой байдлын асуудал эрхэлсэн Монгол Улсын Сайдын 2005 оны 05 дугаар сарын 06-ны 66 дугаар тушаалаар Онцгой байдлын байгууллагын тугны загвар батлагдав.
 24. Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн "Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай" 117 дугаар тогтоолоор Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5.2-т заасныг үндэслэн Онцгой байдлын албаны өдрийг 06 дугаар сарын 20 байхаар тогтоожээ.
 25. Онцгой байдлын албаны алба хаагчийн дүрэмт хувцасны загварыг анх Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2005 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн "Дүрэмт хувцасны загварыг батлах тухай" 130 дугаар зарлигаар баталжээ.
 26. Монгол Улсын сайдын 2005 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 92 дугаар тушаалаар мөн оны 06 дугаар сарын 20-ны өдөр Онцгой байдлын ерөнхий газар, Нийслэлийн Онцгой байдлын газар, Аврах тусгай анги, Хангалт үйлчилгээний анги Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын бэлгэ тэмдэг бүхий тугийг үнэмлэхийн хамт гардан авав.
 27. Монгол Улсын сайдын 2005 оны 06 дугаар сарын 15-ны 93 дугаар тушаалаар Онцгой байдлын ерөнхий газар, Нийслэлийн Онцгой байдлын газар, Аврах тусгай анги, Хангалт үйлчилгээний ангийн захирагч нарын тангараг өргөх ёслолын ажиллагааг 2005 оны 06 дугаар сарын 20-ны өдөр Д.Сүхбаатарын талбайд анх удаа зохион байгуулав.
 28. "Гамшгийн удирдлагын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Онцгой байдлын ерөнхий газар, БНСУ-ын Онцгой байдлын ерөнхий газар хоорондын хамтын ажиллагааны гэрээ"-нд 2005 оны 07 дугаар сарын 08-ны өдөр талууд гарын үсэг зурлаа.
 29. Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн "Комиссын бүрэлдэхүүн, журам батлах тухай" 183 дугаар тогтоолоор Гамшигтай тэмцэх комиссыг "Улсын онцгой комисс" болгон өөрчилжээ.
 30. Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2005 оны А/354 дүгээр тушаалаар ОБЕГ байгуулагдсанаас хойшхи анхны Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг 09 дүгээр сарын 14-17 ны өдрүүдэд Хөвсгөл аймагт зохион байгуулав.
 31. ОХУ-ын Эдийн засгийн хөгжлийн яамны Холбооны улсын нөөцийн газрын орлогч дарга тэргүүтэй төлөөлөгчид 2006 онд Монгол Улсад айлчлав.
 32. 2006 оны 03 дугаар сард Бүгд Найрамдах Унгар Улсын Гамшгаас хамгаалах ерөнхий газрын Галын лабораторийн дарга, ноён Сабо Аттила Монгол Улсад ажлын айлчлал хийв.
 33. 2006 онд Онцгой байдлын ерөнхий газар ОХУ-ын Иргэний хамгаалалт, онцгой байдал, байгалийн гамшгийн үр дагаврыг арилгах хэрэг эрхлэх яам /ОБЯ/-тай "Монгол Улсын Онцгой байдлын байгууллага, ОХУ-ын Иргэний хамгаалалт, онцгой байдал, байгалийн гамшгийн үр дагаврыг арилгах хэрэг эрхлэх яам хоорондын хамтын ажиллагааг идэвхжүүлэх протокол"-д гарын үсэг зурлаа.
 34. Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 193 дугаар тогтоолоор ОБЕГ-ын харьяа Аврах тусгай ангийг төр, нийгэм, цэргийн нэрт зүтгэлтэн, дипломатч, Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн, хурандаа генерал Сандивын Равдангийн нэрэмжит болгожээ.
 35. 2006 оны 09 дүгээр сарын 30-нд "Үйлдвэрийн осол, сүйрэл, байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, тэдгээрийн үр дагаврыг арилгах салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улс хоорондын хэлэлцээр"-ийг байгуулав.
 36. 2006 оны 09 дүгээр сарын 29-нөөс 10 дугаар сарын 01-ний өдрүүдэд Бүгд Найрамдах Солонгос Улсын Онцгой байдлын ерөнхий газрын дарга Муун Вон Кёнг тэргүүтэй төлөөлөгчид Онцгой байдлын ерөнхий газрын дарга, тэргүүн комиссар П.Дашийн урилгаар Монгол Улсад албан ёсны айлчлал хийж, Онцгой байдлын менежментийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын ОБЕГ, БНСУ-ын ОБЕГ-ын хоорондын харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг төслөөр зурсан.
 37. 2006 оны 10 дугаар сарын 11-14-ний өдрүүдэд ОХУ-ын Иргэний хамгаалалт, онцгой байдал, байгалийн гамшгийн үр дагаврыг арилгах хэрэг эрхлэх яамны Бүгд Найрамдах Тува Улс дахь ерөнхий газрын дарга, хурандаа Байыр-оол Эрес-оол Донгакович тэргүүтэй

- төлөөлөгчид Улаанбаатар хотноо ажлын айлчлал хийв.
38. ОБЕГ-ын даргын 2006 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 546 тоот тушаалаар Гамшгаас хамгаалах сургалт, эрдэм шинжилгээний хүрээлэнг Онцгой байдлын албаны эрдэм шинжилгээний хүрээлэн болгон өөрчлөв.
 39. 2006 оны 11 дүгээр сарын 23-24-ний өдрүүдэд Швейцарийн Холбооны Улсын Женев хотод зохион байгуулагдсан “Олон улсын иргэний хамгаалалтын байгууллагын ерөнхий ассамблейн 17 дугаар чуулган”-д ОБЕГ-ын дарга, тэргүүн комиссар П.Даш тэргүүтэй төлөөлөгчид оролцов.
 40. Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаярын 2006 оны 12 дугаар сарын 04-10-ны өдрүүдэд Оросын Холбооны Улсад хийсэн төрийн айлчлалын бүрэлдэхүүнд Онцгой байдлын асуудал эрхэлсэн сайд С.Отгонбаяр орж, ОХУ-ын Иргэний хамгаалалт, онцгой байдал, байгалийн гамшгийн үр дагаврыг арилгах хэрэг эрхлэх сайд С.К.Шойгутай уулзан, Монгол Улсын Онцгой байдлын байгууллага, ОХУ-ын Иргэний хамгаалалт, онцгой байдал, байгалийн гамшгийн үр дагаврыг арилгах асуудал эрхэлсэн яам хоорондын хамтын ажиллагааг идэвхижүүлэх протколд гарын үсэг зурсан.
 41. Монгол Улсын сайдын 2007 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 33 дугаар тушаалаар Онцгой байдлын ерөнхий газрын бүтцэд өөрчлөлт орсноор Мэргэжлийн удирдлагын газар нь Онцгой үеийн удирдлагын газар нэртэйгээр Шуурхай удирдлага, зохицуулалтын төв, Холбоо мэдээллийн хэлтэс, Шуурхай бүлэг-105, Оператив жижүүртэй, Олон нийттэй харилцах, Хүн амын Эрүүл мэндийг хамгаалах, Дэд бүтэц, техник, технологиос үүдсэн гамшигтай тэмцэх, Байгаль экологи, хөдөө аж ахуйн гаралтай гамшигтай тэмцэх, Гал түймэртэй тэмцэх хэлтэс, албадтай болсон байна.
 42. Монгол Улсын Онцгой байдлын асуудал эрхэлсэн сайдын 2007 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 40, 41 дүгээр тушаал, “Ажлын тусгай хувцасны загвар батлах тухай” 60 дугаар тушаалаар ажлын тусгай хувцасны загвар, эдэлгээний хугацааг тогтоож, ажлын хувцас, хэрэглэлийн загвар, эдэлгээний хугацаа, техникийн шаардлага, өнгө, материалын ялгаа, өмсөх дүрмийг шинэчлэн батлав.
 43. 2007 оны 04 дүгээр сард Дархан-Уул аймгийн Хонгор сумын төвд алтны агууламжтай хүдэр, шламнаас мөнгөн ус, натрийн цианид зэрэг химийн бодис ашиглан алт ялгах үйл ажиллагааг хууль бусаар явуулж, химийн бодисоор бохирдсон хаягдал усыг ил задгай асгаж байсны улмаас үүссэн хор уршгийг арилгах үйл ажиллагааг зохион байгуулав.
 44. 2007 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Онцгой байдлын байгууллагын Улсын нөөцийн газрын ахмад ажилтан Г.Нэргүйг “Гавьяат агрономич” цолоор шагнав.
 45. Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн “Дүрэмт хувцасны эдэлгээний хугацаа батлах тухай” 123 дугаар тогтоолоор Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын тусгай албан тушаал эрхэлдэг алба хаагчийн дүрэмт хувцасны эдэлгээний хугацааг тогтоож өгсөн байна.
 46. 2007 оны 06 дугаар сарын 14-ний өглөө ОБЕГ-ын удирдах бүрэлдэхүүний 4, Аврах тусгай ангийн 15 шүхэрчин гал сөнөөгч, онгоцны экипажийн 3, нийт 22 хүний бүрэлдэхүүнтэй хөөрсөн Хилийн цэргийн 8220 дугаартай МИ-8 нисдэг тэрэг Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутаг, Шар Товгор уулын энгэрт осолдов.
 47. Улсын Их Хурлын 2007 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаар Улсын нөөцийн тухай хуулийг хэлэлцэн батлав.
 48. Монгол Улс анх удаа Эрэн хайх, аврах олон улсын зөвлөлдөх бүлэгтэй /INSARAG/ хамтран “Газар хөдлөлтийн үед хотын дотор эрэн хайх, аврах ажиллагаа”-ны дадлага сургуулийг Улаанбаатар хотноо 07 дугаар сарын 31-нээс 08 дугаар сарын 02-ны хооронд зохион байгуулав. Уг сургуульд 13 улс, олон улсын 8 байгууллагын 76 төлөөлөгч оролцов.
 49. Иргэдэд гамшгаас хамгаалах үйлчилгээг түргэн шуурхай хүргэх зорилгоор “Шуурхай бүлэг 105”-ыг байгуулан 2006 оны 11 дүгээр сарын 18-ны өдрөөс үйл ажиллагааг эхлүүлэв.
 50. “Монгол Улсын Онцгой байдлын ерөнхий газар болон Франц Улсын Иргэний аюулгүй байдлын удирдах газар хоорондын санамж бичиг”-ийг 2007 оны 08 дугаар сарын 14-нд байгуулав.
 51. ОХУ-ын Эдийн засгийн хөгжлийн яамны Холбооны улсын нөөцийн газрын орлогч дарга А.Е.Земсков тэргүүтэй төлөөлөгчдийн 2007 оны 09 дүгээр сарын 26-28-ны өдрүүдэд Монгол Улсад хийсэн ажлын айлчлалыг амжилттай зохион байгуулсны үр дүнд хоёр байгууллага улсын нөөцийн чиглэлээр хамтран ажиллах, боловсон хүчин сургах талаар тохиролцсон.
 52. Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар Ц.Амгаланбаярыг Онцгой байдлын ерөнхий газрын даргаар томилов.
 53. Нийслэлийн Багануур дүүрэгт 2007 оны 12 дугаар сарын 30-ны өдрөөс 2008 оны 01 дүгээр сарын 01-нийг хүртэлх хугацаанд 32 хүн метилийн спиртэд хордож 15 хүн нас барсан.
 54. Монгол Улсын Шадар сайдын 2008 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 03 дугаар тушаал, 05 дугаар сарын 16-ны өдрийн 56 дугаар тушаалаар Онцгой байдлын ерөнхий газрын бүтцийг шинэчлэн баталсанаар Онцгой үеийн удирдлагын газар нь Гамшигтай тэмцэх газар, Гал түймэртэй тэмцэх газар гэж хуваагдан өөр өөрийн хуулийг хэрэгжүүлэхээр

- зохион байгуулагджээ.
55. 2008 оны 03 дугаар сарын 30-наас 04 дүгээр сарын 03-ны өдрүүдэд Онцгой байдлын ерөнхий газрын дарга, тэргүүн комиссар Ц.Амгаланбаяр тэргүүтэй төлөөлөгчид, ОХУ-ын Эдийн засгийн хөгжлийн яамны Холбооны улсын нөөцийн газрын дарга А.А.Григорьевийн урилгаар Москва хотноо ажлын айлчлал хийв.
 56. 2008 оны 04 дүгээр сарын 25-нд ОХУ-ын Иргэний хамгаалалт, онцгой байдал, байгалийн гамшгийн үр дагаврыг арилгах хэрэг эрхлэх сайд С.К.Шойгу, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, тэргүүн комиссар Ц.Амгаланбаярын нэр дээр албан захидал ирүүлж, Монгол Улсын Онцгой байдлын байгууллагын ажилтан, алба хаагчдаас жил бүр 4 хүртэлх хүнийг ОХУ-ын Онц байдлын яамны Улсын Гал эсэргүүцэх албаны академид, 3 хүртэлх алба хаагчийг Иргэний хамгаалалтын академид тус бүр үнэ төлбөргүй сургах болсон тухай мэдэгдсэн.
 57. 2008 онд Бүгд Найрамдах Унгар Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар 39,4 сая форинтын өртөг бүхий галын шинжилгээний лабораторийг Онцгой байдлын ерөнхий газарт хүлээлгэн өгсөн.
 58. Монгол Улсын Засгийн Газрын 2008 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 156 тоот тогтоолоор Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Онцгой байдлын албаны эрдэм шинжилгээний хүрээлэнг Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Гамшиг судлалын хүрээлэн болгон өргөтгөн зохион байгуулав.
 59. Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 04 дүгээр сарын 30-ны 157 дугаар тогтоолоор Орхон аймгийн Онцгой байдлын газрын Гал унтраах 81 дүгээр ангийг байгуулав.
 60. 2008 оны 05 дугаар сарын 26, 27-ны өдөр сүүлийн 20 жилд ажиглагдаагүй онц хүчтэй цасан болон шороон шуурга болж Дорнод, Дорноговь, Говьсүмбэр, Сүхбаатар, Төв, Хэнтий аймгийн нутгаар 28-34 м/с, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан суманд 40 м/с хүртэл салхилсан. Цаг агаарын гамшигт үзэгдлийн улмаас 254 хүн төөрч сураггүй болсноос 202 хүнийг эсэн мэнд олж, 52 хүн (үүнээс 14 хүүхэд) нас барж, 362195 толгой мал хорогдон, 110 барилга байгууламжид гэмтэл учирч, 221 гэр нурж, цахилгаан дамжуулах агаарын шугамын 62 тулгуур багана, холбооны 668 тулгуур багана унаж, 758.7 сая төгрөгийн хохирол учрав.
 61. Гамшиг судлалын хүрээлэн нь 2008 оны 06 дугаар сарын 16-нд БСШУЯ-наас Улсын бүртгэлийн гэрчилгээ авснаар Төрийн өмчийн 35 дахь эрдэм шинжилгээний хүрээлэн боллоо.
 62. Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 571 дүгээр тушаалаар НОБГ-ын Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гал унтраах 29 дүгээр анги, Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газрын Гал унтраах 40 дүгээр анги, Хэнтий аймгийн Онцгой байдлын газрын Гал унтраах 49 дүгээр анги байгуулагдсан.
 63. МИ-8 нисдэг тэрэгний ослоор амь үрэгдсэн дайчин нөхдийнхөө гэгээн дурсгалд зориулж, 2008 онд Онцгой байдлын албаны алба хаагчид өөрсдийн хандив санаачилгаар Аврах тусгай ангийн байрлалд Дурсгалын гэрэлт хөшөөг босгов.
 64. Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 322 дугаар тогтоолоор Дорноговь аймгийн Онцгой байдлын хэлтсийн Гал унтраах 17 дугаар анги, Гал унтраах 23 дугаар анги, НОБГ-ын Баянзүрх дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гал унтраах 35 дугаар ангийг тус тус байгуулсан.
 65. 2009 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр Онцгой байдлын албаны 58 айлын орон сууцны түлхүүрийг алба хаагчдад гардуулах ажиллагаа Аврах тусгай ангийн байрлалд болов.
 66. Монгол Улсын Шадар сайдын 2009 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 08 дугаар тушаалаар Онцгой байдлын байгууллага “Аврагч” спорт хороотой болов.
 67. Онцгой байдлын ерөнхий газар Америкийн Нэгдсэн Улсын Гамшгийн удирдлага, хүмүүнлэгийн тусламжийн сургалтын төвтэй хамтран “Говийн чоно-01” олон улсын сургалтыг анх удаа 2009 оны 03 дугаар сарын 30-ны өдрөөс 04 дүгээр сарын 10-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулав.
 68. 2009 оны 07 дугаар сарын 30-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Онцгой байдлын ерөнхий газрын үйл ажиллагаатай танилцаж, нийслэл хотод болсон үерийн гамшгаас олон хүний амь нас, эд хөрөнгийг авран хамгаалсан аврагчдыг хүлээн авч уулзан, төрийн дээд, одон медиалаар шагнаж урамшуулав.
 69. 2009-2010 оны өвөл тохиолдсон зудын гамшигт 18 аймгийн 175 сум (нийт нутаг дэвсгэрийн 80.9 хувь)-ын, 97.5 мянган малчин өрх нэрвэгдэж, 9.7 сая мал хорогдож, 526.0 тэрбум төгрөгийн хохирол учирсан ба хамарсан хүрээ, орсон хур тунадас, цасны хэмжээ, хүйтний эрч, малын хорогдлын хэмжээгээрээ манай улсын түүхэнд 1944-1945 онд тохиолдож байсан зудын аюулаас илүү их хэмжээний хохирол учруулсан байдаг.
 70. 2010 онд Монгол Улсын Засгийн газар, Онцгой байдлын ерөнхий газраас зудын гамшигт өртсөн малчдад туслах зорилгоор донор орнууд, олон улсын байгууллагууд, хандивлагчдын уулзалтыг Кемпински зочид буудалд зохион байгуулав.
 71. 2010 онд Монгол Улсын Засгийн газраас зудын гамшигт өртсөн малчдадаа туслах “Малчин түмэндээ туслацгаая” аяныг нийт ард иргэдийн дунд зохион байгуулж, эм тариа, хүнс, хүнсний бүтээгдэхүүн, дулаан хувцас, өвс тэжээлийн цувааг орон нутагт хүргэв.

72. 2010 онд Монгол, Аляскийн мэргэжилтнүүдийн туршлага судлах уулзалтыг зохион байгуулав.
73. “Хил орчмын ой, хээрийн түймэртэй тэмцэх талаар хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг хэрэгжүүлэх нарийвчилсан журмыг 2010 оны 10 дугаар сарын 14-ний өдөр баталлаа.
74. Үйлдвэрийн осол, байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, тэдгээрийн үр дагаврыг арилгах салбарт хамтран ажиллах Монгол-Оросын хамтарсан комиссын XI хуралдааныг 2011 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр Улаанбаатар хотноо зохион байгуулав.
75. Улсын Их Хурлын 2011 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 22 дугаар тогтоолоор “Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого”, “Гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг тус тус батлав.
76. 2011 онд Япон улсад хүчтэй газар хөдлөлт, түүнээс үүдэлтэй цунамид нэрвэгдэгсдэд туслах сайн санааны хандивын аянг Монгол Улсын Засгийн газар, Улсын Онцгой комисс, Онцгой байдлын ерөнхий газраас шуурхай зохион байгуулж, Монгол Улсын Засгийн газар, ард иргэдээс 2 сая ам.долларыг Японы ард түмэнд дэмжлэг тусламж болгон илгээлээ.
77. 2011 онд Онцгой байдлын албаны аврагчид анх удаа гадаад улсад гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэв. Япон Улсад болсон гамшгийн дараах хор уршгийг арилгах, сэргээн босгох, нэрвэгдэгсдийг эрэн хайх, аврах ажиллагаанд тус албаны 12 аврагч оролцож, үүргээ амжилттай биелүүлээд ирлээ.
78. Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тушаалаар “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”, 340 дүгээр тушаалаар “Гамшгийн үеийн дайчилгаа, нүүлгэн шилжүүлэх журам”-ыг батлав.
79. Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 152 дугаар тогтоолоор Ховд аймгийн Онцгой байдлын газрын Гал унтраах 38 дугаар ангийг байгуулав.
80. Хөвсгөл аймгийн Мөрөн суманд үйл ажиллагаа явуулдаг “НИК” ХХК-ийн салбарын нийт 13250 литр шатахуун ачиж явсан шатахуун тээвэрлэгч 2 автомашин Хөвсгөл нуурын мөсөн дээгүүр зорчиж яваад 2011 оны 02 дугаар сарын 08-ны өдөр Рэнчинлхүмбэ сумын дөрөвдүгээр багийн “Адуутын-Ам” гэдэг газар мөс цөмөрсний улмаас живсэн. Тус аймгийн Онцгой байдлын хэлтэс, Аврах тусгай ангийн аврагчид 8 хоног ажиллан Монгол Улсад анх удаа 50 метрийн гүний шумбалт хийн осолдсон хүн болон живсэн автомашиныг нуураас татан гаргав.
81. 2011 оны 02 дугаар сарын 24-ний өдөр “Онцгой байдлаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Онцгой байдлын ерөнхий газар, Бүгд Найрамдах Киргиз Улсын Онцгой байдлын яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”-т талууд гарын үсэг зурлаа.
82. Монгол Улсын Шадар сайдын 2011 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн “Ажлын тусгай хувцас, хэрэглэлийн нэр, төрөл, эдэлгээний хугацаа батлах тухай” 62 тоот тушаал гарснаар Монгол Улсын Онцгой байдлын асуудал эрхэлсэн сайдын 2005 оны 60, 2007 оны 41 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болгосон байна.
83. Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 95 дугаар тогтоолоор “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах үйл ажиллагааг улсын хэмжээнд уялдуулан зохицуулж нэгдсэн удирдлагаар хангах” үүрэг бүхий Байнгын ажиллагаатай орон тооны бус зөвлөлийг байгуулав.
84. Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 339 дүгээр тогтоолоор “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”, 340 дүгээр тогтоолоор “Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах журам”-ыг тус тус батлууллаа.
85. Монгол Улсын Их Хурлаас 2011 оны 12 дугаар сарын 09-ний өдөр Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулав. Энэ өөрчлөлтөөр хуулийн 32.2-т Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын тусгай алба хаагч нь, ахлагч нь онцгой байдлын дэд ахлагч, ахлагч, ахлах ахлагч, офицер нь онцгой байдлын дэслэгч, ахлах дэслэгч, ахмад, хошууч, дэд хурандаа, хурандаа гэсэн цолтой байна. Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын удирдах албан тушаалтанд цэргийн дээд цол олгож болно гэж заасан байна.
86. Гамшгаас хамгаалах тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтийг үндэслэн Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2012 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 06 дугаар тушаалаар өмнө хэрэглэж байсан /шадар ахмад, шадар дэслэгч гэх мэт/ цолыг хуулийн 32.2-т заасны дагуу алба хаагчдад олгов.
87. Монгол Улсын Шадар сайд, Хууль зүй Дотоод хэргийн сайдын 2012 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 19/А/39 дүгээр тушаалаар Хууль сахиулахын их сургуулийн дэргэд Онцгой байдлын сургуулийг байгуулав.
88. Монгол Улсын Шадар сайдын 2012 оны 04 дүгээр тушаалаар Онцгой байдлын ерөнхий газрын бүтцийг шинэчлэн баталсанаар Гамшигтай тэмцэх газар нь Гамшгаас хамгаалах газар болж өөрчлөгдөв.
89. 2012 оны 05 дугаар сарын 06-ны өдөр Дорнод аймгийн Баяндун сумын нутаг, хилийн хоёрдугаар заставын хариуцсан 858-859 дүгээр тэмдэгтийн чиглэлд Шивэртийн ам гэдэг газарт гарсан хээрийн түймрийг унтраахаар цурам тавин ажиллаж байсан

- алба хаагчид гэнэтийн хүчтэй галан хуйд өртөж Дорнод аймгийн Онцгой байдлын хэлтсийн Эрэн хайх, аврах салбарын бүлгийн дарга, онцгой байдлын дэслэгч Ч.Намжилдаш, ахлагч, аврагч усчин С.Бат-Эрдэнэ, ахлагч, эмнэлгийн зааварлагч Ж.Одбаяр, ахлах ахлагч Г.Багабиш нарын дөрвөн алба хаагч харамсалтайгаар амь насаа алдав.
90. Онцгой байдлын байгууллагын алба хаагчид НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагаанд анх 2012 оноос үүрэг гүйцэтгэж эхэлсэн юм. Анхны 28 алба хаагч 2012 оны 08 дугаар сарын 27-нд энхийг сахиулахаар эх орноосоо мордож байв. Өнөөдрийн байдлаар нийт 230 гаруй алба хаагч Бүгд Найрамдах Өмнөд Судан улсад явагдаж буй НҮБ-ын мандаттай Энхийг сахиулах ажиллагаанд оролцоод байна. Энэ онд VIII ээлжинд Онцгой байдлын байгууллагын 26 алба хаагч үүрэг гүйцэтгэж байна.
91. Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 250 дугаар тогтоолоор Хэнтий аймгийн Онцгой байдлын газрын Гал унтраах 42 дугаар анги, Өмнөговь аймгийн Онцгой байдлын газрын Гал унтраах 44 дүгээр анги, Хөвсгөл аймгийн Онцгой байдлын газрын Гал унтраах 46 дугаар анги, Сүхбаатар аймгийн Онцгой байдлын газрын Гал унтраах 47 дүгээр анги, Дорнод аймгийн Онцгой байдлын газрын Гал унтраах 53 дугаар анги, Завхан аймгийн Онцгой байдлын газрын Гал унтраах 57 дугаар ангийг тус тус байгуулав.
92. Засгийн газрын 2012 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 79 дүгээр тогтоолоор Т.Дуламдоржийг Онцгой байдлын ерөнхий газрын даргаар томилов.
93. Онцгой байдлын ерөнхий газар, Азийн гамшгийн бэлэн байдлын төвтэй хамтран Улаанбаатар хотноо 2013 оны 03 дугаар сарын 25-27-ны өдрүүдэд “Гамшгийн удирдлагын бүсийн зөвлөлдөх хорооны 10 дугаар хуралдаан”-ыг зохион байгууллаа.
94. Хуралдаанд 19 улс орон, олон улсын байгууллагын төлөөлөгчид, Монгол Улсын Шадар сайд, Онцгой байдлын ерөнхий газар, нийслэл, аймаг орон нутгийн удирдлага болон яамд, агентлаг, төрийн бус байгууллагын 130 гаруй зочид, төлөөлөгч оролцсон.
95. Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2013 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн А/304 тушаалаар Гамшгийн шуурхай удирдлагын газрын бүтцэд Гамшгийн шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төвийг байгуулж, нийт 20 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж эхлэв.
96. Ахмад үеийнхнийхээ туршлага, мэдлэгийг залуу хойч үедээ өвлүүлэх, харилцан туршлага судлах зорилгоор Онцгой байдлын байгууллагаас “Гурван үеийн чуулга уулзалтыг” 2013 оноос эхлэн гурван жилд нэг удаа зохион байгуулан ажиллаж байна.
97. Гамшгаас урьдчилан сэргийлэх мэдлэг, боловсролыг иргэдэд олгох, гамшгийн эрсдэлийг бууруулах, сэрэмжлүүлэг мэдээ мэдээллийг шуурхай хүргэх зорилгоор 2013 онд НҮБХХ-ийн “Монгол Улсад гамшгийн аюулыг бууруулах менежментийн тогтолцоог боловсронгуй болгох нь” төслийн санхүүжилтээр Онцгой байдлын ерөнхий дэргэд “Аврагч” студийг байгууллаа.
98. Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн нэрэмжит Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн цэргийн байгууллагуудын дунд хоёр жил тутамд зохион байгуулагддаг “Марш, тусгай бэлтгэлийн цогцолбор тэмцээн”-д Онцгой байдлын байгууллагын алба хаагчид 2013 онд мөнгөн медаль хүртсэн бол 2017 онд Тусгай байрыг эзэллээ.
99. Онцгой байдлын байгууллагын 10 жилийн ойн хүрээнд албаны үйл ажиллагаа, алба хаагчдын ажил, мэргэжлийн онцлогийг олон нийтэд таниулан сурталчлах зорилгоор Онцгой байдлын ерөнхий газар, Монголын үндэсний олон нийтийн радио телевизтэй хамтран “Нарны жим” 50 ангит уран сайхны киног бүтээж, 2014 оны 06 дүгээр сарын 02-ны өдөр үзэгчдийн хүртээл болголоо.
100. Онцгой байдлын албаны тулгын чулуу болсон Улсын Иргэний хамгаалалтын байгууллагад олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж байсан доктор, профессор бэлтгэл хурандаа П. Дамдинг 2014 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар “Үйлчилгээний гавьяат ажилтан” цолоор шагнав.
101. Архангай аймгийн Хашаат сумын Номгон багийн нутаг “Хөөвөр” гэдэг газар 2014 оны 07 дугаар сарын 26-ны өдөр 10 км орчим зурвас газарт 8 см-ийн голчтой мөндөр орж, хүчтэй хар салхи үүссэний улмаас 1 хүн нас барж, 9 хүн гэмтэж бэртэн, 3 байшин, 5 гэр, 200 толгой мал, 3 автомашин тус тус өртөв.
102. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2014 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн “Дүрэмт хувцасны загвар батлах тухай” 111 дүгээр зарлигаар Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын дүрэмт хувцасны загварыг шинэчлэн батлав.
103. Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 325 дугаар тогтоолоор нийслэлийн Налайх дүүрэгт байрлах Уул уурхайн яамны харьяа Уул уурхайн аврах албыг Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Аврах тусгай ангитай нэгтгэв.
104. Засгийн газрын 2015 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 6 тоот тогтоолоор Т.Бадралыг Онцгой байдлын ерөнхий газрын даргаар томилов.
105. Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2015 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн Б/20 дугаар тушаалаар тус газрын бүтэц, орон тоог шинэчлэн баталж, Онцгой байдлын ерөнхий газрын бүтцэд Гамшгаас урьдчилан сэргийлэх газрыг байгуулав.
106. ОБЕГ-ын харьяа Гамшиг судлалын хүрээлэнгийн бүтцийг ОБЕГ-ын 2015 оны 01 дүгээр сарын 16-ны

- өдрийн Б/46 тоот тушаалаар шинэчлэн “Эрдэм шинжилгээ, инноваци хариуцсан нэгж”-ийг байгууллаа.
107. Монгол Улсын Шадар Сайдын 2015 оны 04 дүгээр тушаалаар Онцгой байдлын ерөнхий газрын бүтцийг шинэчлэн баталсанаар Гамшгаас хамгаалах газар нь Гамшгийн шуурхай удирдлагын газар нэртэй болов.
108. Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 80 дугаар тогтоолоор Уул уурхайн аврах албыг Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Уул уурхайн аврах анги болгон өргөтгөлөө.
109. Монгол цэргийн өдрийг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар 2015 оны 03 дугаар сарын 18-нд ОБЕГ-ын дарга Т.Бадрал “Бригадын генерал” цол хүртэж, Онцгой байдлын байгууллагаас төрсөн анхны цэргийн дээд цолтон боллоо.
110. Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 07 дугаар сарын 02-ны өдөр “Галын аюулгүй байдлын тухай хууль”-ийг шинэчлэн батлав.
111. Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын нутаг дэвсгэр Алтай таван богд уулын “Хүйтэн”-ий оргилд авиралт хийж байгаад осолдсон 5 иргэнийг эрэн хайх ажиллагааг 2015 оны 7 дугаар сарын 13-16-ны өдрүүдэд зохион байгуулав.
112. Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 303 тоот тогтоолоор “Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр”-ийг батлуулав.
113. Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 274 дүгээр тогтоолоор Увс аймгийн Онцгой байдлын газрын Гал унтраах 60 дугаар ангийг байгуулсан.
114. Гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний төлөвлөгөөг Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 416 дугаар тогтоолоор батлуулсанаар Монгол Улс Гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй болов.
115. Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 80 дугаар тогтоолоор аймгуудын Онцгой байдлын хэлтсүүдийг Онцгой байдлын газар болгон бүтэц, орон тоог шинэчлэн батлав.
116. Монгол Улсын Их Хурлын 2015 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 85 дугаар тогтоолоор “Монгол Улсын Батлан хамгаалахын бодлогын үндэс”-ийг баталж, 7.1-т “Монгол Улсын төрийн цэргийн байгуулал нь тайван цагт зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллагаас бүрдэнэ, 7.4-т Зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллага нь цэргийн нийтлэг дүрмүүдийг даган мөрдөж, цэргийн алба хаагчийн эрх зүйн хэм хэмжээгээр олгогдсон эрх, үүргийг хэрэгжүүлнэ” гэж зааснаар Онцгой байдлын байгууллага төрийн цэргийн бүрэлдэхүүнд албан ёсоор багтлаа.
117. Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 303 дугаар тогтоолоор “Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр”-ийг батлав.
118. Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 479 дүгээр тогтоолоор Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа Сэргээн засах, сувиллын цогцолборын Сувиллын хэсгийг Онцгой байдлын ерөнхий газарт балансаас балансад шилжүүллээ.
119. Онцгой байдлын ерөнхий газар, Монголын Улаан загалмайн нийгэмлэг нь “Төр-Улаан загалмайн хамтын ажиллагааны чиглэл”-ээр 2015 онд хамтран ажиллах санамж бичиг байгуулж, санамж бичгийг 2015-2020 оны хооронд 5 жилийн турш хэрэгжүүлэхээр хоёр тал баталгаажуулав.
120. 2015 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Аврах тусгай ангийн бэлтгэл офицер, ахмад С.Баавгайг “Үйлчилгээний гавьяат ажилтан” цолоор шагнав.
121. Галын аюулгүй байдлын тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 48 дугаар тогтоолоор “Гал түймрийн хяналтын дүрэм”-ийг батлуулав.
122. Монгол Улсад ГЕНЕРАЛ цол бий болсны түүхт 72 жилийн ойн хүндэтгэлийн арга хэмжээг Онцгой байдлын ерөнхий газраас 2016 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулав. Зэвсэгт хүчин, Цагдаа, Онцгой байдал, Тагнуул, Хилийн цэрэг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудаас төрөн гарсан 80 орчим генералд хүндэтгэл үзүүллээ.
123. Монгол Улсын Шадар сайдын 2016 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 52 дугаар тушаалаар “Гамшгаас хамгаалах улсын албаны ажиллах нийтлэг журам”-ыг батлав.
124. 2016 оны 05 дугаар сарын 12-нд “Монгол Улсын Онцгой байдлын ерөнхий газар, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсын Онцгой байдал, гамшгийн удирдлагын хороо хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг байгуулав.
125. Засгийн газрын 2016 оны 66 дугаар тогтоолоор Онцгой байдлын байгууллагын салбар нэгжийг баруун, зүүн, өмнөд, хойд, Улаанбаатар гэсэн таван бүсэд хувааж гамшгаас хамгаалах удирдлага, зохицуулалтыг бүсчилсэн хэлбэрт шилжүүллээ.
126. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 183 дугаар тогтоолоор Дорнод аймгийн Онцгой байдлын газрын Гал унтраах, аврах 62 дугаар анги, Сүхбаатар аймгийн Онцгой байдлын газрын Түмэнцогт сум дахь Эрэн хайх, аврах бүлэг, Өмнөговь аймгийн Онцгой байдлын газрын Гал унтраах, аврах 66

- дугаар анги, Гал унтраах, аврах 67 дугаар ангийг тус тус байгууллаа.
127. “Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр”-ийн хүрээнд 2016 онд Онцгой байдлын албаны ажилтан, алба хаагчдын 72 айлын анхны орон сууцыг ашиглалтад оруулсан бол, нийслэлийн Баянзүрх дүүргийн 8 дугаар хороонд 300 айлын орон сууцны шавыг тавилаа.
128. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 282 дугаар тогтоолд ОБЕГ-ын харьяа Нохойн алба байгуулах тухай заалт оров.
129. Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсаны дагуу “Аюулгүй, амгалан Улаанбаатар” зорилтын хүрээнд 2014-2015 оны нийслэлийн хөрөнгө оруулалтаар “Нийслэлийн иргэдийг гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төв”-ийг байгуулж, 2016 оны 06 дугаар сарын 20-ны өдөр нээлтийг хийлээ.
130. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 339 дүгээр тогтоолоор “Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм”-ийг батлууллаа.
131. 2016 оны 06 дугаар сарын 20 буюу Онцгой байдлын байгууллагын 13 жилийн ойн өдрөөр “Албаны түүхэн музей” нээлтээ хийв.
132. Анх 1965 онд Сайд нарын Зөвлөлийн 244 дүгээр тогтоолоор хуучнаар Худалдаа бэлтгэлийн яамны харьяа бөөний бараа баазыг түшиглэн байгуулагдаж байсан Улсын нөөцийн газрын түүхт 50 жилийн ой 2016 оны 06 дугаар сарын 25-нд тохиов.
133. Монгол Улсын Шадар Сайдын 2016 оны 12 дугаар сарын 28-ны 134 дүгээр тушаалаар “Онцгой байдлын албаны хүний нөөцийн бодлого заавар”-ыг батлууллаа.
134. Засгийн газрын 2016 оны 66 дугаар тогтоолоор Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Давтан сургалт, сэргээн заслын төвийг байгуулав.
135. 2016 онд Монгол Улсын Засгийн газар, Австри Улсын Засгийн газар хоорондын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд “Онцгой байдлын албаны гал унтраах техник, тоног төхөөрөмжийн хүчин чадлыг сайжруулах төсөл”-өөр 5 сая евро буюу 15 тэрбум төгрөгийн Гал түймэр унтраах, аврах зориулалтын 5 төрлийн 16 автомашиныг нийлүүлэв.
136. Онцгой байдлын ерөнхий газраас “Гамшгаас хамгаалах тухай хууль”-ийг шинэчлэн боловсруулж, УИХ-ын 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлууллаа.
137. Монгол цэргийн өдрийг тохиолдуулан 2017 оны 03 дугаар сарын 19-нд Онцгой байдлын байгууллага хоёр дахь цэргийн дээд цолтноо хүлээн авав. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар ОБЕГ-ын тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга Г.Ариунбуян “Бригадын генерал” цол хүртсэнээр Онцгой байдлын байгууллагаас төрөн гарсан хоёр дахь цэргийн дээд цолтон болсон юм.
138. 2017 онд Тулгар төрийн 2226 жил, Их Монгол Улс байгуулагдсаны 811 жил, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 106 жил, Ардын хувьсгалын 96 жилийн ой, Үндэсний их баяр наадмыг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 179 дүгээр зарлигаар Онцгой байдлын ерөнхий газрын дарга, бригадын генерал Т.Бадрал тус албанаас төрсөн анхны “Хошууч генерал” цолтон болов.
139. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн “Цэргийн дүрэмт хувцас, цол, ялгах тэмдгийг загварыг батлах тухай” 81 дүгээр зарлигаар Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын дүрэмт хувцасны загварыг шинэчлэн баталж, 2005 оны 130, 2014 оны 111 дүгээр зарлигийг хүчингүй болгожээ. Энэ өөрчлөлтөөр алба хаагчдын хээрийн хувцас өнгөлөн далдлалтын өнгөтэй болж, мөрдэсний загвар бусад цэргийн байгууллагуудтай ижил боловч өөрийн өнгөөр ялгарахаар батлагдсан.
140. Онцгой байдлын ерөнхий газар 2017 оноос эхлэн Швейцарийн хамтын ажиллагааны байгууллага, БНХАУ-ын Газар хөдлөлтийн байгууллагатай хамтран Үндэсний эрэн хайх, аврах чадавхыг дээшлүүлэх төслийг хэрэгжүүлж эхлээд байна.
141. Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор “Аврагч” спорт хороог “Аврагч” спорт биеийн тамир техник-спорт хороо болгон өргөжүүлэв.
142. Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 192 дугаар тогтоолоор Орхон аймгийн Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах, аврах 68 дугаар анги, Хөвсгөл аймгийн Гал түймэр унтраах, аврах 69 дүгээр анги, Ховд аймгийн Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах, аврах 70 дугаар ангийг байгуулав.
143. БСШУС-ын сайдын 2017 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн А/103 дугаар тушаалаар 2017-2018 оны хичээлийн жилээс эхлэн “Гамшгаас хамгаалах менежментийн үндэс” хичээлийг их, дээд сургуулиудын заавал судлах суурь хичээлийн хөтөлбөрт орууллаа.
144. ОБЕГ-ын харьяа Хүнсний нөөцийн салбар 2017 онд “ISO 9001:2015” олон улсын стандартын удирдлагын системийн тогтолцоог нэвтрүүлээ.
145. 2017 оны 09 дүгээр сарын 25-наас 10 дугаар сарын 01-ний өдрүүдэд Турк улсын Измир хотноо зохион байгуулагдсан Гал унтраах техникийн олон төрөлт спортын Дэлхийн аварга шалгаруулах 13 дахь удаагийн тэмцээнээс Онцгой байдлын байгууллагын баг тамирчид анхны хүрэл медалиа хүртэж, түүхэн амжилтын эзэд боллоо.
146. Эрэлч нохойн алба нь Нийслэлийн Онцгой байдлын газрын Хан-Уул дүүргийн Онцгой байдлын

- хэлтсийн Гал түймэр унтраах, аврах 65 дугаар ангийг түшиглэн байгуулагдаж 2017 оны 09 дүгээр сарын 20-нд нээлтээ хийлээ.
147. Гамшгийн шуурхай удирдлага, Зарлан мэдээллийн төв сүүлийн үеийн дэвшилтэт технологи бүхий холбоо, зарлан мэдээллийн тоног төхөөрөмжийн шинэчлэлийг бүрэн хийж, Үндэсний болон бүсийн төвүүдийг байгуулан 2017 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр албан ёсны нээлтээ хийлээ.
148. 2017 оны 10 дугаар сарын 22-ны өдөр Завхан аймгийн Отгон сумын нутаг дэвсгэр “Отгонтэнгэр” ууланд 27 хүний бүрэлдэхүүнтэй баг авиралт хийгээд буух явцад цасны хавтангийн гулгалт үүсч 17 хүн осолдов.
149. ОБЕГ-ын даргын 2018 оны 01 дүгээр сарын 05-ны А/12 дугаар тушаалаар “Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр, төлөвлөгөө” /2018-2022/-г батлав.
150. Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 355 дугаар тогтоолоор “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги (2017-2030)”-ийг батлуулав.
151. “Онцгой байдлын удирдлагын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Онцгой байдлын ерөнхий газар, Бүгд Найрамдах Турк Улсын Гамшиг, онцгой байдлын удирдлагын газар хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”-т 2018 оны 02 дугаар сарын 05-ны өдөр гарын үсэг зурлаа.
152. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 41 дүгээр тогтоолоор “Дүрэмт хувцасны эдэлгээний хугацаа”-г шинэчлэн батлуулж, Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 123 дугаар тогтоолыг хүчингүй болгожээ.
153. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 40 дүгээр тогтоолоор “Гамшгаас хамгаалах улсын хяналтын дүрэм”-ыг батлав.
154. Монгол Улсын Ерөнхий сайдаар тэргүүлсэн Гамшгийн эрсдэлийг бууруулах Үндэсний зөвлөлийг Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 63 дугаар тогтоолоор байгуулав.
155. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 67 дугаар тогтоолоор “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам”-ыг батлууллаа.
156. Зэвсэгт хүчний 97 жилийн ой, Монгол цэргийн өдрийг тохиолдуулан 2018 оны 03 дугаар сарын 16-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Онцгой байдлын ерөнхий газрын Ахмадын холбооны тэргүүн, бэлтгэл комиссар Д.Хишигбаатар Үйлчилгээний гавьяат ажилтан цолоор шагнууллаа.
157. Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018 оны А/397 дугаар тушаалаар “Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын бие бялдрын бэлтгэлжилтийн норматив”-ыг батлав.
158. 2018 оны 04 дүгээр сард “Монгол Улсын Онцгой байдлын ерөнхий газар, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн яам хоорондын санамж бичиг” байгууллаа.
159. Онцгой байдлын ерөнхий газраас БСШУСЯ, Боловсролын хүрээлэн, Багшийн мэргэжил дээшлүүлэх институттэй хамтран “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийг боловсруулж, БСШУС-ын сайдын 2018 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн А/181 дүгээр тогтоолоор батлуулан 2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулиудад хэрэгжүүлж байна.
160. 2018 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн Монгол Улсын Засгийн газрын өргөтгөсөн хуралдаанаар Онцгой байдлын ерөнхий газрын харъяа Аврах тусгай анги, Уул уурхайн аврах анги, Хангалт үйлчилгээний ангийг нэгтгэн Үндэсний аврах бригад болгох төсөл дэмжигдэж, 114 дүгээр тогтоолоор Үндэсний аврах бригадыг байгууллаа.
161. Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, олон нийтийн оролцоотой гамшгийн эрсдэлийг бууруулах нөхцлийг бүрдүүлэх, гамшгийн үеийн удирдлагын системийг нэвтрүүлэх зорилгоор Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн Б/442 дугаар тушаалаар Гамшгийн шуурхай удирдлага зарлан мэдээллийн төвийн бүтцэд “Орон зайн мэдээлэл, технологийн тасаг”-ийг байгуулав.
162. Үндэсний аврах бригадын тугийг 2018 оны 06 дугаар сарын 20-ны өдөр гардуулж өгөв.
163. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 114 дүгээр тогтоолоор Хэнтий аймгийн Онцгой байдлын газрын Бор-Өндөр сумын Гал унтраах, аврах 49 дүгээр ангийг Онцгой байдлын хэлтэс болгон өргөтгөж, Баян-Өлгий аймгийн Цэнгэл суманд Гал унтраах, аврах 71 дүгээр анги, Дэлүүн суманд Эрэн хайх, аврах бүлэг, Баянхонгор аймгийн Бууцагаан суманд Гал унтраах, аврах 72 дугаар анги, Баянговь суманд Эрэн хайх, аврах бүлэг, Төв аймгийн Мөнгөнморьт суманд Гал унтраах, аврах 75 дугаар анги, Баян суманд Эрэн хайх, аврах бүлэг, Лүн суманд Эрэн хайх, аврах бүлэг, Хөвсгөл аймгийн Цагаан-Уул суман Гал унтраах, аврах 73 дугаар анги, Нийслэлийн Онцгой байдлын газрын Сүхбаатар дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гал унтраах, аврах 74 дүгээр ангийг байгуулахаар шийдвэрлэлээ.
164. Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах газар, Онцгой байдлын ерөнхий газартай хамтран Улаанбаатар хотноо Гамшгийн эрсдэлийг бууруулах Азийн сайд нарын бага хурлыг 2018 оны 07 дугаар сарын 03-06-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Гамшгийн эрсдэлийг

- бууруулах Азийн сайд нарын хуралд Ази, Номхон далайн 50 улс орны өндөр дээд түвшний төлөөлөгчид, нийт 3500 гаруй зочид төлөөлөгч оролцов.
165. 2018 оны 08 дугаар сард Дорноговь аймгийн Айраг сумын нутаг дэвсгэр дэх төмөр замын 747 дахь километр (Цомог-Айраг өртөө хооронд)-т төмөр замын суурь бүтэц үерийн усанд автсанаас Улаанбаатар-Сайншанд чиглэлийн 328 зорчигчтой галт тэрэгний цуваа осолдов.
166. Монгол Улсын Шадар сайдын санаачлагаар Хөвсгөл нуурын ай сав бүхий цогцолборт газрыг түшиглэн байгуулагдсан Давтан сургалт, сэргээн заслын төвийн харьяа “Гүний усны сургалтын төв” 2018 оны 08 дугаар сарын 18-ны өдөр нээлтээ хийлээ.
167. Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 271 дүгээр тогтоолоор “Гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах” журам батлагдав.
168. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 31-ний 327 дугаар тогтоолоор “Гамшгийг тодорхойлох шалгуур үзүүлэлт, гамшгийн зэрэглэлийг тогтоох журам”-ыг батлууллаа.
169. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 357 дугаар тогтоолоор “Галын аюултай бүтээгдэхүүн, гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмжийг улсын хилээр нэвтрүүлэх болон үйлдвэрлэх, борлуулах, тээвэрлэх, хадгалах, устгах журам”-ыг батлав.
170. Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 118 дугаар тушаалаар “Онцгой байдлын байгууллагын алба хаагчид онцгой гавьяа байгуулсан тохиолдолд мөнгөн урамшуулал олгох журам”-ыг батлууллаа.
171. Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд 2006 оны 104 дүгээр тогтоолоор батлагдсан журмыг шинэчлэн, улмаар 2018 оны 12 дугаар сарын 19-ний Засгийн газрын хуралдаанаар Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын албан ажлын онцгой нөхцлийн нэмэгдлийг албан тушаалын сарын үндсэн цалингийн 20 хувиар тооцож олгохоор шийдвэрлэлээ.
172. Гамшгаас хамгаалах тухай хуульд заасны дагуу “Онцгой байдлын байгууллагын алба хаагчдад мэргэшлийн зэрэг, зэргийн нэмэгдэл олгох журам”-ыг Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 374 дүгээр тогтоолоор батлууллаа.
173. Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 24 дүгээр тушаалаар “Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны нийтлэг журам”-ыг шинэчлэн батлав.
174. Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 120 дугаар тушаалаар “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар”-ыг шинэчлэн батлав.
175. 2018 онд Монгол Улсын гамшгаас хамгаалах төрийн бодлого, хөтөлбөр, үйл ажиллагаа, гамшгийн нөхцөл байдал, түүний талаарх үнэлэлт, дүгнэлтийг бодит байр сууринаас тодорхой баримтад тулгуурлан олон нийтийн оролцоог хангах, салбар хоорондын хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор анх удаа гамшгаас хамгаалах “Цагаан ном”-ыг гаргалаа.
176. 2018 онд Улаанбаатар хот дахь Шатахууны болон Улсын нөөцийн Объект №03 салбарууд “ISO 9001:2015” стандартын удирдлагын системийн тогтолцоог нэвтрүүллээ.
177. Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний баярын өдрийг тохиолдуулан 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Үндэсний аврах бригадын тэргүүн ахлагч Ж.Баяртогтох “Үйлчилгээний гавьяат ажилтан” цол хүртэж, ажил үүргээ гүйцэтгэж байгаа аврагчдын дундаас энэхүү эрхэм цолыг хүртсэн залуу гавьяат гэдгээрээ Онцгой байдлын байгууллагын түүхэнд нэрээ мөнхөллөө.
178. Монгол түмний уламжлалт сар шинийн баярыг тохиолдуулан 2019 оны 02 дугаар сарын 03-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Онцгой байдлын байгууллагын ахмад ажилтан, Монгол Улсын гавьяат багш, улсын арслан Л.Сосорбарамыг “Ардын багш” цолоор шагнасан юм.
179. 2019 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр Төв аймгийн Жаргалант сумын нөөцийн салбарыг түшиглэн Монгол Улсын Засгийн газар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 1,2 тэрбум төгрөгийн дэмжлэгтэйгээр байгуулсан Улсын нөөцийн төвийн “Тэжээлийн үйлдвэр” нээлтээ хийлээ.
180. 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдөр Гамшгийн эрсдэлийг бууруулахад төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх зорилгоор Онцгой байдлын ерөнхий газар, Монголын даатгалын холбоотой хамтран ажиллах Санамж бичгийг байгууллаа.
181. 2019 оны 02 дугаар сарын 28-ны өдөр “Эко-Алтан Заамар” ХХК-ийн ашигт малтмалын олборлолтын 100 метр өргөн, 80 метрийн гүнтэй ил уурхайд нуралт болж зургаан хүн, КАТ-374 загварын эксковатор, КАТ-D-8-T загварын бульдозер дарагдсан осол гарав.
182. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 116 дугаар тогтоолын дагуу Онцгой байдлын ерөнхий газар, нийслэлийн Засаг даргын Тамгын газар хамтран 2019 оны 04 дүгээр сарын 24-27-ны өдрүүдэд нийслэлийн хэмжээнд гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг зохион байгууллаа. Энэхүү дадлага сургууль нь сүүлийн 29 жилийн хугацаанд нийслэлийн иргэдийг бүхэлд нь хамруулан зохион байгуулагдсан сургууль гэдгээрээ онцлог юм.

*Цуцаж үзээгүй Жигүүртэй
Цуцлах эрхгүй тангарагтай
Тайван цагийн энхийн харуул билээ
Тангараг өргөсөн мөнхийн зүтгэл билээ*

